

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 4



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 4

Улаанбаатар хот
2020 он

ННА 67.404
ДАА 347
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 4

Эмхэтгэлийг хянан тохиолдуулсан:

Т.Мэндсайхан, Хууль зүйн доктор (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн Дэд профессор
Ц.Давхарбаяр, Хууль зүйн доктор (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн Дэд профессор
Д.Энхзул, Хууль зүйн ухааны магистр (LL.M), МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш
П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд
Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг
шууд илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9645-4-2

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

АГУУЛГА

Өмнөх үг	4
Улсын дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлд хийсэн дүн шинжилгээ	5
Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтын талаарх судалгаа (Шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн дүн шинжилгээ)	85
Нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардал хуваарилахтай холбоотой шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын шинжилгээ (Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ)	157

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах, шүүгчийн шийдвэрийн ил тод байдал, чанарыг сайжруулах, хуулийн хэрэглээг нэг мөр болгоход хувь нэмэр оруулах зорилгоор шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх хараат бус судлаачидтай хамтран ажиллаж ирлээ.

2018 оноос хойш нийтэлж эхэлсэн цуврал эмхэтгэлийн дөрөв дэх болох энэ удаагийн дугаарт иргэний шүүхийн практикийг судалсан сонирхолтой гурван тайланг багтаан Та бүхэнд хүргэж байна. Монгол Улсын Засгийн газраас иргэний эрх зүйн хүрээнд хийх хууль тогтоомжийн шинэчлэлийг хууль зүйн салбарын шинэтгэлийн бодлогын нэг чухал чиглэл хэмээн тодорхойлсон энэ цаг үед иргэний шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой эдгээр судалгаа нь бодлого боловсруулагчдын хувьд ач холбогдол бүхий гэж найдаж байна.

Улсын дээд шүүхээс хэргийг анхан шатны шүүхэд буцаах, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой үүссэн хохирлыг барагдуулах болон сууц өмчлөл, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалт үйлчилгээний төлбөртэй холбоотой маргаан зэрэг иргэдийн амьдралд нийтлэг тохиолдох асуудлыг хөндсөн тул уг тайлангуудыг шүүгчид, хуульчдаас гадна жирийн иргэд ч сонирхон унших боломжтой.

Шүүхийн шударга, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд судалгаа шинжилгээний ажил чухлын зэрэгцээ уншигч, хэрэглэгчдийн шүүмж, оролцоо нэн шаардлагатай тул санал бодлоо харамгүй хуваалцахыг хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ШҮҮХИЙН ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ
ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН
ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БУЦААСАН ҮНДЭСЛЭЛД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Хонгорзул (LL.M)

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын
хүрээлэнгийн судлаач-багш

Н.Норовсамбуу (LL.M)

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш

АГУУЛГА

1.	УДИРТГАЛ	8
2.	ДЭЭД ШҮҮХЭЭС ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БУЦААЖ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ	10
2.1.	Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	10
2.2.	Хавтаст хэрэгт хийсэн дүн шинжилгээ	12
2.2.1.	№3180 дугаартай хавтаст хэрэг	12
2.2.2.	№1001 дугаартай хавтаст хэрэг	27
2.2.3.	№2586 дугаартай хавтаст хэрэг	33
2.2.4.	№8476 дугаартай хавтаст хэрэг	42
3.	ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА	50
3.1.	Япон Улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон судлах шалтгаан	50
3.2.	1996 оны Иргэний процессын хуулийн шинэчлэл	51
3.3.	Урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх хууль зүйн зохицуулалт	54
3.4.	Урьдчилсан хэлэлцүүлгээс бусад хууль зүйн зохицуулалт, шүүхийн практик	61
3.4.1.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дундын хурал	61
3.4.2.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөлт	62
3.4.3.	Шүүгчийн тодруулах эрх	63
3.4.4.	Шүүгчийн тодруулах эрхийн хэмжээ хязгаар	64
3.4.5.	Шүүгч дотоод итгэл үнэмшлээ ил болгох хэрэгцээ шаардлага	66
3.4.6.	Шүүгчийн мэдэгдэх үүрэг	67
4.	ДҮГНЭЛТ, САНАЛ	68
	ХАВСРАЛТ	72
	Ашигласан эх сурвалж	83

ТАЛАРХАЛ

Нээлттэй Нийгэм Форумаас тус судалгааны ажлыг дэмжин санхүүжүүлсэнд, мөн хавтаст хэргийг судалгааны ажилд ашиглуулах бололцоо олгосон Шүүхийн төрөлжсөн архивын хамт олонд гүн талархал илэрхийлье.

Судалгааны баг

1. УДИРТГАЛ

Монгол Улсын шүүн таслах ажиллагааны дийлэнх хувийг иргэний хэрэг эзэлдэг бөгөөд шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй иргэний хэрэг гурван шатанд өссөн дүнтэй байгааг доорх хүснэгтээс харж болно. Ийнхүү жил бүрийн шүүхийн статистикийн тайланг харахад иргэний хэргийн шүүхийн ажлын ачаалал байнга өндөр байна.

Хүснэгт 1. Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо

Шүүхийн шат	2013	2014	2015	2016	2017	2018	2019
	он	он	он	он	он	он	он
Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг	35314	33996	40674	46173	45233	48155	43397
Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг	1837	1947	2519	3108	3721	3527	3082
Хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг	759	841	1155	1469	1704	1932	1332

Эх сурвалж: Монгол Улсын шүүн таслах ажиллагааны тайлан 2013-2019 он

Үүний сацуу анхан шатны шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдал нэлээд суларсан нь шүүхийн статистикаас ажиглагдаж байна. Шүүхийн статистикийн тайлангаас үзэхэд, давж заалдах шатны шүүх нь иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн 25-30 орчим хувийг, хяналтын шатны шүүх иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалын 10-15 орчим хувийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаажээ.

Хэргийг хүчингүй болгож, дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах тухай 7 үндэслэлийг ИХШХШТХ-ийн 168-р зүйлийн 168.1-д заасан. Үүнд: (i) Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй (168.1.1), (ii) Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн (168.1.2), (iii). Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн (168.1.3), (iv) Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан

шийдвэрлэсэн (168.1.4), (v) Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан (168.1.5), (vi) Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн (168.1.6), (vii) Энэ хуулийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг шийдвэрлэсэн (168.1.7) зэрэг болно. Эдгээр үндэслэлээс практикт 168-р зүйлийн 168.1.1-168.1.3, 168.1.7-оор хэргийг хүчингүй болгосон нь давамгайлах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэсэн үндэслэл мөн өндөр хувийг эзэлдэг.

Иймд энэхүү судалгаагаар дээрх түгээмэл үндэслэлүүд дотроос шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг шийдвэрлэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдсөн гэх ямар бодит тохиолдлууд шүүхийн практикт гарч буйг хяналтын шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалд түүвэр судалгаа хийх замаар тодруулахыг зорилоо.

Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрт материаллаг хууль хэрэглээний дүн шинжилгээ хийх бус тухайн иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлал хүчингүй болоход процесс хуулийн ямар алдаа, зөрчил давамгайлж буй, эдгээр алдаа зөрчил гарч, хэргийн оролцогчдын хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдөхөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчийн хайнга, хариуцлагагүй байдал нөлөөлсөн эсэх, эсхүл шүүн таслах ажиллагааг удирдан явуулж буй шүүгчийн хариуцлагагүй, буруутай үйл ажиллагаа нөлөөлж байна уу гэдгийг тогтоох нь судалгааны ажлын нэг зорилт байв. Үүний үндсэн дээр холбогдох гадаад орны сайн туршлагатай харьцуулсан судалгаа хийх замаар процессын хуулийн алдаа, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга, механизмыг судалж, шүүхийн шийдвэрийн чанар тогтвортой байдлыг сайжруулах арга замыг санал болгоход энэхүү судалгааны зорилго оршино.

Энэхүү судалгааны хүрээнд 2015 онд Дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 107 хэргийн тогтоолын үндэслэлийг судалж, алдаа зөрчлийн тоймыг ангилна. 2015 оны хэргийг сонгон авсан нь эдгээр хэрэг нь одоогоор эцэслэн шийдвэрлэгдэж, хавтаст хэрэг нь

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Шүүхийн төрөлжсөн архивд хадгалагдаж байгаа тул хавтас хэргийн судалгааг хийхэд тохиромжтой байсан юм.

2. ДЭЭД ШҮҮХЭЭС ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БУЦААЖ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2.1. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Судалгааны хүрээнд 2015 онд Улсын дээд шүүх (УДШ)-ээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан нийт 107 тогтоолд дүн шинжилгээ хийлээ. Шинжилгээ хийхдээ буцаасан үндэслэлүүдийг багцалж, дараах 3 төрөлд ангилсан болно. Үүнд:


1. Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
3. Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй зэрэг орно.

ИХШХШтХ-ийн 116-р зүйлийн 116.2 дахь хэсэгт “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэж заасан бөгөөд энэ заалт ёсоор хууль ёсны байх гэдэгт материаллаг болон процесс хуулиа зөв зохистой хэрэглэх хамаарах ба, үндэслэл бүхий байх гэдэгт хэргийн нөхцөл байдал, үйл баримтыг бүрэн, зөв тогтоохыг ойлгоно.

Иймд “Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй” гэдэгт шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангаагүй буюу материаллаг хуулийг буруу хэрэглэсэн алдаануудыг, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” гэдэгт ИХШХШтХ-ийг зөрчсөн тохиолдлуудыг, “Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй” гэдэгт шүүхийн шийдвэр үндэслэл бүхий болоогүй буюу хэргийн нөхцөл байдал, үйл баримтыг үнэн зөв, бүрэн тогтоогоогүй тохиолдлуудыг тус тус хамаарууллаа.

Нийт сонгон авсан 107 хэргийн хувьд авч үзвэл, эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй 19, хэргийн үйл баримтыг бүрэн тогтоогоогүй 70, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн алдаа 76 гарсан байна.

График 1. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл



Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлээс Иргэний хэрэг хянан шалгах ажиллагаа (ИХХША)-ны журам зөрчсөн үндэслэлүүдийг дэлгэрүүлж авч үзвэл дараах нийтлэг алдаа, зөрчил гарч байна.

Хүснэгт 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдол

№	АЛДАА, ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ
1	Хэргийн оролцогчдын эрх зүйн байдал тодорхойгүй
2	Шүүхэд төлөөлөх бүрэн эрх тодорхой бус
3	Гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн
4	Иргэний хэрэг үүсгэх урьдчилсан нөхцөл бүрдээгүй
5	Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг тодруулаагүй
6	Зохигчдод эрх, үүргийг тайлбарлан өгөх журам зөрчсөн
7	Зохигчийн эрх, үүргийг зөрчсөн
8	Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийг гардуулах журам зөрчсөн
9	Хэргийн материалтай танилцуулах журам зөрчсөн
10	Шүүх хуралдааны тов мэдэгдэх журам зөрчсөн
11	Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт шийдвэрлэх журам зөрчсөн
12	Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг гардуулах, хүргүүлэх, мэдэгдэх журам зөрчсөн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

13	Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах журам зөрчсөн
14	Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
15	Нотлох баримт гаргах, цуглуулах журам зөрчсөн
16	Нотлох баримт бүрдүүлэх журам зөрчсөн
17	Нотлох баримт шинжлэн судлах журам зөрчсөн
18	Нотлох баримт үнэлэх журам зөрчсөн
19	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн
20	Хэрэг нэгтгэх, тусгаарлах журам зөрчсөн
21	Нэхэмжлэгч, хариуцагчийг солих журмыг зөрчсөн
22	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн нь үндэслэлгүй
23	Шүүх хуралдааны тэмдэглэл зохих шаардлагыг хангаагүй

Эдгээр тохиолдлоос хамгийн суурь асуудал нь “Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг тодруулах ажиллагаа” хийхгүйгээр хэргийг шийдэж буй явдал юм. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхой байж сая хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдахын зэрэгцээ хэргийн үйл баримтыг бүрэн тогтоох, эрх зүйн харилцааг зөв тодорхойлох үндэс бүрдэнэ.

2.2. Хавтаст хэрэгт хийсэн дүн шинжилгээ

Шүүхийн практикт түгээмэл шийдэгддэг түрээс, зээлийн гэрээтэй холбоотой хэргийг сонгон авч, хавтаст хэрэгт нь нарийвчилсан судалгаа хийсэн. Ингэснээр тухайн маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал, УДШ-ээс хүчингүй болгож, дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл, хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа, шүүх хуралдааны хойшилсон үндэслэлүүд гэх мэт тухайн хэргийг хүлээн авснаас эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх бүх процесс ажиллагааг судалж, алдаа зөрчилд нь дүн шинжилгээ хийхийг зорьсон юм.

2.2.1. №3180 дугаартай хавтаст хэрэг

Нэхэмжлэгч: “Г” ХХК

Хариуцагч: Э.Д

Хэргийн товч утга: Түрээсийн төлбөр 15,635,000 төгрөг гаргуулахыг шаардсан үндсэн нэхэмжлэлтэй, хохиролд 15,000,000 төгрөг гаргуулахыг шаардсан сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэрэг

Хэрэг шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа:

2015.05.11-2016.04.19 (11 сар)

Хэргийн агуулга: Нэхэмжлэгч “Г” ХХК нь үл хөдлөх эд хөрөнгө түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд гараашийн зориулалттай 665 м.кв талбайг 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хариуцагч Э.Д-тэй гэрээ байгуулан түрээслүүлж байгаад уг түрээсийн гэрээний хугацаа 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр дуусаж, шинээр гэрээ байгуулсан нь (ХХ-ийн 39 дэх тал) шүүхэд нэхэмжлэл гаргахад хавсаргасан 2014 оны 5 дүгээр сарын 1-ний өдөр хариуцагч Э.Д-тэй байгуулсан түрээсийн гэрээ гэж ойлгогдохоор байна (ХХ-ийн 5 дахь тал). Нэхэмжлэгч 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2014 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацааны түрээсийн төлбөр 10,400,000 төгрөг, мөн хариуцагч гарааш түрээсэлж машин тавьдаг жолооч нараас жилийн урьдчилгаанд авсан 5,235,000 төгрөг нийт 15,635,000 төгрөгийг Э.Д-ээс нэхэмжилсэн.

Хариуцагч тайлбартаа 2014 оны 4 дүгээр сард “Г” ХХК-ийн захирал Н.А нь хариуцагч Э.Д-ийг өрөөндөө дуудаад дулаан гараашийн болон ил зогсоолын хаалгуудыг солиулж, үүнийгээ түрээсийн төлбөрөөс хасаж тооцохоор амаар тохиролцсон (гэхдээ энэ талаар гаргаж өгөх ямар ч нотлох баримт байхгүй гэж мэдүүлсэн. ХХ-ийн 40 дэх тал). Хариуцагч Э.Д нь ил зогсоолын хаалгыг 1,100,000 төгрөгөөр, дулаан гараашийн хаалгыг 3,500,000 төгрөгөөр суурилуулсан (нотлох баримтаар нотлогдож байгаа). Нэхэмжлэгч нь 2014 оны 9 дүгээр сард урьдчилан мэдэгдэлгүйгээр түрээсийн гэрээг цуцалсан нь ид ашиг орлогын үеэр хууль бусаар гэрээг цуцалсанд тооцогдох тул гомдолтой байна. Иймд гэрээний хугацаа дуусах хүртэлх үеийн буюу 9, 10, 11, 12 дугаар саруудад олох ёстой байсан цэвэр ашиг болох сарын 2,500,000 төгрөгөөр бодоход нийт 4 сард 10,000,000 төгрөг болно (цэвэр ашиг олсон баримт байхгүй гэж мэдүүлсэн. ХХ-ийн 40 дэх тал). Мөн хамгаалагчийн цалинд нэг хүний сарын 450,000 төгрөгөөр 3 хүнд цалин олгосон 1,350,000 төгрөг, нийт 15,000,000 төгрөгийн сөрөг нэхэмжлэл гаргасан (ХХ-ийн 29 дэх тал, уг нь нийлбэр дүн 15,950,000 төгрөг болсон).

Нэхэмжлэгч тайлбартаа түрээсийн гэрээний үүргийг биелүүлээгүй тул түрээсийн гэрээг цуцалсан гэж үзэж, хохирол нэхэмжилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Харуул хамгаалалтын албыг бид авчирч объектыг хамгаалуулаагүй. Манайх харуул хамгаалалтын албатай. Ил

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зогсоолын хаалга хийлгэсэн нь түрээслэгч өөртөө амар хялбар болгох гэж л хийсэн. Дулаан гараашийн хаалгыг хариуцагч түрээсэлж байх хугацаандаа ашиглаж, ашиглалтын явцад эвдэрсэн учраас сольсон байдаг гэж маргажээ (ХХ-ийн 40 дэх тал).

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.07.27 №04663)**

Зохигчдын хооронд 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдөр түрээсийн гэрээ байгуулагдсан болох нь шүүхэд гаргасан нэхэмжлэгч, хариуцагч нарын тайлбар, түрээсийн гэрээ гэсэн баримтуудаар тогтоогдож байна. Хариуцагч Э.Д нь 2014 оны 9 дүгээр сар хүртэлх түрээсийн төлбөрт 10,400,000 төгрөгийг төлөх үлдэгдэлтэй болох нь шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдож байгааг дурдаад түрээсийн төлбөрт 10,400,000 төгрөг төлөхийг зөвшөөрсөн “Г” ХХК-ийн захиргаанд 2014 оны 9 дүгээр 10-ны өдөр гаргасан хариуцагч Э.Д-ийн хүсэлт гэсэн баримтуудаар тогтоогдсон гэж шүүх дүгнэжээ.

Нэхэмжлэгч нь хариуцагч Э.Д-ийг гараашийг түрээслэгч хувь иргэдээс урьдчилж 5,235,000 төгрөг авсан гэж нэхэмжилдэг боловч тайлбарыг нотолсон баримтгүй тул хариуцагч Э.Д-ээс 10,400,000 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч “Г” ХХК-д олгож, үлдэх 5,235,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлээр хохиролд 15,000,000 төгрөгийг шаардсан боловч дулаан гарааш, ил зогсоолын хаалганы үнийг түрээсийн төлбөрөөс хасаж тооцохоор талуудын хооронд байгуулагдсан түрээсийн гэрээний 7.3-т зааснаар гэрээнд бичгийн хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулаагүй, олох байсан ашгийг нотолсон баримтгүй, хамгаалагчийн цалинг түрээслүүлэгч төлөх талаар гэрээгээр тохиролцоогүй шаардлага нь бичгийн баримтаар тогтоогдохгүй байх тул сөрөг нэхэмжлэлийг хангах үндэсгүй байна. Гэвч нэхэмжлэгч нь сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас гадна ил зогсоолын хаалгыг хариуцагчид өгөхийг зөвшөөрсөн тул 1,100,000 төгрөг буюу гадна ил зогсоолын хаалгыг гаргуулж, хариуцагчид олгож шийдвэрлэсэн байна.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.09.25 №1297)**

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.12.01 №1008)**

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн. Зохигчдын хооронд байгуулагдсан түрээсийн гэрээ хуульд заасан шаардлагыг хангасан хүчин төгөлдөр эсэхийг дүгнэхийн тулд гэрээний зүйл болох үл хөдлөх хөрөнгө нь өмчлөх болон эзэмших эрхийн бүртгэлд хэрхэн бүртгэгдсэн, тухайн эд хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түрээсэлсэн аль нь болохыг тодруулах шаардлагатай байсан гэж шүүх үзсэн.

Үүнээс гадна анхан шатны шүүх түрээсийн гэрээ хүчин төгөлдөр бус бол эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалтын дагуу үр дагаврыг шийдвэрлэх зарчим үйлчилнэ гэж дүгнэсэн нь хуулийг буруу тайлбарласан гэж үзнэ. Харин түрээсийн гэрээ хүчин төгөлдөр тохиолдолд Иргэний хуулийн 318.5-д заасан “энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний журам нэгэн адил үйлчилнэ” зохицуулалтыг хэрэглэнэ.

Шүүх түрээсийн 10,400,000 төгрөг нь аль хугацааны төлбөр болохыг, гэрээ цуцлах үндэслэл байсан эсэх, засаж сайжруулсны зардал гаргуулах зэрэг шаардлагын талаар хуульд нийцүүлэн дүгнэлт хийгээгүй байна. Иймд хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүйгээс хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй гэж дүгнэсэн.

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2016.04.19 №03180)**

Гэрээг байгуулсан талаар болон өмнө нь хариуцагч уг объектуудыг түрээсэлж байсан талаар зохигчид маргахгүй байгаа бөгөөд зохигчийн хооронд байгуулсан түрээсийн гэрээ нь Иргэний хуулийн 43.2.1, 196.1.2 дахь хэсгүүдэд заасан шаардлагыг хангасан хүчин төгөлдөр хэлцэл байна. Иргэний хуулийн 318.3, 318.4 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн газарт бүртгүүлэх, бүртгүүлээгүй гэрээг хүчин төгөлдөр бусад тооцохоор

заасан байх боловч түрээслүүлсэн объектыг бүхэлд нь түрээслэгчийн эзэмшил ашиглалтад шилжүүлээгүй, зөвхөн нэг хэсгийг түрээслэхээр тохиролцсон, гэрээ бодит байдлаар хэрэгжсэн байх тул талуудын хооронд 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан түрээсийн гэрээ нь хүчин төгөлдөр байх үндэслэлтэй гэж үзсэн.

Иргэний хуулийн 318.5 дах хэсэгт түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний журам нэгэн адил үйлчлэхээр зохицуулсан, мөн хуулийн 294.2, 294.2.1 дэх хэсгүүдэд хүндэтгэн үзэх дараах шалтгаанаар буюу нэг тал нь үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй гэм буруутай бол нөгөө талын санаачилгаар гэрээг цуцлахаар тус тус заасан байх бөгөөд талуудын хооронд байгуулсан гэрээний 2.3, 2.4, 5.1.2 дахь хэсгүүдэд тохиролцсоноор нэхэмжлэгч компани гэрээг цуцалж, төлбөрийн үлдэгдлийг шаардсан нь үндэслэлтэй гэж дүгнэсэн.

Нэхэмжлэгчийн түрээсийн төлбөрт шаардсан 10,373,800 төгрөгийн шаардлагыг нотолсон баримт болох хариуцагчийн авлагын дэлгэрэнгүй гүйлгээ гэх баримтаас үзэхэд 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан гэрээнээс өмнөх буюу 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар үүссэн төлбөр гэх 2,600,000 төгрөгийг нэхэмжлэлийн нийт шаардлагаас хасаж тооцох үндэслэлтэй ба энэхүү өр төлбөр хэрхэн үүссэн талаар баримт хэрэгт авагдаагүй, нэхэмжлэгч тал нотлоогүй болно.

Нэхэмжлэгч нь хариуцагч Э.Д-ийг гарааш түрээслэгч иргэдээс 5,235,000 төгрөг авсан гэж тайлбарлан нэхэмжилсэн боловч шаардлагаа нотолсон баримтгүй тул энэхүү шаардлагад холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гээд хариуцагч Э.Д-ээс 7,773,800 төгрөг гаргуулан нэхэмжлэгчид олгож шийдвэрлэсэн байна.

Хариуцагч талаас сөрөг нэхэмжлэл гарган хохиролд 15,000,000 төгрөг шаардсан боловч дулаан зогсоолын хаалгыг өөрөө дур мэдэн сольсон, солих талаар түрээсийн гэрээний 7.3-т зааснаар бичгээр тохиролцоогүй, мөн гэрээгээр хамгаалагчийн цалингийн талаар тохиролцоогүй, шаардлага нь бичгийн баримтаар тогтоогдоогүй, гэрээний үүргийг зөрчсөнөөс түрээслүүлэгч хууль болон гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан тул олох ёстой байсан ашгийг шаардах эрхгүй байна.

Иргэний хуулийн 289.2.6 дахь хэсэгт хөлслөн авсан эд хөрөнгөд салгаж болох засан сайжруулалт хийсэн бол гэрээ дуусгавар болоход түүнийгээ салгаж авч болох талаар заасан бөгөөд түрээслэгч нь

автомашины ил зогсоолын хаалгыг өөрийн хөрөнгөөр шинэчлэн хийж гүйцэтгэсэн, түүний үнэ болох 1,100,000 төгрөгийг түрээслүүлэгч төлөхөөр хүлээн зөвшөөрсөн тул нэхэмжлэгч “Г” ХХК-иас гаргуулан хариуцагч Э.Д-т олгож, сөрөг нэхэмжлэлийн үлдсэн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хүснэгт 3. №3180 дугаартай хавтаст хэргийг шүүхэд хянан шийдвэрлэсэн ажиллагааны талаарх дүгнэлт

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015/06/09) Хариуцагч өмгөөлөгч авах хүсэлт гаргаснаар шүүх хурал хойшилсон.	Зохигч талууд хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэдий ч хариуцагч талын хувьд нэхэмжлэл болон холбогдох нотлох баримттай танилцсаны үндсэн дээр хариу тайлбар гаргаж, маргаж байгаа тул аль болох шүүх хурлын өмнө өмгөөлөгч авах эсэхээ шийдвэрлэсэн байх нь зохистой.
	Хурал № 2 (2015/06/22) Хариуцагчийн өмгөөлөгч сөрөг нэхэмжлэл гаргаж, гэрч асуулгах хүсэлт гаргаснаар шүүх хурал хойшилсон.	Хариуцагчийн өмгөөлөгч дараагийн шүүх хурал буюу 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс өмнө сөрөг нэхэмжлэл болон гэрч асуулгах хүсэлтээ гаргаж, нэхэмжлэгч болон шүүгчид урьдчилан танилцуулах нь зүйтэй. 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн шүүх хурал дээр нэхэмжлэгч сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзаж байгаа эсэхийг асууж, гэрч асуулгах нь энэхүү хэрэгт ямар ач холбогдолтой, ямар үйл баримтыг нотлуулах зорилготой эсэхийг тодруулах шаардлагатай байсан.
		Мөн энэхүү ажиллагаанаас өмнө үндсэн нэхэмжлэлийн шаардлага болон түүний хариу тайлбарын талаарх талуудын мэтгэлцээнийг өрнүүлж, тухайн хэргийн маргааны зүйлийг тогтоож, шаардлагатай нотлох баримтууд хэрэгт авагдсан эсэхийг хэлэлцэх нь чухал байсан.

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	<p>Хурал № 3 (2015/07/07) Түрээсийн гэрээнд түрээсийн төлбөрийн дүн байхгүйгээс хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардлагатай болсон тул шүүгч шүүх хурлыг хойшлуулсан.</p>	<p>Нэхэмжлэгч хариуцагчид хандан хоёр шаардлага гаргасан. Нэг нь хариуцагчаас 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2014 оны 9 дүгээр сарын 1 хүртэлх хугацааны түрээсийн төлбөр 10,400,000 төгрөг нэхэмжилсэн. Гэвч түрээсийн төлбөрийг тусгасан гэрээний хавсралт, хариуцагч нийт хэдэн сарын түрээсийн төлбөр төлсөн болон нийт хэдэн төгрөгийн өртэй болохыг нотолсон санхүүгийн баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй. Анх нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхой бичиж, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөөгүй нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй болгох тул шүүх энэ талаар нэхэмжлэгчид урьдчилан сануулж, нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхойлуулж, холбогдох шаардлагатай нотлох баримтуудыг гаргуулж авах шаардлагатай байсан. Энэ ажиллагааг хийгээгүйн улмаас шүүх хурал хойшилсон. Нөгөө шаардлага нь хариуцагч гарааш түрээсэлж машин тавьдаг жолооч нараас жилийн урьдчилгаанд авсан 5,235,000 төгрөгийг нэхэмжилсэн. Гэвч ямар хууль зүйн үндэслэлээр нэхэмжилж байгаа нь тодорхойгүй, холбогдох бичгийн нотлох баримтыг гаргаж өгөөгүй тул шүүх энэ талаар тодруулж, нотлох боломжгүй үйл баримт бол маргааны зүйлээс хасах нь зүйтэй байсан.</p>
	<p>Хурал № 4 (2015/07/27) Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан.</p>	<p>Хариуцагч Э.Д-ээс 10,400,000 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч “Г” ХХК-д олгож, үлдэх 5,235,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч нь сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас гадна ил зогсоолын хаалгыг хариуцагчид өгөхийг зөвшөөрсөн тул 1,100,000 төгрөгийг гаргуулж, үлдэх 13,900,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Давж заалдах шатны шүүх	<p>Хурал № 1 (2015/09/25) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.</p>	<p>Хариуцагчийн өмгөөлөгчийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолд анхан шатны шүүгчийг хууль зүйн үндэслэлгүйгээр, хий хоосон хардаж, шүүхийн шийдвэрийг буруутгасан хэсэг байсан. Гэхдээ нэхэмжлэгчийн нэхэмжилж буй үнийн дүнгийн талаар санхүүгийн баримт байхгүй, ямар баримтаар ийм хэмжээний мөнгө нэхэмжилж байгаа нь тодорхойгүй гэсэн тайлбар, хариуцагчийн гараар бичсэн өргөдлийг (нэхэмжлэгч нь хариуцагчид дарамт шахалт үзүүлж, өргөдөл бичүүлсэн байхыг үгүйсгэхгүй) шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосонд гомдолтой байгаа нь давж заалдах шатны шүүхээс хянан шалгах ёстой асуудал байсан гэж үзнэ.</p>
Дээд шүүх	<p>Хурал № 1 (2015/12/01) Дээд шүүхийн тогтоол гарсан. Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.</p> <p>Шүүх түрээсийн 10,400,000 төгрөг нь аль хугацааны төлбөр болохыг, гэрээ цуцлах үндэслэл байсан эсэх, засаж сайжруулсны зардал гаргуулах зэрэг шаардлагын талаар хуульд нийцүүлэн дүгнэлт хийгээгүй байна. Иймд хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүйгээс хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй гэж дүгнэсэн.</p>	<p>Дээд шүүхийн тогтоолын үндэслэлтэй санал нийлнэ.</p>

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Анхан шатны шүүх	Хурал № 1 (2016/02/25) Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн шүүх хурал давхацсан тул шүүх хурал хойшилсон. Хариуцагчийн өмгөөлөгч нэхэмжлэгчээс нэмэлт нотлох баримт гаргуулах, шинжээч томилуулах хүсэлт гаргасан.	Хариуцагч дараах нотлох баримтуудыг нэхэмжлэгчээс гаргуулахыг хүссэн. Үүнд (i) “Г” ХХК-ийн дулаан зогсоолын өмчлөх эрхийн гэрчилгээ, (ii) Хариуцагч Э.Д-ийн түрээсийн төлбөр төлж байсан баримт, (iii) Нэхэмжлэгчийн төлөөлөгчийн төлөөлөх бүрэн эрхийг нотолсон баримт, (iv) “Г” ХХК-ийн санхүүгийн тайланг гаргуулж, шинжээч томилуулан данс тооцооны үлдэгдэл, төлөгдсөн төлбөр зэргийг тодорхойлуулах хүсэлт гаргасан. Үүнээс шүүх 4 дэх нотлох баримтыг гаргуулах хүсэлтийг хангахгүй орхисон. Учир нь компанийн санхүүгийн тайланд өглөг, авлагын байдал нэг бүрчилсэн байдлаар тусгагддаггүй, уг тайланд үндэслэн хоёр этгээдийн түрээсийн төлбөрийн талаар тогтоох боломжгүй гэдгийг зөвхөн нэхэмжлэгч талын тайлбарт үндэслэсэн нь учир дутагдалтай байна. Энэхүү нотлох баримтыг шүүх хурлаар хэлэлцсэний дараа хэрэгт ач холбогдолтой эсэхийг нь шийдвэрлэх нь зүйтэй юм.
		Мөн хариуцагчийн өмгөөлөгч нь хэрэгт хамгийн их ач холбогдолтой нотлох баримт болох хариуцагч Э.Д-ийн түрээсийн төлбөр төлж байсан болохыг нотлох санхүүгийн баримтыг нэхэмжлэгч талаас гаргуулах хүсэлтийг ийм хожуу гаргасан нь үнэхээр хайнга бөгөөд шүүгчийн зүгээс хэргээ үнэн зөв шийдвэрлэхийн тулд энэ баримтыг талуудаас гаргуулахыг сануулах шаардлагатай байсан.
	Хурал № 2 (2016/03/10) Хариуцагчийн өмгөөлөгч нэхэмжлэгч талаас шүүх хуралдаанд гаргаж өгсөн баримтуудтай танилцаж тайлбар өгөх, мөн төлөөлүүлэгчтэйгээ зөвлөх боломжоор хангаж, шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан.	Шинээр нотлох баримт гаргаж байгаа тал нь товлогдсон шүүх хурлаас өмнө нотлох баримтыг хавтаст хэрэгт хавсаргах, нөгөө тал нь тэдгээртэй шүүх хурлын өмнө танилцаж, хариу тайлбараа бэлдсэн байвал зохино.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	<p>Хурал № 3 (2016/03/17) Хариуцагчийн өмгөөлөгч санхүү, мөнгөний холбогдолтой хэрэгт санхүүгийн шинжээч томилох хүсэлтийг шүүгч хангаагүйн улмаас ИХШХШТХ-ийн 91.1.3-г заасан үндэслэлээр шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргаж, шүүх хурлыг хойшлуулсан.</p>	<p>2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн шүүх хуралд хариуцагчийн өмгөөлөгч нь нэхэмжлэгчийн санхүүгийн тайланг гаргуулж, шинжээч томилуулах хүсэлтийг хангахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах боломжгүй байсан тул шүүгчээс татгалзсан байх магадлалтай. Тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй. Зохигчоос гаргасан хүсэлтийг шүүгч хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шийдвэрлэсэн байдлыг шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ гэж үзэхгүй юм гэж дүгнэсэн.</p>
	<p>Хурал №4 (2016/04/14) Нэхэмжлэгчийн өмгөөлөгч эрүүгийн шүүх хуралдаантай байгаа тул шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан.</p>	<p>Товлогдсон шүүх хуралд хүрэлцэн ирэх боломжгүй болсон бол түүнийгээ өмнө нь эсрэг тал болон шүүгчийн туслахад мэдэгдэх нь эсрэг талын шүүхэд ирэх цаг завьг хэмнэх, шүүгчийн туслахын ажлын зохион байгуулалтад тустай юм.</p>
	<p>Хурал № 5 (2016/04/19) Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан. Нэхэмжлэгчийн түрээсийн төлбөрт шаардсан 10,373,800 төгрөгийн шаардлагыг нотолсон баримт болох хариуцагчийн авлагын дэлгэрэнгүй гүйлгээ гэх баримтаас үзэхэд 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан гэрээнээс өмнөх буюу 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар үүссэн төлбөр гэх 2,600,000 төгрөгийг нэхэмжлэлийн нийт шаардлагаас хасаж</p>	<p>Нэхэмжлэгчийн шаардлага дахь өмнөх түрээсийн гэрээний түрээсийн төлбөрийн үлдэгдэл болох 2,600,000 төгрөгийг нотолсон баримт хэрэгт авагдаагүй тул нэхэмжлэлийн шаардлагаас хасаж шийдвэрлэжээ. Өмнө нь 3 шатны шүүхээр хянагдахад яагаад энэ асуудлыг анхаараагүй болох, нөгөө талаас нэхэмжлэгч холбогдох санхүүгийн баримтыг хожуу гаргаж өгсөнтэй холбоотой байж болох нь анхаарал татаж байв. Харуулын ажилчдад олгосон цалинг нэхэмжилсэн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг шинжлэн судлах шаардлагатай байсан.</p>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	тооцох үндэслэлтэй ба энэхүү өр төлбөр хэрхэн үүссэн талаар баримт хэрэгт авагдаагүй, нэхэмжлэгч тал нотлоогүй болно. Нэхэмжлэгч нь хариуцагч Э.Д-ийг гарааш түрээслэгч иргэдээс 5,235,000 төгрөг авсан гэж тайлбарлан нэхэмжилсэн боловч шаардлагаа нотолсон	
	баримтгүй тул энэхүү шаардлагад холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шийдсэн. Хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас ил зогсоолын хаалганы үнэ болох 1,100,000 төгрөгийг нэхэмжлэгч төлөхийг хүлээн зөвшөөрсөн тул хариуцагч Э.Д-д олгуулж шийдвэрлэсэн.	

Дүн шинжилгээ

Энэхүү хэрэг нь эрх зүйн харилцааны хувьд түрээсийн гэрээтэй холбоотой маргаан байсан. Нэхэмжлэгч хоёр шаардлага гаргасан бөгөөд нэг нь хариуцагч 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2014 оны 9 дүгээр сарын 1 хүртэлх хугацааны түрээсийн төлбөр болох 10,400,000 төгрөгийг төлж барагдуулах байв. Нөгөө нь хариуцагч гарааш түрээсэлж машин тавьдаг жолооч нараас жилийн урьдчилгаанд авсан 5,235,000 төгрөгийг төлөхийг шаарджээ.

Хариуцагч хариу тайлбартаа нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд гурван шаардлага бүхий сөрөг нэхэмжлэл

гаргажээ. Үүнд: 1-д 2014 оны 4 дүгээр сард “Г” ХХК-ийн захирал Н.А нь хариуцагч Э.Д-тэй дулаан гарааш болон ил зогсоолын хаалгыг солиулж, үүнийгээ түрээсийн төлбөрөөс хасаж тооцохоор амаар тохиролцсон тул суурилуулсан хаалганы нийт үнэд 4,500,000 төгрөг, 2-т нэхэмжлэгч түрээсийн гэрээг урьдчилан бичгээр мэдэгдэлгүй цуцалсан тул гэрээ цуцалснаас хойших гэрээний хугацаа дуусгавар болох хүртэлх олох ёстой байсан 4 сарын ашигт 10,000,000 төгрөг, 3-т түрээсийн гэрээнд хариуцагч харуул хамгаалалтыг хариуцахгүй байсан боловч харуул хамгаалалтын ажилтан авч ажиллуулсан бөгөөд тэдний цалинд олгосон 1,350,000 төгрөгийг шаардсан байна.

Энэ хэрэгт гарч байгаа эдгээр нийт таван шаардлагаас шүүгч болон зохигч, тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч нар хамтран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, үр нөлөөтэй явуулж, талуудын тайлбар, мэдүүлгээс маргаантай болон маргаангүй асуудлыг ялгаж, тухайн хэргийн маргааны зүйлийг олж тогтоосны дараа түүнд холбогдох нотлох баримт шинжлэн судлах ажиллагааг явуулж, хэргийг эцэслэн шийдвэрлэх ёстой.

Нэхэмжлэгчийн эхний шаардлага хангагдахын тулд эхлээд талуудын хооронд хүчин төгөлдөр түрээсийн гэрээ байгуулагдсан байх ёстой бөгөөд хариуцагч уг түрээсийн гэрээгээр хүлээсэн түрээсийн төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй тул нэхэмжлэгч түрээсийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, төлөгдөөгүй сарын түрээсийн төлбөрийг шаардаж байгааг нотлох шаардлагатай. Нэхэмжлэгчийн хувьд үүнийг нотлох боломжтой байсан тул түрээсийн төлбөрийн талаар тохирсон гэрээний хавсралт, хариуцагчийн түрээсийн төлбөр төлж байсныг нотлох баримт, хэддүгээр саруудад түрээсийн төлбөр төлөгдөөгүйг нотлох санхүүгийн баримтуудыг нэхэмжлэл гаргах үед эсхүл эхний шүүх хурлын үеэр гаргах байсан. Эдгээр баримт нь нэхэмжлэгчийн шаардлагыг нотлох хэрэгт чухал ач холбогдолтой баримт байтал нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа ч хэрэг хэлэлцэх эхний шүүх хурлын үеэр ч уг баримтуудыг авч ирээгүй. Шүүхийн зүгээс хэргийг үнэн зөв бөгөөд шуурхай шийдэхийн тулд нэхэмжлэгчийг эдгээр баримтаа гаргахыг сануулсан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахгүй байжээ.

Хоёрдох шаардлагын тухайд нэхэмжлэгч яагаад энэхүү шаардлагыг гаргаж байгаа нэхэмжлэлийн үндэслэлээ нэхэмжлэлдээ ч, шүүх хурлын

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

үеэр ч тайлбарлаж чадаагүй. Түрээсийн гэрээний 2.3-т түрээслэгч түрээсийн талбайг давхар түрээслэхийг хориглосон боловч ийнхүү түрээсэлснээр түрээслүүлэгчид болон машины эздэд ямар хохирол учирсан болох нь тодорхойгүй бөгөөд хариуцагч 5,235,000 төгрөг урьдчилгаанд авсныг нотлох баримт байгаагүй тул энэ шаардлагыг эхнээс нь шүүгч маргааны зүйлээс хасах шаардлагатай байв.

Сөрөг нэхэмжлэлийн шаардлагын тухайд хаалга хийлгэсэн зардлыг суутгах нь аман тохиролцоо байсан бөгөөд үүнийг нотлох баримт байхгүй. Нөгөө талаас, түрээсийн гэрээний 3.2-т зааснаар түрээслэгч нь гэрээг цуцлах үед түрээсэлж байсан талбай нь анх хүлээлцсэнээс ердийн бусаар чанар байдал нь муудаж, эвдэрч гэмтсэн бол өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх үүрэгтэй тул энэхүү үүргийг хэрэгжүүлсэн байх талтай. Эсхүл хаалгыг эвдэж гэмтээгээгүй ч чанарыг нь сайжруулах, ажлаа хөнгөвчлөх зорилгоор хийлгэсэн бол энэ тухайгаа урьдчилан түрээслүүлэгчтэй тохиролцож, түрээсийн гэрээний 7.3-т зааснаар бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж, хаалганы үнийг аль тал төлөх, гэрээ дуусгавар болсон тохиолдолд хаалгыг хэн авч үлдэх талаар тусгах шаардлагатай байсан гэж үзнэ. Иймд хаалганы үнийг шаардсан шаардлагыг маргааны зүйлээс хасах нь зүйтэй байсан.

Олох ёстой байсан ашгийн тухайд түрээсийн гэрээний 5.1.2-т түрээсийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэлийг заасан бөгөөд түрээслэгч нь түрээсийн төлбөрийг 1 сараас дээш хугацаагаар төлөхгүй байх тохиолдолд цуцлахаар байна. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл, шүүхэд гаргасан тайлбар, холбогдох нотлох баримтаар хариуцагчийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2014 оны 9 дүгээр сарын 1 хүртэлх хугацааны түрээсийн төлбөрийг төлөөгүй гэж мэдүүлснээс үзэхэд түрээсийн төлбөр 1 сараас дээш хугацаагаар төлөгдөөгүй нь тодорхой тул түрээслүүлэгч талын санаачилгаар гэрээг цуцлах үндэслэл бүрдсэн гэж үзнэ. Иймд хариуцагч гэрээ цуцлагдсанаас хойших буюу гэрээний хугацаа дуусгавар болох хүртэлх 4 сарын олох ёстой ашгийг шаардах нь үндэслэлгүй бөгөөд үүнийг маргааны зүйлээс хасах нь зүйтэй.

Харин харуул хамгаалалтын 3 ажилтанд сарын 450,000 төгрөгөөр тооцож, 1,350,000 төгрөгийн цалин олгосныг нэхэмжилсэн боловч талууд харуул хамгаалалтын ажилтны цалингийн талаар гэрээгээр тохиролцоогүй, шаардлага нь бичгийн баримтаар тогтоогдоогүй тул хэрэгсэхгүй болгож, шүүх шийдвэрлэснийг учир дутагдалтай

болсон гэж үзэх боломжтой. Учир нь түрээсийн гэрээгээр харуул хамгаалалтын ажилчдын цалингийн талаар тохиролцсон шууд заалт байхгүй боловч түрээсийн гэрээний 1.1-д талбайн харуул хамгаалалтын асуудлыг түрээслэгч тал хариуцахгүй гэж заасан байна. Үүнийг эсрэгээр нь тайлбарлавал харуул хамгаалалтыг түрээслүүлэгч тал хариуцна гэж ойлгож болохоор байна. Нэхэмжлэгч шүүхэд гаргасан тайлбартаа манайх харуул хамгаалалтын албатай, хариуцагчийн ажиллуулсан харуулын мөнгийг бид төлөх үндэслэлгүй гэж мэдүүлсэн. Гэвч хариуцагч яагаад харуул хамгаалалтын албатай газар дахин харуул авч ажиллуулах болсон, үндэслэл, шаардлага нь юунд байсан, түрээслүүлэгчийн ажиллуулдаг гэх харуул хамгаалалтын алба найдвартай, сайн ажиллаж байсан эсэхийг шүүх тодруулах шаардлагатай байсан гэж үзнэ. Мөн хариуцагч түрээсийн гэрээний хугацаанд байнга харуул ажиллуулж байсан юм уу, яагаад зөвхөн нэг сарын харуулын цалинг нэхэмжилж байгаа болох, тухайн сард нь л тус түрээсэлж буй объектод харуул хамгаалалт ажиллаагүй гэж ойлгох уу гэх зэрэг нөхцөл байдлыг тодруулснаар түрээслүүлэгч тал харуул хамгаалалт ажиллуулах гэрээний үүргээ зөрчсөн эсэхийг дүгнэх боломжтой болно. Үнэхээр зөрчсөн бол хариуцагч талд шаардах эрх үүсэх боломжтойг үгүйсгэхгүй.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд, энэ хэрэгт талуудын мэтгэлцэж, нотлох шаардлагатай байсан маргааны зүйл нь түрээсийн төлбөр болон харуулын ажилчдын цалин байх боломжтой байсан. Түрээсийн төлбөрийн хувьд нэхэмжлэгч шаардлагаа нотлох санхүүгийн баримтаа гаргаж өгөөгүйгээс шүүх хуралдаан удаа дараа хойшлох нөхцөл байдал үүссэн. Үүнийг шүүх нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлагаа хэрхэн нотолж буйг тодруулж асуух, шаардлагатай нотлох баримтыг гаргахыг сануулах боломжтой байсан гэж үзнэ.

Сөрөг нэхэмжлэлийн шаардлагын тухайд хавтаст хэргээс үзэхэд шат шатны шүүх хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн боловч эхнээсээ гаргасан шаардлагыг нь маргааны зүйлээс хассан бол шүүхийн шийдвэрүүдэд энэ талаар заавал дүгнэлт хийх шаардлагагүй байсан. Мөн харуулын ажилчдын цалингийн тухайд хариуцагчийн өмгөөлөгч харуулаар ажиллаж байсан хүмүүсийг гэрчээр асуулгах хүсэлт гаргасан (шүүх хуралдааны тэмдэглэлд хүсэлтээсээ татгалзсан гэж тэмдэглэсэн байсан

бөгөөд дараа нь хариуцагчийн өмгөөлөгч ийнхүү татгалзаагүй гэж маргасан) нь хэрэгт ач холбогдолтой бөгөөд энэ маргаантай асуудлыг шинжлэн судлах шаардлагатай байсан гэж үзнэ.

Энэ хавтаст хэргийг бүхэлд нь дүгнэвэл шүүгч талуудын мэтгэлцээнээс маргаантай болон маргаангүй асуудлыг ялгаж, тухайн хэргийн маргааны зүйлийг нь олж тогтоох, түүнийг нотлоход шүүхийн мэтгэлцээнийг чиглүүлэхийн тулд зохигчдоос шаардлага, тайлбарын үндэслэлийг нь тодруулах, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримтуудыг гаргах талаар талуудад сануулах зэргээр шүүгчийн идэвхтэй оролцоо дутмаг байсан. Үүнээс шалтгаалан үйл баримт болон хууль хэрэглээний хувьд харьцангуй тодорхой, хөнгөн хэрэг 3 шатлалын шүүхийг 4 дамжиж, хэргийн оролцогчид хугацаа их алдсан төдийгүй шүүхийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөө багатай болгосон гэж дүгнэж болохоор байна.

Дашрамд дурдахад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдол гаргаж байгаа байдал, шүүх хуралд гаргасан тайлбараас үзэхэд мэргэшсэн өмгөөлөгч (хуульчийн гэрчилгээтэй эсэх) эсэх нь эргэлзээ төрүүлсэн бөгөөд хуульчийн мэргэжилгүй, итгэмжлэлээр оролцсон хүн байхыг үгүйсгэхгүй. Нэхэмжлэгч тал шүүх хуралд өмгөөлөгчгүй оролцож байгаад сүүлд өмгөөлөгч авсан гэж хавтаст хэргээс ойлгогдсон. Иймд мэргэшсэн хуульчийн туслалцаа аваагүй, өмгөөлөгчгүй оролцож байгаа зохигчдын хувьд тэдний шүүхэд тайлбар, мэдүүлгээ үндэслэлтэй, ойлгомжтой гаргах, хэрэгт шаардлагатай нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөхөд нь шүүгчийн оролцоо дэмжлэг нэн чухал байгаа нь ажиглагдсан болно. Эс бөгөөс мэтгэлцэх зарчмыг туйлын утгаар ойлгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талуудын нуруун дээр бүрэн даатгах нь маргааны зүйл хэт өргөжих (ялангуяа хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй), хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үндэслэлгүйгээр хойшлох, удаашрах байдал үүсэж байгааг анхаарах хэрэгтэй.

2.2.2. №1001 дугаартай хавтаст хэрэг

Нэхэмжлэгч: “К.М” ББСБ

Хариуцагч: Г.У

Хэргийн товч утга: Зээлийн гэрээний үүргийн биелэлт болох нийт 3,301,221 төгрөг гаргуулах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай иргэний хэрэг

Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа: 2015.04.28-2016.06.23 (1 жил, 2 сар)

Хэргийн агуулга: Зохигчид 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдөр зээлийн гэрээ байгуулсан бөгөөд хариуцагч Г.У нь тус ББСБ-аас 4,500,000 төгрөгийг сарын 3 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатайгаар зээлж авсан. Нэхэмжлэгч нь хариуцагчийг 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар зээлийн гэрээний дагуу төлөх үндсэн зээл 2,308,370.60, зээлийн хүү 886,133.18, нэмэгдүүлсэн хүү 1,846.70, нийт 3,196,350.48 төгрөг, шүүхэд нотлох баримт бүрдүүлэн өгөхөд гарсан нотариатчийн үйлчилгээний хөлс 9,300, улсын тэмдэгтийн хураамжид 95,571.11, нийт 3,301,221.59 төгрөг шаарджээ.

Хариуцагч хариу тайлбартаа зээлийн гэрээ байгуулсан талаар маргаагүй. Харин 2011 оны 9 дүгээр сараас хойш ажил хийж орлого олох боломжгүй болсноос төлөх ёстой зээлээс 1,400,000 төгрөг үлдсэн. Дараа нь өөрийн боломжоор бага багаар төлсөн боловч үндсэн зээлийн хэмжээнээс хасагдалгүй хүү, алдангиас хасагдаж байсан. 2015 оны 1 дүгээр сарын 29-нд бэлнээр 2,000,000 төгрөг төлсөн боловч мөн л зээлийн хүү, алданги нэрээр суутгасан. Одоо тус компанид би ямар ч өр төлбөр байхгүй гэж маргасан байна.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.04.28 №2977)**

Талуудын хооронд 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдөр зээл болон барьцааны гэрээ байгуулж 4,500,000 төгрөгийг 18 сарын хугацаатай, сарын 3 хувийн хүүтэй зээлж, зээлийн барьцаанд газар, автомашин барьцаалсан байна. Гэрээний хугацаа 2012 оны 2 дугаар сарын 25-ны өдөр дууссан ба үндсэн зээлийн үлдэгдэл 2012 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 2,308,370 төгрөг байжээ.

Нэхэмжлэгч “К.М” ББСБ-ын шүүхэд ирүүлсэн зээлдэгчийн зээл, хүүгийн тооцоолол гэсэн баримтаар, зээлдэгч гэрээний дагуу зээлийн хүүд 1,454,058 төгрөг төлөхөөс 1,136,389 төгрөг төлсөн, үлдэх 317,669 төгрөгийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн 1588 төгрөгийг төлөх үүрэгтэй.

2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр төлсөн 2,000,000 төгрөгөөс 319,257 төгрөгийг суутгаж, үлдэх 1,680,743 төгрөгийг үндсэн зээлээс хасаж нийт 627,627 төгрөгийг хариуцагчаас гаргуулж, нэхэмжлэгчид олгох нь зүйтэй байна. Үүн дээр нэмээд нотариатын үйлчилгээний хөлс 9,300 төгрөгийг нэмж тооцон, нийт 636,927 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 2,568,722 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.07.20 №921)**

Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэв.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.10.06 №750)**

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэв.

Учир нь анхан шатны шүүх зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүүгийн талаарх нэхэмжлэлийн шаардлагад дүгнэлт хийгээгүй, давж заалдах шатны шүүх “зээлийн гэрээний хугацаа өнгөрснөөс хойш үлдэгдэл төлбөрт хүү тооцон шаардах эрхгүй” гэснийг эрх зүйн хувьд алдаатай, хуулийг буруу тайлбарласан гэж үзсэн бөгөөд хоёр шатны шүүх зээлийн төлбөр тооцооны талаар бүрэн тодруулаагүйгээс хяналтын шатны шүүхээс хэргийг шийдвэрлэх боломжгүй байна гэж дүгнэжээ.

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2016.01.26 №01001)**

Шүүх зохигчдын хооронд 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан зээлийн гэрээг Иргэний хуулийн 42.2, 451.1-д заасны дагуу хүчин төгөлдөр гэж дүгнэсэн. Иргэний хуулийн 453.1-д зааснаар зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү тус тус төлөх үүрэгтэй.

Хариуцагч Г.У нь 2010 оны 10 дугаар сарын 1-ээс 2011 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд нэхэмжлэгч “К.М” ББСБ-д 3,396,610 төгрөг (нийт 3,426,610 төгрөг болох учиртай) төлсөн нь нотлох баримтаар тогтоогдсон. Тухайн үед үндсэн зээлийн үлдэгдэл 2,062,072, зээлийн хүү 495,376 төгрөг тус тус байсан гэж тооцсон боловч ямар нотлох баримтад үндэслэсэн болох, ямар тооцооллоор ингэж гаргасан нь ойлгомжгүй.

Хариуцагч Г.У нь 2012 оны 9 дүгээр сарын 18-аас 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд бага багаар төлсөөр 742,800 төгрөг төлсөн нь нотлох баримтаар нотлогдсон юм. Шүүх энэхүү төлөлтийн дүнг үндсэн зээлээс хасаж тооцоход үндсэн зээл 1,419,272 (2,062,072 төгрөгөөс 742,800-г хасахад 1,319,272 төгрөг үлдэх учиртай), хүү 495,376, хэтэрсэн хугацааны хүү 707,778, нэмэгдүүлсэн хүү 141,555 нийт 2,763,981 төгрөг үлдсэн гэж тооцоолсон.

Энэ төлөлтөөс хойш хариуцагч Г.У зээлийн төлөлт хийхгүй байж байгаад 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр 2,000,000 төгрөг төлсөн бөгөөд энэ үед түүний үндсэн зээл 1,419,272, зээлийн хүү 495,376, хэтэрсэн хугацааны хүү 1,662,765, нэмэгдүүлсэн хүү 474,108, нийт 4,051,521 төгрөг байснаас 2,000,000-ыг хасахад 2,061,227 (2,051,521 төгрөг болох учиртай), нотариатын үйлчилгээний зардал 9300, нийт 2,060,821 төгрөгийг (уул нь 2,070,527 төгрөг болно) хариуцагч Г.У-ээс гаргуулж шийдвэрлэсэн.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2016.04.13 №703)**

Хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэв.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2016.06.23 №00778)**

Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхиж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн байна.

Хүснэгт 4. №1001 дугаартай хавтаст хэргийг шүүхэд хянан шийдвэрлэсэн ажиллагааны талаарх дүгнэлт

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015.04.28) Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан. Хариуцагч Г.У-ээс нийт 636,927 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч “К.М” ББСБ-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 2,568,722 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	Анхан шатны шүүх зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүүгийн талаарх нэхэмжлэлийн шаардлагад дүгнэлт хийгээгүй гэдэг Дээд шүүхийн шаардлагатай санал нийлж байна.
Давж заалдах шатны шүүх	Хурал №1 (2015.07.20) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан. Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.	Давж заалдах шатны шүүх “зээлийн гэрээний хугацаа өнгөрснөөс хойш үлдэгдэл төлбөрт хүү тооцон шаардах эрхгүй” гэснийг эрх зүйн хувьд алдаатай, хуулийг буруу тайлбарласан гэж үзнэ гэх Дээд шүүхийн дүгнэлттэй санал нийлж байна.
Дээд шүүх	Хурал №1 (2015.10.06) Дээд шүүхийн тогтоол гарсан. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.	Хоёр шатны шүүх зээлийн төлбөр тооцооны талаар бүрэн тодруулаагүйгээс Дээд шүүх хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй гэх дүгнэлттэй санал нийлж байна.
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015.11.26) Нэхэмжлэгч хариуцагчийг шүүх хуралд биечлэн оролцуулах хүсэлт гаргаж, хурлыг хойшлуулсан. Хурал №2 (2015.12.17) Хариуцагч хаягаа өөрчилсөн тухайгаа шүүхэд мэдэгдээгүй байна. Иймд хариуцагч Г.У-ийн хаягийг тодруулж, шүүх хуралд биечлэн оролцуулах хүсэлт гаргаж, хурлыг хойшлуулсан.	Хариуцагч оршин суугаа хаягаа өөрчилсөн бол энэ тухайгаа шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	Хурал №3 (2016.01.12) Нэхэмжлэгч нотлох баримт нэмэлтээр гаргаж өгөх хүсэлт гаргаж, хурлыг хойшлуулсан.	Хариуцагч Г.У-ийн зээлийн төлбөр төлж байсныг нотлох баримт хэрэгт хавсаргагдаагүй байсан тул нэхэмжлэгч төлөлт хийсэн, тооцоололтой баримт гаргаж өгөх хүсэлт гаргаж, хурлыг хойшлуулсан. Хэрэгт хамгийн ач холбогдолтой энэхүү нотлох баримтыг гаргах талаарх хүсэлтийг дэндүү хожуу гаргасан. Мөн өмнөх шатны шүүхүүд хэргийг шийдвэрлэхдээ шаардаж авах боломжтой байсан гэж үзнэ.
	Хурал №4 (2016.01.26) Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан.	Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлаад хариуцагч Г.У-ээс 2,060,821 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч “К.М” ББСБ-д олгож, нэхэмжлэлээс 1,144,828 төгрөг гаргуулах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
Давж заалдах шатны шүүх	Хурал №1 (2016.04.13) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан.	Хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
Дээд шүүх	Хурал №1 (2016.06.23) Дээд шүүхийн тогтоол гарсан.	Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхиж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн.

Дүн шинжилгээ

Уг хэрэг нь зээлийн гэрээний үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүйн улмаас үүссэн эрх зүйн харилцааны маргаан байсан ба зохигчдын хооронд 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдөр зээлийн болон барьцааны гэрээ байгуулагдаж, нэхэмжлэгч “К.М” ББСБ нь хариуцагч Г.У-д 4,500,000 төгрөгийг сарын 3 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай зээлдүүлсэн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

болох нь нотлох баримтаар тогтоогдсон бөгөөд талууд энэ асуудлаар маргаагүй. Харин зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш зээлдэгч хугацаа хэтэрсний болон нэмэгдүүлсэн хүүг төлөх үүрэгтэй юу гэдэг нь гол маргааны зүйл байв.

Зээлийн хүүгийн асуудлыг Иргэний хуулийн 453.1-д зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24.3-т зээлийг заасан хугацаанд нь төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол түүний хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлнө гэж тодорхой заажээ. Иймд хариуцагч нь яаж ч маргаад зээлийн гэрээний үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тул үүргээ биелүүлэх хүртэлх хугацаа хэтэрсний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүрэг үүссэн байна.

Шүүх дээрх хуулийн зохицуулалтын дагуу зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш хариуцагч Г.У-ийн төлсөн зээлийн төлбөрийг Иргэний хуулийн 216.4-т заасан үндсэн үүрэг, хүү гэсэн үүргийн гүйцэтгэлийн дарааллын дагуу үндсэн зээлээс хасаж тооцсон бөгөөд хэтэрсэн хугацааны хүүг бодож, дараагийн төлөлт хийгдэхэд мөн үндсэн зээлээс хасаж, үлдэгдэл хүүгийн төлбөрийг хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэсэн нь хуульд үндэслэсэн шийдвэр болжээ.

Гагцхүү маргааны үйл баримт болон хууль хэрэглээний хувьд ойлгомжтой энэ хэргийн хувьд шүүхээр шийдвэрлэгдэх хүртлээ 3 шатлалын шүүхийг 6 тойрч, 1 жил 2 сарын хугацаа зарцуулсан нь анхаарал татаж байна. Хавтаст хэргээс үзэхэд зохигчид өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон. Анх хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх нь хариуцагчийн зээлийн төлөлт хийсэн, тооцоололтой баримт хэрэгт хавсаргагдаагүйг нэхэмжлэгчид сануулаагүй, нэхэмжлэгч ч хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой энэхүү баримтыг 3 шатны шүүхээр маргаан хянагдаад, анхан шатны шүүх дээр дахин хянан хэлэлцүүлэгдэхээр буцаагдах үед гаргаж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж, чирэгдүүлэх үндэс болсон байна.

Мөн анх хэргийг хянан хэлэлцсэн анхан шатны шүүх мөн давж заалдах шатны шүүх ч нэхэмжлэгчийн нэхэмжилж буй зээлийн

төлбөрийн хэмжээ (үүнээс хэдэн төгрөг нь үндсэн зээлийн үлдэгдэл болох, хариуцагч Г.У нь хэдий хэр хугацааны хугацаа хэтэрсний болон нэмэгдүүлсэн хүүг төлөх үүрэгтэй болох), түүнийг нотлох баримтыг тодруулж асуугаагүйгээс зээлийн төлбөрийн тооцооллыг буруу бодож гаргасан нь нэхэмжлэгч давж заалдах шатны шүүх болон дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл болсон байна.

Дээд шүүхээс хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасны дараа хэрэгт шаардлагатай нотлох баримт бүрдэж, анхан шатны шүүх хэргийг үндэслэлтэй шийдвэрлэх боломжтой болжээ. Хуулийн хатуу зохицуулалтын дагуу хариуцагч Г.У нь нэхэмжлэгчид өндөр хэмжээний хүү төлөх үүрэг үүссэн ч шүүхийн зүгээс хариуцагч Г.У-ийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, талуудыг зээлийн төлбөрийн хэмжээ болон хугацаан дээрээ харилцан буулт хийх боломжтой эсэхийг асууж, талуудыг эвлэрүүлэх талаас санаачилга гаргасан бол талуудад ашигтай байж болох талтай. Учир нь барьцааны хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахад дуудлага худалдаа зохион байгуулах зэргээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хугацаа зарцуулах, энэ явцад дахин маргаан гарахыг үгүйсгэхгүй тул хариуцагчийн төлбөрийн хэмжээг боломжит хэмжээнд багасгаад (учир нь үндсэн зээл давуулан төлөгдсөн байгаа), хариуцагчид хугацаа олговол хариуцагч шүүхийн албадлагагүйгээр санаачилгаараа төлбөрөө шуурхай төлөхийг эрмэлзэж болох талтай.

Уг хэргийг бүхэлд нь дүгнэвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчгүй оролцож байгаа зохигчдод шүүгчийн зүгээс маргааны зүйлийг олж тогтоох, түүнийхээ нотлох баримтыг талуудаас гаргуулж авах тал дээр дэмжлэг үзүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахаас сэргийлэх боломж гэж үзэж байна.

2.2.3. №2586 дугаартай хавтаст хэрэг

Нэхэмжлэгч: Л.Г

Хариуцагч: Р.Ш

Хэргийн товч утга: 11.661.872 төгрөг гаргуулах тухай иргэнийг хэрэг

Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа: 2014.02.18-2015.10.01
(1 жил 8 сар)

Хэргийн агуулга: Өмнөговь аймгийн Шивээхүрэн дэх Гаалийн газар бүрдүүлэлтийн ахлах байцаагчаар ажилладаг нэхэмжлэгч Л.Г нь

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хариуцагч нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг “Таван толгой шин” ХХК-д тээвэр хариуцсан менежерээр ажиллаж байсан Р.Ш-д 10,000,000 төгрөгийг 2012 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Шивээхүрэн дэх Хаан банкны ... тоот дансанд шилжүүлжээ. Ийнхүү мөнгө шилжүүлсэн шалтгааныг Л.Г нэхэмжлэлдээ “Р.Ш-тэй нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашин түрээслэх гэрээ байгуулахаар болж, урьдчилгаа болгон”¹ шилжүүлсэн гэжээ. Автомашин түрээслэх гэрээ байгуулаагүй учраас урьдчилгаа 10 сая төгрөгөө буцааж авахаар шаарджээ.

Харин хариуцагч Р.Ш хариу тайлбартаа “Түүний надад шилжүүлсэн гэх 10,000,000 төгрөг нь тухайн автомашины урьдчилгаа төлбөр болон автомашин эзэмших эрхийг олж авах зэрэг ажилд зарцуулагдсан болно”² гэжээ. Хариуцагч Р.Ш мөн тайлбартаа “Таван толгой шин” ХХК нь өөрийн эзэмшлийн Норд бенз маркийн автомашиныг урьдчилгаа аван, жолооч нартай түрээсийн гэрээ хийн эзэмшүүлдэг ба 40,000 тн нүүрс тээвэрлэж өгсөн бол тээврийн хэрэгсэл нь тухайн түрээс эзэмшигчид өмчлөх эрх нь шилжих нөхцөлтэй байдаг ба зарим тохиолдолд автомашины жолооч урьдчилгаа мөнгийг төлөх чадваргүйгээс үүдэн давхар түрээсийн нөхцөл үүсдэг. Авто машины давхар түрээсийн гэрээ олж өгөхийг нэхэмжлэгч Л.Г надаас удаа дараа хүссэн учраас зөвхөн түүний хүсэлтийг биелүүлж, туслалцаа үзүүлсэн болохоос надад ямар нэг ашиг олох зорилго байгаагүй гэжээ.

Мөн нэхэмжлэгч Л.Г нь 2012 оны 2 дугаар сарын 20-нд Өмнөговь аймгийн Хадгаламж банкнаас 15,000,000 төгрөг зээлж дээрх 10,000,000 төгрөгийг бүрдүүлсэн тул зээлийн хүүд төлсөн 1,661,872 төгрөгийг мөн шаарджээ.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2014.04.07 №1148)**

Нэхэмжлэгч нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашин түрээслэхэд хариуцагчаар зуучлуулахаар тохирч, Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1 дэх хэсэгт заасан зуучлалын гэрээг зохигч амаар байгуулжээ. Харин гэрээний дагуу хүлээсэн үүргээ хариуцагч биелүүлээгүй гэж нэхэмжлэгч зуучлалын гэрээнээсээ татгалзаж,

¹ №2586 дугаартай хавтаст хэргийн 1 дэх тал

² №2586 дугаартай хавтаст хэргийн 14 дэх тал

гэрээний дагуу хариуцагчид шилжүүлэн өгсөн 10,000,000 төгрөгийг буцаан авахаар шаардсан байна.

Иймд иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсэгт заасны дагуу гэрээний гүйцэтгэлийг гэрээний дагуу талууд биет байдлаар нь буцаах үүрэгтэй тул гэрээний гүйцэтгэлд шилжүүлэн өгсөн төгрөгийг хариуцагчаас буцааж гаргуулахаар нэхэмжлэгч шаардах эрхтэй байна³.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал (2014.11.14 №1071)**

Хэрэгт авагдсан баримтууд, зохигчийн тайлбараас үзэхэд талуудын хооронд Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1 дэх хэсэгт заасан зуучлалын гэрээ амаар байгуулагдсан, гэрээний хүчин төгөлдөр байдлын тухайд зохигчид маргахгүй байна. Харин Р.Ш нь нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашины жолоочтой нэхэмжлэгч Л.Г-г гэрээ байгуулахад нь зуучлах үүргээ биелүүлсэн гэх боловч энэ тайлбараа баримтаар нотлоогүй тул шүүх нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан нь үндэслэлтэй гэж үзнэ.

Хариуцагч Р.Ш нь Б.М-ээс гэрчийн мэдүүлэг гаргуулах хүсэлтийг шүүх хангаагүй гэснийг хүлээн авах үндэслэлгүй болно. Учир нь хариуцагч нь “...Б.Мөнхбат тээврийн үйл ажиллагаа хэрхэн өрнөж байсан процессыг нотолж чадна...” гэж гэрчээс мэдүүлэг авхуулах хүсэлтээ үндэслэсэн ба энэ нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолгүй талаар шүүх дүгнэж, хүсэлтийг хангаагүй нь буруу биш байна⁴.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.01.08 №04)**

Анхан болон давж заалдах шатны шүүх зохигчдын хооронд үүссэн эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүйгээс хэрэглэвэл зохих хуулийн зүйл, заалтыг зөв баримтлаагүйгээр шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны байх хуулийн шаардлагыг хангаагүй байна. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулаагүйгээс талуудын мэтгэлцэх эрх зөрчигдсөн байх ба хэргийн бодит нөхцөл байдал хэрэгт авагдсан баримтаар тогтоогдоогүй тул шүүхийн шийдвэр, магадлалыг үндэслэл бүхий болсон гэж үзэх боломжгүй байна.

Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1.-д зааснаар зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож

³ №2586 дугаартай хавтаст хэргийн 40-41 дэх тал

⁴ №2586 дугаартай хавтаст хэргийн 66 дахь тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээдэг. Нэхэмжлэгч Л.Г шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ шаардлагын зүйл болох 10,000,000 төгрөгийг зуучлалын хөлс гэж тодорхойлоогүй, харин хүнд даацын автомашин түрээслэх урьдчилгаанд өгсөн гэж зааснаас гадна хариуцагч Р.Ш уг мөнгийг түрээсийн гэрээ байгуулахад нь нэхэмжлэгчид зуучилсны хөлс гэж тайлбарлаагүй байна (ХХ-ийн 1-2, 18-19 дүгээр тал). Зохигчдын хооронд зуучлалын гэрээ байгуулагдсан гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй байхад шүүх Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1-д заасан гэрээнээс татгалзсан гэж үзэж, мөн хуулийн 205 дугаар зүйлийн 205.1-д зааснаар нэхэмжлэгчийн шилжүүлсэн 10,000,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь учир дутагдалтай болжээ.

Хариуцагч Р.Ш нэхэмжлэгч Л.Г-ээс шилжүүлсэн мөнгийг тээврийн хэрэгсэл түрээслэх урьдчилгаа төлбөрийн хувьд холбогдох хүмүүст нь дамжуулан өгч, түрээсийн гэрээ хэрэгжиж эхэлсэн гэж тайлбарласан байх ба өөрийн тайлбарын нотолгоо болгох зорилгоор тухайн үед “Таван толгой шин” ХХК-д тээвэр хариуцсан ахлах менежер Б.М-ээс гэрчийн мэдүүлэг авхуулахаар шүүхэд хүсэлт гаргасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шаардлагад нийцжээ (ХХ-ийн 24 дүгээр тал).

Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлэх үүрэгтэй байхад анхан шатны шүүх гэрчийн мэдүүлэг авах нь хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай болох нь тогтоогдоогүй гэж үзэж, хүсэлтийг хангахаас татгалзсан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3-г заасан шаардлагыг зөрчжээ.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаажээ⁵.

⁵ №2586 дугаартай хавтаст хэргийн 82 дахь тал

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2015.04.22 №102 (ШШ2015/02586))**

Хариуцагч тал өөрийн нь дансанд 10,000,000 төгрөг шилжсэн талаар маргаагүй бөгөөд уг мөнгийг холбогдох хүмүүст нь дамжуулан өгч, автомашин түрээслэх түрээсийн гэрээ хэрэгжиж эхэлсэн гэж тайлбарлажээ. Талуудын хооронд бичгээр гэрээ байгуулагдаагүй хэдий ч Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2-т зааснаар гол нөхцөлийн талаар тохирсон, тогтсон байдлаар урьдчилгаа мөнгө шилжүүлсэн байх тул мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар амаар хэлцэл хийгдсэн гэж үзлээ. Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1-д зааснаар хариуцагч тал түрээсийн автомашиныг шилжүүлэх, эсхүл эзэмшигч жолоочтой нь холбож өгөх байсан байна. Иргэний хуулийн 323 дугаар зүйлийн 323.1-д зааснаар түрээслэгч, түрээсэлсэн эд хөрөнгөө гагцхүү түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр дамжуулан түрээсэлж болохоор байна.

Гэтэл Л.Г, Р.Ш нарын хооронд хийгдсэн хэлцэл нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д зааснаар хууль зөрчсөн анхнаасаа хүчин төгөлдөр бус хэлцэл байна. Хяналтын шатны шүүх хуралдааны тэмдэглэлд “бэлнээр аваад үрсэн” гэх Р.Ш-ийн тайлбар, уг 10,000,000 төгрөгийг хэрхэн зарцуулсан талаар нотолсон баримтгүй, аман хэлцлийн үр дүн гараагүй байдлаас үзэхэд хариуцагч нь бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан, хөрөнгөжсөн байх тул Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1, 492.1.2-т зааснаар Л.Г шилжүүлсэн 10,000,000 төгрөгөө шаардах эрхтэй байна⁶.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2015.06.26 №824)**

Зохигчдын тайлбар болон хэрэгт авагдсан баримтаас үзэхэд нэхэмжлэгч Л.Г нь 2012 оны 3 дугаар сарын 15-ны өдөр “Таван толгой шин” ХХК-тай нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашин түрээслэх гэрээ байгуулахад туслуулах зорилгоор 10,000,000 төгрөгийг уг компанид менежер ажилтай Р.Ш-ийн ХААН банкны дансанд шилжүүлсэн боловч тэдгээрийн хооронд хэлцэл хийгдээгүй, нэхэмжлэгчийн хүссэн үр дүн гараагүй гэж үзсэн шүүхийн дүгнэлт үндэслэлтэй байна. Түүнчлэн хариуцагч Р.Ш-ийн “... мөнгийг бэлнээр аваад үрсэн” гэх тайлбар болон 10,000,000 төгрөгийг “Таван толгой шин” ХХК-д шилжүүлээгүй, хэрхэн

⁶ №2586 дугаартай хавтаст хэргийн 149 дэх тал

зарцуулсан талаар баримт байхгүй тул хариуцагч Р.Ш-г нэхэмжлэгч Л.Г-ийн шилжүүлсэн 10,000,000 төгрөгөөр үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзэн Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.2-т зааснаар шаардах эрхтэй.

Гэрч Б.М-ийн мэдүүлэг болон “Таван толгой шин” ХХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 15/52 тоот албан бичгээр хариуцагч Б.Ш нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашиныг нэхэмжлэгчид олж өгөх үүргээ гүйцэтгэсэн гэх хариуцагчийн тайлбар няцаагдсан байна⁷.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.10.01 №709)**

Нэхэмжлэгч Л.Г “Таван толгой шин” ХХК-тай нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашин түрээслэх гэрээ байгуулах зорилгоор хариуцагч Р.Ш-д 10,000,000 төгрөгийг 2012 оны 3 дугаар сарын 15-ны өдөр түүний ХААН банкин дахь дансанд шилжүүлсэн талаар зохигч маргаагүй байна. Нэхэмжлэгчид хүссэн үр дүн бий болоогүйгээс тэрээр шилжүүлсэн мөнгөө буцаан шаардсан ба хариуцагч өөрийн татгалзлыг тухайлбал, нэхэмжлэгчид түрээсийн автомашин олж өгч, холбогдох хүмүүст мөнгийг шилжүүлсэн гэх тайлбараа баримтаар нотлоогүй байна.

Иймд 10,000,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулж, нэхэмжлэгчид олгож шийдвэрлэсэн хоёр шатны шүүхийн хийсэн дүгнэлтийг буруутгах үндэслэлгүй.⁸

Хүснэгт 5. №2586 дугаартай хавтаст хэргийг шүүхэд хянан шийдвэрлэсэн ажиллагааны талаарх дүгнэлт

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Анхан шатны шүүх	Хурал №1 (2014.03.24) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Хариуцагч Р.Ш-ийн өмгөөлөгч авах хүсэлтийг хүлээн авч, Б.М-ийг гэрчээр оролцуулах хүсэлтийг хангахгүй орхиж, шүүх хуралдаан 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 14.30 цаг хүртэл хойшилсныг тайлбарлажээ.	Эхний шүүх хуралдаан зөвхөн хүсэлт шийдвэрлэх төдий явагдаж өнгөрч байгаа нь асуудалтай юм.

⁷ №2586 дугаартай хавтаст хэргийн 169 дэх тал

⁸ №2586 дугаартай хавтаст хэргийн 182-183 дахь тал

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	<p>Хурал №2 (2014.03.28) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Хариуцагч эмнэлэгт хэвтсэн учраас шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан ба шүүх хуралдааныг 4 дүгээр сарын 7-ны өдрийн 13.00 цаг хүртэл хойшлуулж хүсэлтийг хангасан байна.</p>	<p>Шүүхийн практикт хэргийн оролцогч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч өвчтэй гэсэн шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах тохиолдол нийтлэг болсон бөгөөд эмчийн зүгээс олгосон акт үнэн зөв эсэхийг шалгах, хариуцлагажуулах шаардлагатай.</p>
	<p>Хурал №3 (2014.04.07) Хариуцагч дахин Б.М-ийг гэрчээр оролцуулах хүсэлт гаргасан боловч өмнөх шүүх хуралдаанаар уг хүсэлтийг хангахаас татгалзсан учир шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулав. Хариуцагчаас 10,000,000 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгож шийдвэрлэв.</p>	<p>Шүүх хуралдаан зохих журмын дагуу явагдаж өнгөрсөн байх боловч даргалагчаас асуултдаа тодорхой хариулт авч чадахгүй, лавлаж асуухгүй байгаа зарим тохиолдол ажиглагдав. Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг Иргэний хуулийн 410-р зүйлийн 410.1 гэж тодорхойлсон боловч уг шаардах эрхийн урьдчилсан нөхцөлтэй холбогдуулж төдийлөн сайн асуулт асуугаагүй байна.</p>
<p>Давж заалдах шатны шүүх</p>	<p>Хурал №1 (2014.11.14) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан. Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.</p>	<p>Харин давж заалдах шатны шүүх хуралдаан дээр Иргэний хуулийн 410-р зүйлийн 410.1 гэж тодорхойлсон боловч уг шаардах эрхийн урьдчилсан нөхцөлтэй холбоотой асуултуудыг нэлээдгүй асуусан боловч нэхэмжлэгчээс хариуцагчид шилжүүлсэн 10,000,000 төгрөгийг ямар зориулалттай болохыг тодорхой болгож чадаагүй байна.</p>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Дээд шүүх	Хурал №1 (2015.01.08) Дээд шүүхийн тогтоол гарсан. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.	Дээд шүүх нэхэмжлэгчээс хариуцагчид шилжүүлсэн 10,000,000 төгрөгийг ямар зориулалттай байсан, тухайн мөнгийг хэрхэн зарцуулсан талаар тодруулжээ. Гэхдээ энэ нь Дээд шүүхийн чиг үүрэг мөн үү гэдэг асуулт гарч ирж байна.
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015.03.30) Нэхэмжлэгчийн зүгээс “Таван толгой шин” ХХК-иас хариуцагч Р.Ш нь түрээсийн урьдчилгаа төлбөр болох 10,000,000 төгрөгийг тус компанид тушаасан баримтыг албан ёсоор гаргуулах, нэхэмжлэгчийн нэр дээр түрээсийн тооцооны мөнгө авсан эсэхийг албан бичгээр баталгаажуулах, хариуцагчийн байрыг битүүмжлэх хүсэлт гаргасан ба шүүхийн зүгээс хариуцагчийн хүсэлтийг хангаж шүүх хуралдааныг хойшлуулсан байна.	Үндсэн хэргийг шийдвэрлэх ёстой шүүх хуралдаан дээр хүсэлт гаргаж шүүх хуралдааныг хойшлуулж буй нь манай улсын шүүх хуралдааны талаарх ИХШХШТХ-ийн зохицуулалт хангалтгүй байгааг харуулддаг бөгөөд үүний үр дүнд шүүх хуралдаан зохион байгуулалт муутай явагддаг.
	Хурал №2 (2015.04.15) Хариуцагч өмгөөлөгчтэй оролцох хүсэлт гаргаснаар шүүх хуралдааныг 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутад хийхээр хойшлуулав.	Өмгөөлөгчтэй оролцох хүсэлт гарган шүүх хуралдааныг хойшлуулах явдал нийтлэг болсон бөгөөд энэ талаар иргэний процесс хуульд тодорхой зохицуулалт оруулах шаардлагатай байна. Хэдийгээр хууль зүйн туслалцаа авах нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хэргийн оролцогчийн эрх боловч үүнээс болж нөгөө талын болон шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй тал зохих хязгаарлалтыг хийж өгөх нь зүйтэй.

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	Хурал №3 (2015.04.22) Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1, 492.1.2-т зааснаар хариуцагч Р.Ш-ээс 10,000,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Л.Г-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 8,034,694 төгрөгийг хэрэгсэхгүй болгожээ.	Шүүх хуралдаан зохих журмын дагуу явагдаж өнгөрсөн байх боловч даргалагчаас асуултдаа тодорхой хариулт авч чадахгүй, лавлаж асуухгүй байгаа зарим тохиолдол ажиглагдав. Ингээд шүүхээс шийдвэр гаргахдаа хяналтын шатны шүүх хуралдааны тэмдэглэлд “бэлнээр аваад үрсэн” гэх Р.Ш-ийн тайлбарыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон байна.
Давж заалдах шатны шүүх	Хурал №1 (2015.06.26) Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.	Давж заалдах шатны шүүх мөн л талуудын хооронд болсон харилцааг бүрэн тодруулж лавлахгүй байгаа байдал ажиглагдав.
Дээд шүүх	Хурал №1 (2015.10.01) Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хэвээр үлдээж шийдвэрлэв.	Дээд шүүхийн хурал хуульд заасан журмын дагуу явагдсан байна.

Дүн шинжилгээ

Шүүх нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг болон хариуцагчийн хариу тайлбарыг тодруулах ажиллагааг хийгээгүй байна. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ “Р.Ш-тэй нүүрс тээвэрлэх хүнд даацын автомашин түрээслэх гэрээ байгуулахаар болж, урьдчилгаа болгон 10,000,000 төгрөгийг шилжүүлсэн”⁹ гэсэн байх бөгөөд энэхүү тайлбараас харахад нэхэмжлэгч нь автомашин түрээслэх гэрээг Р.Ш-тэй байгуулах мэтээр ойлгогдож буй юм. Гэвч бодит байдалд Р.Ш-д ажил олгогч компанийн эзэмшлийн хүнд даацын автомашиныг түрээслэгч жолоочтой хамтран ажиллах гэрээ хийх зорилготой бөгөөд Р.Ш нь хүнд даацын автомашин түрээслэгч жолоочтой нэхэмжлэгчийн өмнөөс гэрээ хийх байжээ.

⁹ №2586 дугаартай хавтаст хэргийн 1 дэх тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Цаашлаад анхан шатны шүүх талуудын хооронд үүссэн харилцааг зуучлалын гэрээний харилцаа гэж үзэн Иргэний хуулийн 410-р зүйлийг хэрэглэсэн байдаг. Гэтэл зуучлалын гэрээний гол нөхцөл нь хөлс байх бөгөөд талууд хөлс тохирсон эсэх, нэхэмжлэгчийн хариуцагчаас буцаан шаардаж буй мөнгө нь хөлс мөн эсэхийг тогтоохгүйгээр зуучлалын гэрээ байгуулагдсан гэж дүгнэж буй нь үндэслэлгүй байна.

Мөн хариуцагч хариу тайлбартаа "... надад шилжүүлсэн гэх 10,000,000 төгрөг нь тухайн автомашин эзэмших эрхийг олж авах зэрэг ажилд зарцуулагдсан болно. Ийм учраас миний бие нэхэмжлэгчид төлөх төлбөргүй болно"¹⁰ гэсэн байх бөгөөд уг тайлбараас харвал 10,000,000 төгрөг нь ямар зориулалттай болон хэдийг юунд зарцуулсан, юугаар нотлох нь тодорхойгүй байхад шүүх мөн л тодруулах ажиллагааг хийгээгүй байна.

2.2.4. №8476 дугаартай хавтаст хэрэг

Нэхэмжлэгч: Б.А

Хариуцагч: А.Ц

Хэргийн товч утга: 48,051,404 төгрөг гаргуулах тухай

Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа: 2015.04-2016.05
(1 жил 1 сар)

Хэргийн агуулга: Р.А нь Я.Б, А.М нарын өмчлөлийн I давхарт байрлах 331.52 м.кв байрнаас худалдаа, үйлчилгээний "JP SHOP" дэлгүүрийг ажиллуулах зориулалтаар 50 м.кв талбайтай 05 тоот өрөөг түрээслэх гэрээг Я.Б, А.М нартай 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Уг гэрээг 2016 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал буюу 36 сарын хугацаатай байгуулж, нэг сарын 1,000,000 төгрөгийн түрээсийн төлбөр төлөхөөр тохирчээ. 2013 оны 9 дүгээр сарын 25-аас 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийг дуусталх хугацаанд япон автомашины гэрэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, "Канген" цэвэршүүлсэн усны худалдаа эрхлэх зэргээр аж ахуйн үйл ажиллагаа явуулжээ. 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдөр дээрх 331.52 м.кв үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг А.М, Я.Б нь А.Ц-д "Худалдах, худалдан авах гэрээ"-ээр шилжүүлжээ.

Нэхэмжлэгч Р.А нэхэмжлэлдээ "... түрээслүүлэгч талын төлөөлөл болох А.М нь өөрийн үл хөдлөх хөрөнгийг А.Ц-д худалдсан тул

¹⁰ №2586 дугаартай хавтаст хэргийн 14 дэх тал

2014 оны 8 дугаар сарын 20-ны дотор түрээсийн байрыг яаралтай чөлөөлөхийг амаар шаардаж, байр чөлөөлөх тухай мэдэгдлийг хаалган дээр наасан байсан. Улмаар шинэ өмчлөгч А.Ц 8 дугаар сарын 25-аас ажлын байр руу орох, гарах гол хаалгыг цоожлон, түрээсийн байрыг ус, цахилгаанаар хангахаа зогсоож, “байраа яаралтай чөлөөл, ханыг нь нурааж худалдааны танхим байгуулна” гэсэн шаардлагыг тавьсан. Иймд түрээслэгч миний бие өнөөдрийг хүртэл 5 сарын хугацаанд түрээсийн байранд нэвтэрч орж, үйл ажиллагаа явуулах ямар ч боломжгүйгээс орох байсан орлогоо алдаж, хохирсон¹¹ гэжээ. Харин хариуцагч тайлбартаа “нэхэмжлэгч Р.А-ийн нэхэмжлэл дээр дурдсан ажлын байрны орох хаалгыг цоожлон ус цахилгаанаар хангахаа зогсоож, байраа яаралтай чөлөөл гэсэн шаардлагыг тавиагүй бөгөөд харин хуучин өмчлөгч Я.Б нь байрыг чөлөөлж өгөх талаар шаардлага тавьж улмаар дээрх маргаан гарсан. ...нэг бол түрээсийн гэрээгээ шинээр хийж ажиллах, эсвэл байрыг суллаж өгөх шаардлага тавьж байна”¹² гэжээ.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2015.04.24 №2894)**

А.Ц нь гэрээний дагуу дээрх хөрөнгийг худалдан авч 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн өмчлөгч нь болсон бөгөөд өмнөх өмчлөгчийн буюу А.М, Я.Б нарын Р.А-тай байгуулсан 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн түрээсийн гэрээний дагуу эрх эдэлж, үүрэг хүлээсэн түрээслүүлэгч биш ба уг гэрээний харилцаанаас үүссэн зардал, хохирлыг А.Ц хариуцах учиргүй болно. Иргэний хуулийн 297 дугаар зүйлийн 297.1-д “Эд хөрөнгө хөлслүүлэгч нь хөлслөгчийн эзэмшилд байгаа хөрөнгөө гуравдагч этгээд буюу шинэ өмчлөгчид шилжинэ” гэж заасныг үндэслэн А.М нартай байгуулсан гэрээний харилцаанаас үүссэн зардал, хохирлыг шинэ өмчлөгч А.Ц-ээс шаардаж байгаа нь үндэслэлгүй байна¹³.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2015.07.22 №935)**

Нэхэмжлэгч Р.А нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ түрээслүүлэгч түрээсийн гэрээний үүргээ зөрчсөнөөс учирсан хохирол

¹¹ №8476 дугаартай хавтаст хэргийн 1-2 дахь тал

¹² №8476 дугаартай хавтаст хэргийн 99 дэх тал

¹³ №8476 дугаартай хавтаст хэргийн 148 дахь тал

гэж тодорхойлж, Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1 дэх хэсэгт заасныг үндэслэсэн тул түрээсийн гэрээнээс түрээслүүлэгч татгалзсан явдалд түрээслүүлэгч буруутай болохыг нэхэмжлэгч өөрөө нотлох нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт нийцнэ.

Гэтэл хэрэгт авагдсан баримтаар талууд Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг хэрэгжүүлсэн гэх байдал тогтоогдоогүй, түрээслүүлэгчийн буруутай ажиллагааг нэхэмжлэгч нотолж чадаагүй байна. Өмнөх түрээслүүлэгч А.М, Я.Б нар шүүхэд гаргасан тайлбартаа “одоогоор түрээсийн гэрээг цуцлаагүй байгаа” гэж тайлбарласан ба хариуцагч А.Ц “түрээсийн гэрээг үргэлжлүүлэн шинээр байгуулж ажиллахыг зөвшөөрсөн” гэж тайлбар гаргасан, шүүхийн шийдвэрээр түрээсийн гэрээг хүчин төгөлдөр гэж дүгнэсэн зэргээс үзэхэд Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.2 дахь хэсэгт зааснаар хариуцагч А.Ц хохирлыг хариуцах үндэслэлгүй байна.

Нэхэмжлэгч түрээсийн зүйлийг гэрээнд заасан зориулалтаар ашиглахад хариуцагч А.Ц саад учруулсан гэх байдал баримтаар тогтоогдохгүй байх ба түрээслэгчдийг ажиллуулахгүй тухай мэдэгдэл наасан гэх гэрэл зургаас өөр нотлох баримтыг нэхэмжлэгч гаргаж өгөөгүй байна. Түүнчлэн хариуцагч А.Ц нь дээрх үл хөдлөх хөрөнгийг худалдаж аваад, түрээсийн зүйлийг үргэлжлүүлэн түрээслэх саналыг нэхэмжлэгч Р.А-д тавьсан байхад гэрээ цуцалснаас учирсан хохирол шаардаж байгаа нь үндэслэлгүй байна¹⁴.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2015.10.27 №850)**

Хариуцагчийн “түрээсийн гэрээг цуцлаагүй, үргэлжлүүлж болохоор байхад нэхэмжлэгч өөрөө зөвшөөрөөгүй” гэсэн тайлбарыг шүүх үндэслэж байгаа бол нөгөө талаас “түрээсийн байрыг ус, цахилгаанаар хангахаа зогсоож, ажлын байр руу орох, гарах гол хаалгыг цоожилсон” гэсэн нэхэмжлэгчийн тайлбар, ажлын байранд түрээслэгчийг ажиллуулахгүй тухай мэдэгдэл наасан фото зураг, шүүхийн шийдвэр зэрэг баримтыг харьцуулан үнэлээгүй нь буруу юм.

Түүнчлэн, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 5138 дугаар шийдвэрээр ямар нэхэмжлэлийн шаардлага шийдвэрлэгдсэн, одоо нэхэмжлэгч Р.А-ын нэхэмжлэлийн шаардлагад аль хэсэг нь хамаарах

¹⁴ №8476 дугаартай хавтаст хэргийн 171 дэх тал

талаар шүүх дүгнээгүйгээс гадна нэхэмжлэлийн шаардлагаас түрээсийн эд хөрөнгийг засаж сайжруулахад гаргасан хөрөнгийг салгаж болох эсэх талаар тодруулаагүй нь хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлаж, хэрэглээгүй гэж үзнэ.

Тухайн маргаанд хоёр шатны шүүх холбогдох хуулийг буруу хэрэглэсэн, хяналтын шатны шүүх хэрэгт авагдсан баримтын хэмжээнд зөвтгөх боломжгүй тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр буцаах нь зүйтэй гэж үзлээ¹⁵.

- **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2015.12.07 №8476)**

Хариуцагчийн тайлбараас үзэхэд түүний шаардсаны дагуу өмнөх өмчлөгч Я.Б түрээсийн байрны гадна хаалганд байрыг чөлөөлөхийг шаардсан мэдэгдэл наасан болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь хавтаст хэрэгт авагдсан баримтаар нотлогдсон ба үүнийг түрээслэгчийн нэг талын санаачилгаар ажлын байр түрээслүүлэх гэрээг цуцалсан гэж үзэх үндэслэлтэй байна. Эдгээрээс 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан ажлын байр түрээслүүлэх гэрээ нь хүчин төгөлдөр болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон, гэрээг түрээслүүлэгч талын санаачилгаар цуцалсан үйл баримт нь хаалганд наасан мэдэгдлээр тогтоогдож байх тул хариуцагчийг ажлын байр түрээслүүлэх гэрээний 1.1-д заасан хугацаанаас өмнө үндэслэлгүйгээр гэрээг цуцалсан гэж үзлээ. Энд нэхэмжлэгч тал түрээсийн гэрээний үүргээ зөрчсөн гэх үйл баримт тогтоогдоогүй, энэ талаар маргаагүй болохыг дурдах нь зүйтэй. Иймд нэхэмжлэгч нь Иргэний хуульд зааснаар хариуцагч гэрээний үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй гэж дүгнэв¹⁶.

- **Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал
(2016.03.16 №524)**

Нэхэмжлэгч нь хариуцагчийн түрээсийн гэрээний үүргийг зөрчсөн, гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах шаардлага тавьснаас хохирол учруулсан гэж тайлбарласан боловч гэрээний үүргээ зөрчсөн хариуцагчийн гэм бурууг баримтаар нотлоогүй болно. Өөрөөр хэлбэл, хариуцагч нь гэрээний үүргээ зөрчсөнөөс нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалсан ашиг сонирхолд хохирол учруулсан гэх

¹⁵ №8476 дугаартай хавтаст хэргийн 194 дэх тал

¹⁶ №8476 дугаартай хавтаст хэргийн 234 дэх тал

үндэслэлийг нэхэмжлэгч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар баримтаар нотлоогүй байна. Иймд шүүх хохирлын хэмжээг дутуу тооцон гаргуулсан гэх нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангах үндэслэлгүй болно.

Гэвч анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэнд хариуцагч талаас гомдол гаргаагүй тул шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахгүй хэвээр үлдээх нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн үзсэн болно¹⁷.

- **Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал (2016.05.31 №630)**

Анхан шатны шүүх нэхэмжлэгч Р.А-н хохирол шаардсан нэхэмжлэлийн зарим хэсгийг нотлогдсон хэмжээгээр хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй, хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн гэж үзнэ. Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1-д “үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй”, 227 дугаар зүйлийн 227.1-д зааснаар гэрээний тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбоотой учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй” гэж тус тус заасан байна.

Хариуцагч А.Ц нь түрээсийн зүйл болох байрыг худалдан авснаас хойш байрны хаягийг өөрчилж, засвар хийн, нэхэмжлэгч Р.А-н үйл ажиллагаа явуулах боломжийг хааж, байр чөлөөлөхийг шаардаж, ажлын байр руу орох, гарах гол хаалгыг цоожлон, түрээсийн байрыг ус цахилгаанаар хангахаа зогсоосон гэх нэхэмжлэгчийн тайлбарыг хариуцагч няцаагаагүй байна. Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.2-г “нэг тал нь гэрээнээс татгалзсан явдалд нөгөө тал нь буруугүй бол энэ хуулийн 227.1-д заасан үндэслэл хамаарахгүй” гэж заасан бөгөөд А.Ц нь түрээсийн гэрээний дагуу түрээслэгч Р.А-д түрээсийн зүйлийг эзэмших, ашиглах боломжоор хангах үүргээ биелүүлээгүй, буруутай тул хохирол төлөхөөс чөлөөлөгдөхгүй¹⁸.

¹⁷ №8476 дугаартай хавтаст хэргийн 2-р хавтас 13 дахь тал

¹⁸ №8476 дугаартай хавтаст хэргийн 2-р хавтас 42 дахь тал

Хүснэгт 6. №8476 дугаартай хавтаст хэргийг шүүхэд хянан шийдвэрлэсэн ажиллагааны талаарх дүгнэлт

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015.04.06) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Нэхэмжлэгчээс шинээр нотлох баримт гаргасан тул хариуцагчийн хэргийн материалтай танилцах хүсэлтийг хүлээн авч, шүүх хуралдааныг 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 15:30-аас хэлэлцүүлэхээр хойшлуулжээ.	Иргэний процесс хуулийн 105-р зүйлийн 105.2 дахь хэсэг хэрхэн хэрэглэгдэх нь тодорхойгүй байна.
	Хурал №2 (2014.04.13) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Нэхэмжлэгчээс шинээр нотлох баримт гаргасан тул хариуцагчийн хэргийн материалтай танилцах хүсэлтийг хүлээн авч, шүүх хуралдааныг 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 13:30-аас хэлэлцүүлэхээр хойшлуулжээ.	Иргэний процесс хуулийн 105-р зүйлийн 105.2 дахь хэсэг хэрхэн хэрэглэгдэх нь тодорхойгүй байна
	Хурал №3 (2015.04.20) Хариуцагчийн өмгөөлөгчийн шүүх хурал давхардсан тул хариуцагчийн зүгээс өмгөөлөгчтэйгөө хамт шүүх хуралд оролцох хүсэлтийг гаргасныг шүүхийн зүгээс хангаж шүүх хуралдааныг 2015 оны 4 дүгээр сарын 24-ний 08:30-аас хэлэлцүүлэхээр хойшлуулжээ.	Өмгөөлөгчтэй оролцох хүсэлт гарган шүүх хуралдааныг хойшлуулах явдал нийтлэг болсон бөгөөд энэ талаар иргэний процесс хуульд тодорхой зохицуулалт оруулах шаардлагатай байна. Хэдийгээр хууль зүйн туслалцаа авах нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хэргийн оролцогчийн эрх боловч үүнээс болж нөгөө талын болон шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй тал зохих хязгаарлалтыг хийж өгөх нь зүйтэй.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хүснэгт 6-ын үргэлжлэл

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	Хурал №4 (2015.04.24) Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.	Анхан шатны шүүхийн шүүгчийн асуулт оновчгүй, хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй асуулт асуух явдал олон гарч байна.
Давж заалдах шатны шүүх	Хурал №1 (2015.07.22) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан. Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан.	Давж заалдах шүүхийн зүгээс анхан шатны хууль хэрэглээний алдааг тодорхой хэмжээнд зассан боловч хэргийн үйл баримтыг хангалттай бүрэн хэмжээнд тогтоогоогүй байна.
Дээд шүүх	Хурал №1 (2015.10.27) Дээд шүүхийн тогтоол гарсан. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.	Дээд шүүхийн хурал хуульд заасан журмын дагуу явагдсан байна.
Анхан шатны шүүх	Хурал №1 (2015.11.26) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Шүүх хуралдаан дээр хариуцагчийн өмгөөлөгчөөс сөрөг нэхэмжлэл гаргах учраас шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан ба шүүх уг хүсэлтийг хүлээн аваагүй тул шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан тул шүүгчээс татгалзах асуудлыг шийдвэрлэх хүртэл шүүх хуралдааныг хойшлуулжээ.	Шүүгчээс татгалзах явдлыг шүүх хуралдааныг хойшлуулах зорилгоор ашигладаг байдал түгээмэл болсон тул шүүгчээс татгалзах талаарх иргэний процесс хуулийн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Шүүх	Шүүх хурлын давтамж, шийдвэрлэсэн асуудал	Тайлбар, судлаачийн дүгнэлт
	<p>Хурал №2 (2015.11.30) Анхан шатны шүүх хуралдаан хойшилсон. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид товыг мэдэгдсэн боловч хүрэлцэн ирээгүй. Хэдийгээр хурал давхацсан гэсэн боловч үүнтэй холбоотой баримт ирүүлээгүй тул хүндэтгэсэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй гэж үзэн шүүх хуралдааныг үргэлжлүүлжээ. Гэвч хэргийг эцэслэн шийдвэрлэлгүй шүүх хуралдааныг 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 08 цаг 30 минут хүртэл хойшлуулжээ.</p>	<p>Шүүх хуралдаан явагдаж нотлох баримт шинжлэн судалсан байтал шүүх хуралдааныг ямар үндэслэлээр хойшлуулж буй нь тодорхой бус байна.</p>
	<p>Хурал №3 (2015.12.07) Иргэний хуулийн 227-р зүйлийн 227.1-д зааснаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас 26,544,305 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, хариуцагч А.Ц-ээс 7,908,000 гаргуулж шийдвэрлэжээ.</p>	<p>Анхан шатны шүүх хуралдаан хуульд заасан журмын дагуу явагдсан боловч мөн л хэргийн үйл баримтын талаар хангалттай мэтгэлцээн өрнөөгүй байна.</p>
<p>Давж заалдах шатны шүүх</p>	<p>Хурал №1 (2016.03.16) Давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан. Шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.</p>	<p>Анхан шатны шүүхийн чиг үүрэг буюу нотлох баримтыг шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлэх зарчмыг зөрчсөн дүгнэлтийг давж заалдах шатны шүүх хийсэн байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүх нэхэмжлэгч хариуцагчийн гэм бурууг нотолсон гэж үзсэн байхад давж заалдах шатны шүүх хариуцагчийн гэм бурууг баримтаар нотлоогүй байна гэсэн нь дээрх зарчмыг зөрчихөд хүргэж буй юм.</p>
<p>Дээд шүүх</p>	<p>Хурал №1 (2016.06.23) Дээд шүүхийн тогтоол гарсан.</p>	<p>Дээд шүүхийн хурал хуульд заасан журмын дагуу явагдсан байна.</p>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Дүн шинжилгээ

Анхан шатны шүүх хариуцагчийн тайлбарыг тодруулаагүй нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Хариуцагч хариу тайлбартаа “... Р.А нь нэг бол түрээсийн гэрээгээ хийж ажиллах, эсвэл байрыг суллаж өгөх шаардлага тавьж байна”¹⁹ гэсэн тодорхойгүй тайлбар өгсөн байхад тодруулах ажиллагаа явуулах ёстой байсан. Өөрөөр хэлбэл, хариуцагч нь шинээр түрээсийн гэрээ байгуулах хүсэл зоригтой байна уу, эсвэл гэрээг цуцлахыг хүсэж байна уу гэдгийг тодруулах ёстой юм. Шинээр түрээсийн гэрээ байгуулах эсэх нь энэ хэрэгтэй холбоогүй тул ач холбогдолгүй тайлбар болно. Харин хариуцагч тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж буй бол нэхэмжлэгч тал үүнээс болж өөрт учирсан хохирлоо шаардах эрхтэй.

3. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА

3.1. Япон Улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон судлах шалтгаан

Япон Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикийг харьцуулсан эрх зүйн хүрээнд сонгон судлах болсон нь дараах хэдэн шалтгаантай.

Нэгдүгээрт, тус улс нь Герман, Австри, АНУ зэрэг эрх зүйн өндөр хөгжилтэй орны иргэний процессын хуулийн зохицуулалт, шүүхийн практик, онолыг судалж, өөрийн орны эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикийг ямагт сайжруулсаар ирсэн. Хоёрдугаарт, тус улс нь 1996 онд Иргэний процессын хуулийг шинэчлэн найруулахаас өмнө иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд маш их цаг хугацаа, зардал шаарддаг байсан төдийгүй шүүх хурал ихээр хойшилдог байсныг 5 дугаар сарын ойр ойрхон зогсолтгүй орох бороотой жишихэд хүртэл хүрсэн байсныг өөрчилж чадсан туршлагатай орон юм. Гуравдугаарт, тус улс нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийг янз бүрээр хуульчилж, уг ажиллагааны үр нөлөөг байнга сайжруулсаар ирсэн. Үүний сацуу мэтгэлцэх зарчим болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүгчийн оролцооны эрх хэмжээ, чиг үүргийн тэнцвэрт харьцааг ямагт эрэлхийлж, судалж ирсэн бөгөөд энэ талаарх

¹⁹ №8476 дугаартай хавтаст хэргийн 2-р хавтас 99 дэх тал

хууль зүйн зохицуулалт, шүүхийн практик, онолын тайлбар тодорхой түвшинд хөгжсөн тул тус улсын туршлагыг энэхүү судалгааны хүрээнд товч ч гэсэн судлах нь манай улсад нэн ач холбогдолтой гэж үзлээ.

3.2. 1996 оны Иргэний процессын хуулийн шинэчлэл

Япон Улсын анхны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 1877 онд батлагдсан Герман Улсын мөн хуулийг загвар болгож боловсруулагдсан бөгөөд 1890 онд батлагдаж, 1891 оноос хэрэгжиж эхэлжээ. 1926 онд уг хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж, 1929 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлснээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон хэдий ч дахин бүхэлд нь шинэчлэн найруулалгүй байсаар 1996 онд тус хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж, 1998 оноос дагаж мөрдөж эхэлжээ²⁰. Ийнхүү тус хуулийг 70 гаруй жилийн дараа шинэчлэн найруулах болсон шалтгааныг дараах хэдэн хүчин зүйлээр тайлбарладаг.

Нэгдүгээрт, тус хууль хэрэгжиж эхэлсэн үеэс хойш нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, улс орны хөгжил хувьсал, иргэний хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргээс шалтгаалан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нь өнөөгийн нийгмийн нөхцөл байдалд тохирохгүй болсон.

Хоёрдугаарт, иргэний хэргийн шүүхээр үйлчлүүлэхэд хэт их цаг хугацаа, зардал шаарддаг гэсэн шүүмжлэл иргэдийн дундаас гарч, анкет судалгааны үр дүнг авч үзсэн ч иргэдийн дийлэнх нь нэлээн том л хэрэгт орооцолдоогүй бол шүүхэд хандахгүй гэсэн бодолтой явдаг гэж хариулж байжээ. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд нэн яаралтай иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулж, иргэдэд хялбар дөхөм, ойлгомжтой болгохгүй бол иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хязгаарлаж, иргэний хэргийн шүүхийн нийгэмд гүйцэтгэх чиг үүргийг сулруулж болзошгүй гэж үзсэн.

Гуравдугаарт, сүүлийн жилүүдэд шүүгч болон өмгөөлөгчдийн зүгээс иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны практикийг

²⁰ 東京弁護士会 民事訴訟問題等特別委員会[編]『民事訴訟代理人の実務II 争点整理』(青木書院、2011年)、Токиогийн Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Иргэний процессын асуудлыг судлах тусгай хороо “Иргэний процесс дахь итгэмжлэгдсэн төлөөлөгчийн практик 2: Урьдчилсан хэлэлцүүлэг”, 2011 он, 39-40 дэх тал

сайжруулах зорилготой бүхий л арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн боловч хуулийг өөрчлөхгүйгээр явагдаж байгаа энэхүү арга хэмжээнд хязгаар байх тул иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдсан²¹.

Ийнхүү цаг хугацааны аясаар нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд нийцэхгүй болж, практикийн хуульчдын хүчин чармайлтаар засаж сайруулах боломжгүй, цаг хугацаа, зардал их шаарддаг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөн шинэчлэхийн тулд заавал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дахин бүхэлд нь шинэчлэн найруулах шаардлага үүсэж, 1996 онд тус хуулийг баталж дараах 4 гол асуудлыг хуульчилсан байна. Үүнийг дэлгэрүүлж авч үзье.

1. *Урьдчилсан хэлэлцүүлгийн хэлбэрүүдийг хуульчилж, шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааг сайжруулахыг зорьсон.* Дээр дурдсанчлан иргэний хэргийн шүүхээр үйлчлүүлэхэд маш их цаг хугацаа шаарддаг байсан асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрт шатанд буюу үндсэн шүүх хуралдааны өмнө талуудын тайлбар, нотлох баримтуудыг цэгцэлж, нотлох зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлыг тодорхойлж, түүнд холбогдсон үр нөлөөтэй нотлох баримт шинжлэн судлах ажиллагааг хэрэгжүүлснээр хэргийг илүү үр дүнтэй, шуурхай шийдвэрлэх боломжтой гэж үзсэн²². Ингээд нээлттэй шүүх хурлын танхимд явагдах урьдчилсан хэлэлцүүлэг (164-р зүйл), хаалттай танхимд явагдах урьдчилсан хэлэлцүүлэг (168-р зүйл), талууд шүүхэд хүрэлцэн ирэлгүйгээр бичгээр явагдах бэлтгэл ажиллагаа (175-р зүйл) гэсэн 3 төрлийн урьдчилсан хэлэлцүүлгийн хэлбэрийг хуульчилж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааны шат болон шүүх хуралдааны шат гэсэн 2 үе шатанд тодорхой заагласан. Энэхүү судалгаагаар тус зохицуулалтын талаар илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

2. *Нотлох баримт цуглуулах арга хэрэгслийг өргөжүүлсэн.* Ялангуяа эсрэг тал болон гуравдагч этгээдээс нотлох баримтыг олж авах ажиллагааг боловсронгуй болгосон. Тодруулбал, эсрэг тал болон гуравдагч этгээдээс нотлох баримтыг олж авах ажиллагааг

²¹ 柳田幸三「新民事訴訟について」(ジュリスト、№1098、1996.10.1)、ヤナギ Козо “Шинэ Иргэний процессын хуулийн талаар” Жүристано сэтгүүл №1098 дугаар, 18 дахь тал

²² 22 дахь эшлэлийн 20 дахь тал

боловсронгүй болгосон²³. Гэвч нөгөө талаас, нотлох баримт цуглуулах арга хэрэгслийг хэт өргөтгөснөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маш их хугацаа, зардал шаардагдах, мөн тэдгээр арга хэрэгслийг урвуулан ашиглах зэрэг хүндрэлүүд үүсэж болзошгүйг анхаарах шаардлагатайг онцолж байжээ²⁴. Ингээд тус хуулийн шинэчилсэн найруулгаар энэ асуудалд онцгойлон анхаарсан бөгөөд шүүгчийн захирамжаар гаргуулах боломжтой нотлох баримтыг өргөжүүлснээс (220.4-р зүйл) гадна процедурыг нь тодорхой болгож, талуудын тайлбар, нотлох баримтаа бэлтгэхэд дэмжлэг болох зорилгоор нэг талын зохигч нь нөгөө талаасаа тайлбар, нотлох баримтаа бэлтгэхэд шаардлагатай асуудлаар тодорхой хугацаа өгч, бичгээр хариу авахыг шаардах боломжтой болсон (163-р зүйл).

3. Бага үнийн дүнтэй хэргийг шуурхай шийдвэрлэх тусгай процедурыг бий болгосон. Тодруулбал, 300,000 иенээс (7,500,00 орчим төгрөг) доош үнийн дүнтэй нэхэмжлэлийг нэг удаагийн хурлаар хэлэлцэж, шүүхийн шийдвэрийг даруй гаргана²⁵. Мөн шүүхийн шийдвэрийн дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа хариуцагчийн төлбөрийн чадварыг харгалзан үзэж, төлбөрийг хуваан төлүүлэх, эсхүл үүргийн гүйцэтгэлийг тодорхой хугацаагаар хойшлуулж болохоор зохицуулсан²⁶.

4. Улсын дээд шүүхэд гомдол хүлээн авах эсэхийг урьдчилан хянан шалгах тогтолцоог бий болгохын зэрэгцээ давж заалдах шатны шүүхээс Дээд шүүхэд гомдол гаргах зөвшөөрөл авах зохицуулалтыг бий болгосноор Дээд шүүхэд үүсээд байсан хэт ачааллыг багасгахыг зорьсон. Улсын дээд шүүхэд гомдол гаргах үндэслэлийг зөвхөн Үндсэн хууль зөрчсөн, заавал гомдол гаргах шаардлагатай тохиолдол гэдгээр хязгаарласны (312-р зүйл) сацуу хууль зөрчсөн гэдэг үндэслэлийн тухайд гомдол хүлээн авах эсэхийг урьдчилан хянан шалгах тогтолцоог бий болгосон²⁷. Ингэснээр хууль тайлбарлан хэрэглэхтэй холбоотой асуудлыг агуулаагүй гомдол бол хэрэг үүсгэхгүйгээр шууд буцаадаг байх (318-р зүйл), хууль тайлбарлан хэрэглэхтэй холбоотой гомдлын тухайд давж заалдах шатны шүүхийн зөвшөөрлийг авсны дараа Улсын дээд шүүхэд гомдол гаргадаг байхаар зохицуулсан (337-р зүйл). Эдгээр

²³ 22 дахь эшлэлийн 20 дахь тал

²⁴ 22 дахь эшлэлийн 21 дэх тал

²⁵ Мөн тэнд.

²⁶ Мөн тэнд.

²⁷ Мөн тэнд.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зохицуулалтыг хийж өгснөөр Улсын дээд шүүх нь Үндсэн хууль зөрчсөн, хуулийг нэг мөр тайлбарлан хэрэглээгүй тохиолдлуудыг шийдвэрлэх чухал чиг үүргээ хангалттай түвшинд биелүүлэх боломжтой болно гэж үзсэн байна²⁸.

Эдгээр хууль зүйн зохицуулалтууд нь бүгд өнөөгийн манай улсын иргэний хэргийн шүүхийн практикт ч тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэхэд нэн хамааралтай билээ. Гэвч энэхүү судалгааны ажлын цар хүрээнээс хамаарч шүүхийн шийдвэр хүчингүй болохоос урьдчилан сэргийлэх хамгийн чухал аргад тооцогдох урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлж, шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааг сайжруулахтай холбоотой зохицуулалтуудыг дор дэлгэрүүлэн авч үзье.

3.3. Урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх хууль зүйн зохицуулалт

1891 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (1877 оны Герман Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг загвар болгосон) санхүүгийн тооцоололтой холбоотой зөвхөн онцгой ээдрээ төвөгтэй хэрэгт шүүгч нь урьдчилсан хэлэлцүүлэг явуулах боломжтойгоор зохицуулж байсан (208, 266-р зүйл). Энэ нь маш хязгаарлагдмал хүрээний хэрэгт шүүхийн шатны өмнөх бэлтгэл ажиллагааг хэрэгжүүлж байсан гэсэн үг юм²⁹.

1929 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар (тухайн цаг үедээ хамгийн шинэлэг байсан Австрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг загвар болгосон) анхан шатны орон нутгийн шүүх нь бүх иргэний хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар зохицуулсан боловч практикт төдийлөн хэрэгжиж чадаагүй байна (249-р зүйл)³⁰.

1948 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж байгаа хэрэгт шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар зохицуулсан (249-р зүйл). Үүний дараа 1950 онд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмаар тухайн хэргийг бүрэлдэхүүнтэй болон дангаар шийдвэрлэж байгааг

²⁸ Мөн тэнд.

²⁹ 21 дэх эшлэлийн 39 дэх тал

³⁰ 21 дэх эшлэлийн 39-40 дэх тал

үл харгалзан шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар өөрчилсөн (журмын 9-11-р зүйл). Гэвч мөн л эдгээр нэмэлт өөрчлөлт нь тавьж байсан зорилгодоо хүрч чадаагүй байна³¹.

1956 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журамд урьдчилсан хэлэлцүүлгийг зөвхөн ээдрээ төвөгтэй хэрэгт явуулах (журмын 16, 17-р зүйл), шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааг урьдчилсан шинжтэй шүүх хуралдааны хэлбэрээр явуулахаар заасан (журмын 26-29-р зүйл). Гэвч эдгээр зохицуулалт ч амжилт олоогүй байна³².

Ийнхүү Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тусгайлсан журмаар урьдчилсан хэлэлцүүлгийг хуульчилж, шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааг сайтар хангуулахыг дэмжиж ирсэн боловч практикт амжилт олохгүй байсан нь дараах хэдэн шалтгаантай гэж үздэг³³. Үүнд (i) Урьдчилсан хэлэлцүүлгийг удирдан явуулж байгаа шүүгчийн эрх хэмжээ тодорхойгүй, практик туршлага төдийлөн сайн байгаагүй, (ii) Урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа явагдахгүй бөгөөд уг шатанд гаргаагүй тайлбар, нотлох баримтыг шүүх хуралдааны шатанд гаргаж болохгүй зохицуулалттай (хуулийн 255-р зүйл) байсны улмаас нотолгооны ач холбогдол багатай тайлбар, нотлох баримтыг ч уг шатанд гаргаж байсан (дараа нь нотолгооны чадвараа алдах учраас), (iii) Урьдчилсан хэлэлцүүлэгт шүүгчийн туслах оролцож, заавал тэмдэглэл хөтөлдөг (хуулийн 250-р зүйл) байсан нь тэдний ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байсан, (iv) Урьдчилсан хэлэлцүүлэг дууссаны дараа нотлох баримтыг нэг дор шинжлэн судлахтай холбоотой зохицуулалт байхгүй байснаас гадна шүүгч, өмгөөлөгч нар нь шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааны ач холбогдлыг сайн ойлгож, ухамсарлаагүй байсантай холбоотой гэж үздэг байна.

1985 он хүртэлх иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагаатай холбоотой хууль зүйн зохицуулалтууд хангалттай түвшинд хэрэгжиж чадахгүй байсны улмаас шүүх ч, хэргийн оролцогчид ч шүүх хуралдаанд сайн бэлдэлгүйгээр

³¹ 21 дэх эшлэлийн 40 дэх тал

³² Мөн тэнд.

³³ 21 дэх эшлэлийн 40-41 дэх тал

оролцох, шүүх хуралдаан нь талууд тайлбараа бичгээр гаргаж, хоорондоо солилцоод дуусдаг ажиллагаа болж хувирсан байв³⁴. Мөн маргааны зүйлийг олж тогтоолгүйгээр талууд тайлбар, нотлох баримтыг ихээр гаргадаг шүүх хуралдаанууд ар араасаа үргэлжилж, шүүх хуралдаан хэлбэрийн төдий зүйл болон хувирч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч эхэлсэн байна³⁵. Энэ байдлыг тухайн үед 5 дугаар сарын бороотой (5 дугаар сард ойр ойрхон зогсолтгүй бороо ордогтой адилтгасан) жишин зүйрлэдэг байжээ³⁶.

Ингээд 1985 оноос 1990 оны эхэн хүртэлх хугацаанд шүүхээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөтэй, шуурхай явуулах талаар арга хэмжээ авч, түүнд өмгөөлөгч нар идэвхтэй оролцох болсон байна. Тухайн цагт авсан нэг томоохон арга хэмжээ нь талуудын тайлбар, нотлох баримтыг цэгцэлж, маргааны зүйлийг олж тогтоох зорилготой урьдчилсан хэлэлцүүлэг болон талуудыг эвлэрүүлэх ажиллагааг нэгтгэсэн “Бэнронкэнвакай” гэдэг ажиллагааг нийт шүүхэд нэвтрүүлсэн явдал юм³⁷. Энэхүү ажиллагаа нь бэлтгэл ажиллагааны өрөө, талуудыг эвлэрүүлэх өрөө, шүүгчийн өрөө зэрэг шүүх хуралдааны танхимаас бусад шүүхийн байрны өрөөнд шүүгч, зохигчид болон тэдний өмгөөлөгчид цуглаж, шүүх хуралдаанаар хэлэлцэх маргаантай асуудал, түүнд холбогдох шинжлэн судлах шаардлагатай нотлох баримтуудыг тогтоох мөн цаашлаад талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авах зорилготой хаалттай урьдчилсан хурал байв³⁸. Гэвч тус ажиллагаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлттэй байдал, талуудын тэгш оролцоог хангах, ямар процесс ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой эсэх нь тодорхойгүй тул хууль зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзжээ³⁹. Энэ нөхцөл байдал нь 1996 онд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах гол үндэслэл болсон юм.

Одоогийн хэрэгжиж буй хуулиар хэргийн мөн чанар, агуулга, цар хүрээ, ээдрээ төвөгтэй байдал, талуудын шүүхэд хүрэлцэн ирэх боломжтой байдал зэрэгт тохируулан дараах 3 төрлийн урьдчилсан

³⁴ 21 дэх эшлэлийн 41 дэх тал

³⁵ Мөн тэнд.

³⁶ Мөн тэнд.

³⁷ Мөн тэнд.

³⁸ Мөн тэнд.

³⁹ Мөн тэнд.

хэлэлцүүлгийг сонгон хэрэглэх боломжтой.

(1) **Нээлттэй урьдчилсан хэлэлцүүлэг** (хуулийн 164-167 дугаар зүйл, журмын 86-87 дугаар зүйл) гэдэг нь шүүхээс шүүх хуралдааныг маргааны зүйл болон хэрэгт хамааралтай нотлох баримтыг тогтоох зорилготой урьдчилсан шинжтэй шүүх хуралдаан болон тэдгээр нотлох баримтыг шинжлэн судлах үндсэн шүүх хуралдаан гэсэн 2 үе шатанд заагласныг ойлгоно⁴⁰. Тус урьдчилсан хэлэлцүүлэг нь нээлттэй шүүх хуралдааны танхимд явагдана. Иймд нийгмийн анхаарлыг татсан хэрэг, хэргийн оролцогч, холбогдогч олонтой хэрэгт тохиромжтой гэж үздэг⁴¹. Шүүхээс уг ажиллагаа шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэрэгжинэ (хуулийн 164-р зүйл). Өөрөөр хэлбэл, уг ажиллагааг эхлүүлэхэд талуудын саналыг авах шаардлагагүй, шүүхийн өөрийн эрх хэмжээний асуудал юм. Уг ажиллагаанд шүүх хуралдааны нээлттэй, амаар, шууд явагдах, талуудын тэгш оролцоог хангах зэрэг зарчмууд үйлчлэх бөгөөд нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа явагдах боломжтой.

Маргааны зүйл болон шинжлэн судлах шаардлагатай нотлох баримтуудыг тогтоосны дараа шүүхийн тогтоолоор уг ажиллагаа дуусгавар болно. Шүүх уг ажиллагааг дуусгавар болгохдоо дараагийн нотлох баримт шинжлэн судлах ажиллагаанд нотлох шаардлагатай хэргийн бодит нөхцөл байдлыг талуудаас дахин нэг удаа нягтална (хуулийн 165.1). Энэ тохиолдолд шүүх шаардлагатай гэж үзвэл нотлох шаардлагатай хэргийн бодит нөхцөл байдлын талаар шүүгчийн туслахаар урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгуулна (журмын 86.1). Мөн шүүх шаардлагатай гэж үзвэл урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнг талуудаас бичгээр гаргуулж авахыг шаардаж болно (хуулийн 165.2).

Урьдчилсан хэлэлцүүлэг дууссаны дараа уг ажиллагааны явцад гаргаагүй тайлбар, нотлох баримтыг гаргасан талаас эсрэг тал нь шаардан гаргасан тохиолдолд түүнд яагаад өмнө нь гаргаагүй үндэслэлээ тайлбарлах ёстой бөгөөд шүүх хуралдаанаас бусад үед уг тайлбарыг гаргах тохиолдолд бичгээр гаргана (хуулийн 167-р зүйл, журмын 87-р зүйл).

(2) **Хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг** (хуулийн 168-174 дүгээр зүйл, журмын 88-90 дүгээр зүйл) нь зөвхөн онцгой тохиолдолд зарим

⁴⁰ 21 дэх эшлэлийн 42 дахь тал

⁴¹ Мөн тэнд.

этгээдийн хувьд нээлттэй явагдах боломжтой ажиллагаа юм⁴². Шүүх нь тухайн хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг шаардлагатай гэж үзвэл талуудын саналыг авч, хэргийг урьдчилсан хэлэлцүүлэгт шилжүүлнэ (хуулийн 168 дугаар зүйл). Хаалттай явагддаг хэдий ч шүүх нь (i) Урьдчилсан хэлэлцүүлэгт оролцуулах нь зохистой гэж үзсэн этгээд (хуулийн 169.2), (ii) Зохигчид урьдчилсан хэлэлцүүлэгт оролцуулахаар хүсэлт гаргасан этгээдийн хувьд уг ажиллагааг явуулахад саад учруулж болзошгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд оролцуулахыг зөвшөөрдөг. Саад учруулж болзошгүй этгээд гэдэгт (i) Тухайн этгээд нь ажиллагааны явцад дураараа үг хэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй тохиолдол, (ii) Өөр этгээд уг ажиллагаанд байснаар зохигчид биеэ барьж, чөлөөтэй мэтгэлцэж чадахгүй болж, ажиллагааны үр нөлөөг буруулж болзошгүй тохиолдол, (iii) Шүүх хуралдааны танхимаас бусад шүүхийн байрны өрөөнд явагддаг тул суудлын хүрэлцээ муу байгаа тохиолдлыг ойлгодог⁴³. Уг ажиллагааны явцад шүүх талуудыг тайлбараа бичгээр гаргахыг шаардах (хуулийн 170.1), бичгийн нотлох баримтыг шинжлэн судлах, нотлох баримттай холбоотой талуудын хүсэлтийг шийдвэрлэх зэрэг асуудлыг хэлэлцэх боломжтой. Ерөнхийдөө гэрчийн мэдүүлэг авахаас бусад бүх процесс ажиллагааг явуулах бололцоотой.

Уг ажиллагаа дуусгавар болох үед дараагийн нотлох баримт шинжлэн судлах ажиллагаанд нотлох шаардлагатай хэргийн нөхцөл байдлыг талуудаас дахин нэг удаа тодруулах (хуулийн 170.5, 165.1), шүүх шаардлагатай гэж үзвэл уг ажиллагааны үр дүнг талуудаас бичгээр гаргуулж авах боломжтой (хуулийн 170.5, 165.2) хэдий ч ийнхүү бичгээр гаргуулах нь нэн ховор бөгөөд амаар нягтлан асуудаг байна. Уг ажиллагаа дуусгавар болсны дараа тайлбар, нотлох баримт шинээр гаргасан зохигчоос эсрэг тал нь шаардлага гаргасан тохиолдолд түүнд уг ажиллагаа дуусгавар болохын өмнө эдгээр тайлбар, нотлох баримтыг гаргаагүй үндэслэлийг тайлбарлах ёстой (хуулийн 174, 167 дугаар зүйл). Энэхүү тайлбарыг уг ажиллагааны явцад амаар гаргаснаас бусад тохиолдолд заавал бичгээр гаргах ёстой (журмын 87.1) бөгөөд амаар гаргасан тохиолдолд ч эсрэг тал нь уг тайлбараа бичгээр гаргаж өгөхийг шаардаж болно (журмын 87.2). Энэ нь эсрэг тал болон түүний өмгөөлөгчийн хувьд

⁴² 21 дэх эшлэлийн 42 дахь тал

⁴³ 21 дэх эшлэлийн 103-104 дэх тал

уг тайлбар нь (i) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 157 дугаар зүйлд зааснаар санаатай болон хэт хайхрамжгүйгээр оройтож гаргасан тайлбар болон нотлох баримт болохыг нотлох чухал баримт болгох, (ii) Үндэслэлтэй тайлбар гаргаж чадахгүй тохиолдолд эсрэг талын оройтож гаргасан тайлбар, нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим, агуулгатай харьцуулж, нотолгооны чадварыг нь бууруулан үнэлэх шүүгчийн дотоод итгэл үнэмшлийг бий болгож болзошгүйг анхаарах шаардлагатай юм⁴⁴.

(3) Бичгээр явагдах бэлтгэл ажиллагаа (хуулийн 175-178 дугаар зүйл, журмын 91-94 дүгээр зүйл) нь Герман Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 276 дугаар зүйлээс санаа авч бий болсон бөгөөд талууд шүүхэд хүрэлцэн ирэлгүйгээр зөвхөн бичгээр тайлбар, нотлох баримтыг солилцож, явагдана⁴⁵. Тус зохицуулалтыг хуульчилсан зорилго нь зохигчид алс хол газар оршин суудаг, зохигчид шүүхэд биечлэн хүрэлцэн ирэхэд хүндрэлтэй байгаа зэрэг тохиолдолд зохигчдод учрах бэрхшээлийг бууруулахын зэрэгцээ шүүх хуралдааны товыг тогтооход төвөгтэй байгаагийн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахаас сэргийлж, тухайн хэргийн маргааны зүйлийг эрт олж тогтоох боломжийг бүрдүүлэхэд оршдог аж⁴⁶. Шүүхийн практикт уг ажиллагааг маргааны зүйл нь харьцангуй ойлгомжтой, хялбар хэрэгт хэрэглэх нь түгээмэл байна.

Зохигчид алс газар оршин суудаг эсхүл энэхүү ажиллагааг зохистой гэж үзсэн бусад тохиолдолд шүүх талуудын саналыг авч, хэргийг уг ажиллагаанд шилжүүлдэг (хуулийн 175-р зүйл). Ийнхүү талуудын саналыг авах нь уг ажиллагаагаар тухайн хэргийн маргааны зүйлийг олж тогтоох боломжтой эсэхийг шийдвэрлэхийн тулд асуудаг байна. Уг ажиллагааг зөвхөн даргалагч шүүгч (зохигчдыг биечлэн оролцуулалгүйгээр хэрэгжүүлдэг тул практикийн арвин туршлагатай шүүгч байх нь зохимжтой гэж үздэг) удирдан явуулдаг. Бичгээр явагддаг ажиллагаа тул даргалагч шүүгч талуудыг тайлбараа бичгээр гаргах хугацааг тогтоодог (хуулийн 176.2) бөгөөд ингэснээр тус ажиллагааг удаашрахаас сэргийлдэг байна.

⁴⁴ 21 дэх эшлэлийн 107 дахь тал

⁴⁵ 21 дэх эшлэлийн 42 дахь тал

⁴⁶ 21 дэх эшлэлийн 110 дахь тал

Уг ажиллагаа дуусгавар болоход дээр дурдсан хоёр төрлийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалттай нэгэн адил шүүгч дараагийн нотлох баримт шинжлэн судлах шатанд нотлох шаардлагатай хэргийн нөхцөл байдлыг талуудаас дахин нэг удаа нягтлан асуудаг (хуулийн 177 дугаар зүйл). Мөн шүүгч шаардлагатай гэж үзвэл уг ажиллагааны эцсийн үр дүнг талуудаас бичгээр хураангуйлж авах боломжтой (хуулийн 176.4, 165.2). Түүнчлэн уг ажиллагаа дуусгавар болсны дараа талууд шинээр тайлбар, нотлох баримт гаргах бол өмнө нь гаргаж чадаагүй үндэслэлээ тайлбарлах ёстой (хуулийн 178 дугаар зүйл).

1996 оны хуулиас өмнөх хуучин хуулийн 255.1-д урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гаргаагүй нотлох баримтыг уг ажиллагаа дууссаны дараа гаргавал нотолгооны чадвараа алдана гэж заасан. Гэтэл практикт өөрт байгаа нотлох баримтыг нотолгооны чадвараа алдахаас эмээсэн талууд шаардлагатай, шаардлагагүй бүх нотлох баримтуудыг урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гаргаж, энэ нь эсрэгээрээ маргааны зүйлийг хэт өргөжүүлж, шүүгчийн ачааллыг нэмэгдүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төвөгтэй болгож байсан⁴⁷.

Энэ нөхцөл байдлыг засаж сайжруулахын тулд 1996 оны хуулиар урьдчилсан хэлэлцүүлгийн хурал дууссаны дараа шинээр нотлох баримт гаргах тохиолдолд эсрэг талын шаардсанаар уг ажиллагаа дуусахаас өмнө эдгээр нотлох баримтыг гаргаж чадаагүйг зөвтгөх үндэслэлээ тайлбарлах ёстой гэж зохицуулсан (хуулийн 167, 174, 178-р зүйл, журмын 87, 90, 94 дүгээр зүйл). Ингээд гаргасан нотлох баримтыг хүлээж авахыг зөвтгөх үндэслэлээ гаргаж чадахгүй бол хугацаандаа гаргаагүй нотлох баримт болон санаатайгаар хожимдож гаргасан нотлох баримт гэдгээр шүүх хүлээн авахаас татгалзах, нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй байх эрхтэй байна⁴⁸.

⁴⁷ 21 дэх эшлэлийн 260-261 дэх тал

⁴⁸ 21 дэх эшлэлийн 262-263 дахь тал. Гэвч практикт урьдчилсан хэлэлцүүлгийн хурал дууссаны дараа гаргаж байгаа нотлох баримтыг хүлээж авах нь элбэг байгаа бөгөөд эсрэг талаас ч хуульд заасан тайлбар хүсэх эрхээ хэрэгжүүлэхгүй байдал ажиглагдаж байгаа аж. Энэ нь урьдчилсан хэлэлцүүлгийн хурлын ач холбогдлыг бууруулж байна гэсэн шүүмжлэл дагуулсан тул тохиромжтой хугацаандаа гаргаж чадаагүй нотлох баримтыг хүлээж авах, үнэлэхээс татгалзах зэргээр талуудыг илүү хариуцлагатай байлгах зохицуулалт хуульд шаардлагатай байгааг судлаачид дэвшүүлж байгаа юм.

3.4. Урьдчилсан хэлэлцүүлгээс бусад хууль зүйн зохицуулалт, шүүхийн практик

3.4.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дундын хурал

Уг ажиллагаа нь шүүх хуралдаан дээрх талуудын мэтгэлцээн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөтэй болгох зорилготой бөгөөд шүүх хуралдаанаас бусад үед шүүгч болон талууд шүүх хуралдаан дээрх нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа, тухайн хэргийн маргааны зүйлтэй холбоотой асуудал болон тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх явцад шийдвэрлэх шаардлагатай бусад асуудлын талаар хоорондоо хэлэлцэх боломжтой хурал юм (журмын 95 дугаар зүйл).

Уг хурлыг зохигч талууд оролцох боломжтой өдөр товлон хийх ёстой (журмын 95.1.1) боловч энэ нь тухайн хэргийн маргааны зүйлийг тогтоохтой холбоотой урьдчилсан хэлэлцүүлэг биш тул шинээр нотлох баримт гаргах боломжгүй⁴⁹. Гэхдээ нөгөө талаас, нэхэмжлэлийн шаардлагаас татгалзах, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх зэргээр талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгохыг хориглоогүй. Мөн талууд энэхүү хурлын үеэр эвлэрэх боломжтой эсэх талаар тодорхой зохицуулалт байхгүй тул талууд эвлэрэх хүсэлтэй байгаа тохиолдолд эвлэрэх зорилготой тусдаа хурал зарлаж, ажиллагааг явуулах нь зүйтэй байна⁵⁰.

Энэ хурлын үеэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах талаар төлөвлөгөө гаргах, оюуны өмч, барилга, эмчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой тусгай мэдлэг шаардсан маргаан дээр холбогдох салбарын мэргэжилтнийг оролцуулж, схем, загвар ашиглаж хэргийн бодит нөхцөл байдлын талаар тайлбар хийх, мөн шүүхээс өөр газар буюу хэргийн газар очиж танилцах ингэснээр гэрч асуух, шинжээч томилох, үзлэг явуулах шаардлагатай асуудал болон түүний арга хэлбэрийг ярилцаж тогтдог байна⁵¹. Мөн өөр байгууллагаас нотлох баримт гаргуулах, судалгаа хийлгэх, шинжээч томилохтой холбоотой бэлтгэл ажиллагаа, түүнтэй холбоотой талуудын саналыг авах зорилгоор зохион байгуулагддаг⁵².

⁴⁹ 21 дэх эшлэлийн 112 дахь тал

⁵⁰ Мөн тэнд.

⁵¹ 21 дэх эшлэлийн 112-113 дахь тал

⁵² 21 дэх эшлэлийн 113 дахь тал

3.4.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөлт

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар талуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урьдчилан төлөвлөж явуулахыг үүрэг болгосон (хуулийн 147.2). Мөн ээдрээ төвөгтэй хэргийн тухайд шүүх зохигчидтой зөвлөлдөж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөгөөг гаргах ёстой (хуулийн 147.3). Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөгөө гэдэгт (i) Тухайн хэргийн маргааны зүйл болон шинжлэн судлах шаардлагатай холбогдох нотлох баримтыг олж тогтоох, (ii) Гэрч болон зохигчдоос мэдүүлэх авах хугацаа, (iii) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болж, шүүхийн шийдвэрийг гаргах урьдчилсан хугацааг тогтоох шаардлагатай (хуулийн 147.3.2). Мөн тайлбар, нотлох баримтыг гаргах ёстой хугацаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулахад шаардлагатай асуудлыг тогтооно (хуулийн 147.3.3, 156.2).

Ихэвчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урьдчилан төлөвлөдөг хэргийн төрлүүдэд (i) Том цар хүрээтэй хэрэг, (ii) Хувьцаа, бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авахтай холбоотой маргаан, эзэмшил газрын хил хязгаарыг тогтоохтой холбоотой маргаан, өв залгамжлуулсан хөрөнгийн хэмжээг тогтоохтой холбоотой маргаан, нэр хүнд гутаан доромжлогдсонтой холбоотой маргаан, галын даатгалын төлбөртэй холбоотой маргаан зэрэг тодорхой төрлийн маргаанууд, (iii) Тусгай мэдлэг шаардсан маргаан, (iv) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан хэрэг, (v) Зохигчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан төлөвлөгөө гаргахыг тохиролцсон болон тухайн хэргийн маргааны зүйл нь ээдрээ төвөгтэй, өмнө нь ховор гарч байсан асуудлыг агуулсан маргаанууд хамаардаг байна⁵³.

Шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, талуудын оролцооны байдал болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж, шаардлагатай гэж үзвэл зохигчидтой ярилцан тохирсны дагуу эхний гаргасан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно (хуулийн 147.3.4). Энэ нь гаргасан төлөвлөгөөг ягштал даган биелүүлэх нь гол зорилго бус харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохистой бөгөөд шуурхай явуулахад гол ач холбогдол нь оршино.

⁵³ 21 дэх эшлэлийн 116 дахь тал

Шүүхийн практикт гаргасан төлөвлөгөөг баримтлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь ховор боловч түүний үзэл санаа нь сайн төлөвшиж байгаа гэж үздэг байна⁵⁴. Мөн Токиогийн зарим шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа нэг хурал дууссаны дараа дараагийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг ярьж тохирох бус 2-3 удаагийн уулзалт, хурлын асуудлыг урьдчилан тохирох, шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагааны дуусгавар болох хугацаа, талуудын тайлбар, нотлох баримт гаргах хугацааг тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох хүртэлх хугацааг 6 сар, 9 сар, 1 жил, 1 жил хагас гэх мэтээр хугацааг ерөнхийд нь тогтоох байдлаар дээрх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа жишиг байгаа аж⁵⁵.

3.4.3. Шүүгчийн тодруулах эрх

Шүүгчийн тодруулах эрх гэдэг нь талуудын шаардлага, татгалзал, түүнтэй холбогдох тайлбар, мэдүүлэг дэх гол санаа орхигдсон, зөрчилдөөнтэй, тодорхойгүй, алдаатай хэсэгт талуудын анхаарлыг хандуулж, улмаар тэдгээрийг засах, нөхөх, буцаан татах боломжийг талуудад олгох, хэрэгт шаардлагатай нотлох баримтыг гаргуулахыг дэмжих агуулгатай шүүхийн эрх хэмжээ юм⁵⁶. Энэхүү тодруулах эрхийн дагуу хэргийн бодит нөхцөл байдал болон хууль зүйн холбогдолтой асуудлыг асууж тодруулдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 149.1-д “Шүүх талуудад асуулт тавьж, түүнийг нотлохыг шаардаж болно” гэж заасан тул энэ нь шүүхийн эрх хэмжээ төдийгүй нөгөө талаас үүрэг ч гэж хэлж болно. Шүүх нь энэхүү эрхийг шүүх хуралдаан төдийгүй урьдчилсан хэлэлцүүлэг дээр ч хэрэгжүүлэх боломжтой (хуулийн 170.5). Шүүх бүрэлдэхүүнтэй хэргийн хувьд энэхүү эрхийг даргалагч шүүгч хэрэгжүүлэх (хуулийн 149.1) бөгөөд бусад шүүгч нь даргалагч шүүгчид мэдэгдсэний дараа энэхүү эрхийг хэрэгжүүлж болно (хуулийн 149.2).

Шүүгчийн тодруулах эрхийн зорилго нь онолын хувьд (i) Тухайн хэргийн бодит үнэнд нийцсэн зүй зохистой шүүхийн шийдвэр гаргах, (ii) Талуудын тэгш байдлын зарчмыг бодитоор хэрэгжүүлэх, (iii) Шүүх

⁵⁴ Мөн тэнд.

⁵⁵ 21 дэх эшлэлийн 117 дахь тал

⁵⁶ 21 дэх эшлэлийн 245 дахь тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

болон талуудын мэдээллийн зөрүүтэй байдал, мөн талуудын хоорондын хүчний тэнцвэргүй байдлыг аль алийг нь нөхөхийн тулд оршдог гэж тайлбарладаг⁵⁷.

Дээр дурдсанчлан, шүүгчийн тодруулах эрхийг үүрэг ч гэж ойлгодог тул шүүх нь тодруулах шаардлагатай асуудлыг тодруулаагүй тохиолдолд тодруулах үүргийн зөрчил гаргасан гэж үздэг байна⁵⁸. Ингэснээр давж заалдах (хуулийн 312.3) болон дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл болдог (хуулийн 318.1). Дээд шатны шүүхэд “Шүүхийн шийдвэрт нөлөө үзүүлэх нь гарцаагүй хуулийн зөрчил байна” гэж үзвэл (хуулийн 325.1, 2) уул шүүхийн шийдвэр хүчингүй болно. Сүүлийн жилүүдийн шүүхийн шийдвэрийн жишгээс харахад шүүгчийн тодруулах эрхийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлж байна⁵⁹.

3.4.4. Шүүгчийн тодруулах эрхийн хэмжээ хязгаар

Энэ тухайд (i) Идэвхгүй тодруулга (талуудын гаргаж байгаа тайлбар, мэдүүлэгт тодорхойгүй, зөрчилдөөнтэй, гол санаа орхигдсон, урьдчилан бэлтгээгүй зэрэг байдал байгаа тохиолдолд тэдгээрт залруулга хийх), (ii) Идэвхтэй тодруулга (талуудын тайлбар, мэдүүлэг нь хэргийн нөхцөл байдалд нийцээгүй, эсхүл талууд зохистой тайлбар, мэдүүлэг гаргахгүй байгаа тохиолдолд шүүх түүнийг нь хэлж, зааж чиглүүлэх) гэж хоёр ангилах бөгөөд идэвхгүй тодруулгыг хийгээгүй тохиолдолд шүүх энэ үүргээ зөрчсөн гэж үзнэ⁶⁰. Харин идэвхтэй тодруулгыг хийгээгүй тохиолдолд тухайн хэргийн нөхцөл байдал, олон талын эрх ашгийг харгалзан үзэж, шүүх үүргээ зөрчсөн эсэх, эрх хэмжээгээ хэтрүүлсэн эсэхийг шийдвэрлэдэг байна⁶¹. Тодруулбал, дараах 5 тохиолдлыг харгалзан үздэг.

1. Шүүхийн шийдвэр дэх ялалт, ялагдлыг өөрчлөх магадлалтай байгаа тохиолдол гэдэг нь зохистой тодруулах эрхийг хэрэгжүүлбэл талуудын ялалт, ялагдалд өөрчлөлт гарч, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт чухал өөрчлөлт орох магадлал өндөр байгаа тохиолдлыг ойлгох бөгөөд энэ тохиолдолд шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрнө.

⁵⁷ 21 дэх эшлэлийн 247 дахь тал

⁵⁸ Мөн тэнд.

⁵⁹ Мөн тэнд.

⁶⁰ 21 дэх эшлэлийн 248 дахь тал

⁶¹ 21 дэх эшлэлийн 249 дэх тал

2. Талуудын тайлбар, мэдүүлэг дэх материаллаг хууль зүйн зохицуулалтыг оновчгүй сонгосныг залруулах гэдэг нь талуудын гаргасан тайлбар, нотлох баримт, тухайн хэргийн нөхцөл байдлаас үзэхэд талуудын сонгосон материаллаг эрх зүйн зохицуулалт нь оновчгүй, хэрэглэх ёстой хэм хэмжээний талаарх шүүх болон талуудын санал зөрөөтэй байгаа тохиолдолд түүнийг залруулсан шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрнө.

3. Хүлээлтийн байдал үүсгэсэн тохиолдол гэдэг нь шүүхээс тодруулга хийхгүй тохиолдолд талууд зохистой тайлбар, нотолгоо гаргаж чадахааргүй янзтай бол шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрнө.

4. Талуудын тэгш байдлыг хангах гэдэг нь хэрэгт холбогдох тухайн нэг асуудлаар шүүгч тодруулга хийх нь талуудын тэгш байдлыг илтэд алдагдуулахаар бол шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрөхгүй.

5. Бусад тохиолдол гэдэг нь шүүгч идэвхтэй байр сууринаас тодруулга хийснээр тухайн хэргийг үндсээр нь шийдвэрлэж, дахин маргаан гарахаас урьдчилан сэргийлэх боломжтой тохиолдолд шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрч, эсрэгээрээ шүүгч тодруулга хийснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илтэд удаашруулах боломжтой тохиолдолд шүүгчийн тодруулах эрхийг хүлээн зөвшөөрдөггүй байна.

Энэхүү шүүгчийн тодруулах эрх нь мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж болзошгүй гэж үздэг хэдий ч тус улсын шүүхийн практикт өргөнөөр хэрэгжиж байна. Энэ нь өмгөөлөгч, үйлчлүүлэгчтэйгээ, мөн эсрэг талтайгаа харилцах харилцаанд өөрөө манлайлан талуудын тайлбарыг цэгцтэй авч үзэж, маргааны зүйлийг олж тогтоох нь ихэнх тохиолдолд бэрхшээлтэй байдаг. Энэ тохиолдолд гуравдагч этгээд болох шүүгч нь талуудад тухайн хэрэгт чухал байж болох маргааны зүйлийг нь зааж чиглүүлэн, тэр талаар талуудын хооронд мэтгэлцээн өрнүүлж, тухайн хэрэгт шаардлагагүй маргааны зүйл, тайлбарын тухайд үнэхээр шаардлагатай эсэх талаас нь дахин нэг судалж үзэхийг нь сануулах, тайлбар, үндэслэлийг нь асуух гэх мэтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцохгүй бол тухайн хэргийн маргааны зүйл нь тодорхой болохгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг гэж үздэгтэй холбоотой байна.

3.4.5. Шүүгч дотоод итгэл үнэмшлээ ил болгох хэрэгцээ шаардлага

Уламжлалт хандлагаар шүүгч нь төвийг сахисан, хөндлөнгийн байх зарчмын шаардлагын үүднээс өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил гаргах нь шүүхийн шийдвэрээр хязгаарлагдана гэж үздэг байв⁶².

Гэвч сүүлийн жилүүдэд иргэний хэргийг зөв, оновчтой шийдвэрлэхийн тулд шүүгч талуудын байр суурийг сонсохын сацуу хамтдаа тухайн хэргийн талаар дүгнэлт гаргах нь чухал тул аль болох өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил гаргах нь зүйтэй гэх хандлага гарч ирсэн⁶³. Энэхүү хандлагын үүднээс авч үзвэл, шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээ ил болгох нь дараах хоёр чиг үүрэгтэй гэж үздэг. Үүний нэг нь эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг олж тогтооход шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээ ил болгох нь тустай байдаг байна. Тодруулбал, нэхэмжлэгчийн шаардлага, хариуцагчийн татгалзлаас тухайн хэргийн маргааны зүйл шууд тодрох нь бэрхшээлтэй. Мөн талууд хэрэгт төдийлөн ач холбогдолгүй зүйлийг ярьж, маргах ч тохиолдол элбэг. Энэ тохиолдолд нотлох баримт бүрдүүлж, шинжлэн судлах шаардлагагүй асуудлыг маргааны зүйлээс хасаж, нотлох баримтаар зайлшгүй шинжлэн судлах шаардлагатай маргааны зүйлийг талуудын мэтгэлцээнээс гаргаж ирэхэд шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээ ил болгох нь ач холбогдолтой юм. Талуудын тайлбар, үндэслэлд гарч буй хэрэгт төдийлөн ач холбогдолгүй асуудлын талаар шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгож, шүүгч болон талууд харилцан ойлголцсоноор тухайн асуудлыг маргааны зүйлээс хасах боломжтой⁶⁴.

Энэ төрлийн шүүгчийн дотоод итгэл үнэмшлийг дотор нь гурав ангилж авч үздэг⁶⁵. (i) Маргааны зүйлийг хэлж чиглүүлэх (маргаантай байгаа хэргийн нөхцөл байдал болон хууль зүйн асуудал нь юу болох талаар шүүгчийн ойлголт, ухамсрыг ил болгох), (ii) Хуулийн холбогдолтой асуудлаар байр сууриа илэрхийлэх (тухайн хэрэгт холбогдох хуулийн зохицуулалтыг сонгох, түүний агуулгын талаар шүүгч байр сууриа илэрхийлэх), (iii) Явцуу утгатай шүүгчийн дотоод

⁶² Ясүй “Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох хэрэгцээ шаардлага” 安井「裁判官の心証開示の必要性－証明負担軽減に際しての心証開示－」, 4 дэх тал

⁶³ Мөн тэнд, 7 дахь тал

⁶⁴ Мөн тэнд.

⁶⁵ Мөн тэнд.

итгэл үнэмшил (нотлох шаардлагатай үйл баримтын талаар шүүгч өөрийн шийдвэрийг илэрхийлэх) гэсэн төрөл байна.

Дараагийн шүүгчийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох чиг үүрэг нь талуудыг эвлэрүүлэхэд оршино гэж үздэг⁶⁶. Өөрөөр хэлбэл, нотлох баримт шинжлэн судалсны дараа шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох нь шүүхийн шийдвэрийн агуулгыг урьдчилан танилцуулж буйтай ижил төстэй тул талуудыг эвлэрүүлэхэд түлхэц болдог байна. Мөн шүүгч эвлэрлийн санал гаргаж, талуудын эвлэрлийг дэмжиж байгаа тохиолдолд талууд шүүгчээс өөрийн дотоод итгэл үнэмшлээ ил болгохыг шаардах эрхтэй гэж үздэг. Энэ нь талууд эвлэрлийн санал болон гарч болох шүүхийн шийдвэрийн агуулгыг харьцуулан авч үзсэнээр аль нэгийг нь сонгох боломжтой болдог байна.

3.4.6. Шүүгчийн мэдэгдэх үүрэг

Зохигчдын маргаж байгаа хууль зүйн үндэслэл болон тухайн хэргийг шийдвэрлэх гэж буй шүүхийн талаас гаргаж байгаа хууль зүйн үндэслэл харилцан өөр байх тохиолдолд шүүх тухайн үндэслэлд тулгуурлан маргааныг шийдвэрлэхээс өмнө энэ тухайгаа зохигчдод мэдэгдэж, тухайн хууль зүйн үндэслэлийн талаар зохигчид тайлбар гаргах, нотлох ажиллагаа явуулах боломжоор хангах үүрэгтэй байна⁶⁷. Энэ нь шүүгчийн тодруулах эрхээс ялгаатай бөгөөд тусдаа ойлголт болохыг судлаачид тэмдэглэдэг.

Шүүгч нь (i) Зохигчид анзаараагүй эсхүл чухал бус гэж үзсэн хууль зүйн үндэслэл бөгөөд тэр нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болох боломжтой бол энэ талаар зохигчдод мэдэгдэх үүрэгтэй, (ii) Холбогдох хууль зүйн үндэслэлийн асуудлаар шүүгч зохигчдод мэдэгдэх ёстой байдал нь шүүгч энэхүү үүргийг хэрэгжүүлэх үндэслэл болно⁶⁸. Энэхүү үүргийг шүүгчид оногдуулсан нь талуудын мэтгэлцэж буй хууль зүйн үндэслэлээс өөр хууль зүйн үндэслэлээр талуудын мэдүүлсэн үйл баримтад тулгуурлан шүүгч тэдэнд урьдчилан мэдэгдэхгүйгээр шүүхийн шийдвэр гаргах нь талуудын хувьд гэнэтийн шийдвэр болох тул шүүгч

⁶⁶ Мөн тэнд, 7-8 дахь тал

⁶⁷ Хамазаки “Хууль зүйн үндэслэлийг мэдэгдэх үүрэг болон шүүгчийн тодруулах үүргийн харилцан уялдааны талаар” 濱崎 録「法的観点指摘義務と釈明義務の關係について」(熊本法学130号、2014年), 156 дахь тал

⁶⁸ Мөн тэнд, 166 дахь тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

нь үүнийг заавал тэдэнд мэдэгдэж, тэдний мэтгэлцэх эрхийг хангах нь зүйтэй гэж үздэг⁶⁹.

Тэгвэл шүүгчийн тодруулах эрх (үүрэг) гэдэгт тодорхойгүй, ойлгомжгүй байдлын тодруулга, хэрэгт ач холбогдолгүй, хамааралгүй асуудлыг хасах тухай тодруулга, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэхтэй холбоотой тодруулга, шинээр нотлох баримт гаргуулахтай холбоотой тодруулга гэх мэт олон янз байна. Дээрх үүргээс ялгаатай нь шүүгч зохигчдын мэдүүлж буй хууль зүйн үндэслэл хангагдах эсэхийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтын тодорхойгүй, дутуу байдлыг хэлж заах, шаардлагатай нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргуулах зорилготой байдаг⁷⁰.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар Дээд шүүхээс ямар үндэслэлээр хэргийг хүчингүй болгож, дахин хянан хэлэлцүүлэхээр буцааж буй үндэслэлүүдийг олж мэдэх, тэдгээр алдаа, зөрчлүүд гарахад нөлөөлсөн хүчин зүйл юу байв, дахин тэдгээр алдаа, зөрчлийг гаргахаас урьдчилан сэргийлэх арга байгаа эсэхийг судлахад судалгааны гол зорилго оршиж байв. Суурь судалгаа болох үүднээс нийт үндэслэлээ судлах, тэдгээрийг багцалж ангилахад гол анхаарал хандуулсан бөгөөд цаашид гурав ангилсан алдаа зөрчил бүрд хамаарах нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай болохыг тэмдэглэх нь зүйтэй. Энэ удаад ерөнхий бөгөөд өргөн цар хүрээний асуудлыг хөндөхөөс өөр аргагүй байсныг дурдъя. Ингээд судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэснээ хүргэе.

2015 онд Дээд шүүхээр хянагдаад хүчингүй болж, дахин хянан хэлэлцүүлэгдэхээр буцаагдсан иргэний хэргийн шүүхийн нийт 107 шийдвэр, магадлалын үндэслэлийг судлахад эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй, энэ харилцааг зөв тодорхойлсон ч хэргийн үйл баримтыг бүрэн тогтоогоогүйгээс хэрэг хүчингүй болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан байна. Мөн үүний сацуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн холимог зөрчлүүд давамгайлж байна.

⁶⁹ Мөн тэнд.

⁷⁰ Мөн тэнд.

Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт зохигчдын тайлбар ойлгомжтой, бүрэн бичигддэггүй, үндэслэх хэсэгт хэрэгт авагдсан нотлох баримтыг хэргийн үйл баримт бүртэй субсумци хийж, шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй бичдэггүй зэргээс шалтгаалан шүүхийн шийдвэр ихэвчлэн товч гардаг бөгөөд тухайн хэргийн талаар бүрэн ойлголт авах боломжгүй байх тохиолдол үүсдэг. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж, судлаачид шүүхийн шийдвэрийн үндэслэлийг унших төдий бус тухайн маргааны хавтаст хэрэгтэй бүрэн танилцах нь маргааны агуулга болон процесс ажиллагааны алдаа, зөрчлийг гүйцэд ойлгох боломж бүрдэхээс гадна судалгааны өндөр ач холбогдолтой гэж үзсэн.

Судалгааны цар хүрээ болон нөөц бололцоонд тулгуурлан шүүхийн практикт түгээмэл шийдэгддэг зээлийн болон түрээсийн гэрээтэй холбоотой маргааны хавтаст хэргийг сонгон авч, дүн шинжилгээ хийхийг оролдлоо. Ингэхдээ эрх зүйн харилцааг зөв тодорхойлоогүй, хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн зэрэг холимог зөрчил гарсан хэргийг сонгохыг хичээсэн болно. Нийт дөрвөн хэргийн хавтаст хэрэгт судалгаа хийсэн бөгөөд гурван шатны шүүхийг 4 тойрсон хэрэг 1, хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа 11 сар, гурван шатны шүүхийг 6 тойрсон хэрэг 3, хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа нь 1 жил 1 сар, 1 жил 2 сар, 1 жил 8 сар тус тус байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маш удаашралтай байсныг илтгэж байгаа юм. Зарлагдсан шүүх хурлууд нь өмгөөлөгч авах, зохигчдын аль нэг талын өмгөөлөгч ирээгүй, шинээр нотлох баримт шаардагдсан, хүсэлт шийдвэрлүүлэх, шүүгчээс татгалзсан, хэргийн оролцогчийн (тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч) шүүх хуралд урьдчилан бэлтгээгүй байдал зэргээс шалтгаалж хойшилсон байв.

Хэрэг хүчингүй болоход нөлөөлсөн гол хүчин зүйл нь шүүх нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагаа хэрхэн нотолж буйг тодруулж асуух, шаардлагатай нотлох баримтыг гаргахыг сануулах, шүүх нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болон хариуцагчийн хариу тайлбарыг тодруулаагүй явдал байв. Энэ нь шүүгч талуудын мэтгэлцээнээс маргааны зүйлийг олж тогтоох, түүнийг нотлоход шүүхийн мэтгэлцээнийг чиглүүлэхийн тулд зохигчдоос шаардлага, татгалзлын үндэслэлийг нь тодруулах, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримтыг гаргах талаар талуудад сануулах зэргээр

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

шүүгчийн идэвхтэй оролцоо дутмаг байгаа нь ажиглагдсан. Шүүх хурал дээр тухайн хэргийн үйл баримтыг тодруулах, шаардлагатай нотлох баримтыг гаргуулахтай холбоотой талуудаас оновчтой асуулт, тодруулга хийж чадахгүй, шүүх хурлыг удирдан явуулах ур чадвар дутмаг байгаа нь шүүх хурлын тэмдэглэлээс харагдаж байв. Үүний цаад учир шалтгааныг нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал өндөр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримталж буй хугацаа богино, шүүхийн захиргааны ажилтны мэргэшсэн, тогтвортой байдал алдагдсан, хэргийн оролцогчдын ялангуяа өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх зүйн ухамсар, хандлага төлөвшөөгүй зэргээр тайлбарлаж болох талтай. Гэвч энэхүү судалгаагаар эдгээр шалтаг шалтгаанаас илүүтэйгээр процессын хуулийг нэн даруй шинэчилж, тогтолцооны өөрчлөлт хийх (урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх), мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандахь шүүгчийн оролцооны чиг үүргийг тодорхой болгох, үүнийг дагаад шүүгч нар мэргэжлийн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэх, ялангуяа шүүх хурал удирдах, хэргийн оролцогчтой харилцах харилцааны ур чадварыг дээшлүүлэх нэн шаардлагатай байгааг онцлох нь зүйтэй.

Ингээд харьцуулсан эрх зүйн судалгааны үр дүнд үндэслэж, дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Санал

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урьдчилсан хэлэлцүүлэг болон үндсэн шүүх хурал гэж тодорхой зааглан ялгах. Урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй байлгах үүднээс хаалттайгаар, шүүх хурлын бус танхимд явуулах.
2. Урьдчилсан хэлэлцүүлэгт нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын үндэслэлийг тодруулах, маргааны зүйлийг олж тогтоох, шаардлагатай нотлох баримтуудыг цуглуулж, бүрдүүлэх, хэрэгт ач холбогдолтой, хамааралтай хүсэлтүүдийг шийдвэрлэдэг байх.
3. Хүндэтгэн үзэх шалтгаантай байснаа үндэслэлтэйгээр тайлбарласнаас бусад тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг дууссаны дараа гаргасан тайлбар, нотлох баримтыг хүлээн авахаас татгалзах зохицуулалтыг бий болгох.

4. Үндсэн шүүх хурал дээр урьдчилсан хэлэлцүүлгээс гарсан үр дүнг танилцуулж, зохигчид болон гэрчээс мэдүүлэг авч шүүх хурлыг хаах. Учир нь талууд болон гэрчээс мэдүүлэх авах нь нээлттэй байх зарчимд үндэслэх ёстой.
5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг тухайн хэргийн онцлог, шүүх хурлын өмнөх бэлтгэлээс хамаарч тухай бүр тохирч, төлөвлөдөг байх.
6. Шүүгч хэргийн үйл баримт болон хууль зүйн холбогдолтой асуудлаар талуудаас тодруулах асуулт тавих үүрэгтэй байхаар хуульчлах.
7. Шүүгч гэнэтийн шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй байхаар хуульчлах.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон үндэслэлийн
дэлгэрэнгүй жагсаалт

№	Огноо	Тогтоо- лын дугаар	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон үндэслэл		
1	2015.01.08	4	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
2	2015.01.08	7	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
3	2015.01.15	22	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
4	2015.01.20	25	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
5	2015.01.27	48	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
6	2015.01.27	49	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
7	2015.02.05	75	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
8	2015.02.10	92	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	

9	2015.02.12	95	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
10	2015.02.26	102	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй
11	2015.03.03	112	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
12	2015.03.03	117	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
13	2015.03.03	119	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
14	2015.03.05	125	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
15	2015.03.05	127	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
16	2015.03.10	136	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
17	2015.03.10	143	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

18	2015.03.12	151	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
19	2015.03.17	156	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
20	2015.03.19	166	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй
21	2015.03.19	168	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
22	2015.03.19	173	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
23	2015.03.24	179	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
24	2015.03.26	191	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
25	2015.04.14	235	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
26	2015.04.16	245	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
27	2015.04.21	247	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	

28	2015.04.21	252	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй		
29	2015.04.21	253	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
30	2015.04.23	258	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
31	2015.04.28	269	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
32	2015.04.28	271	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
33	2015.04.28	273	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
34	2015.05.07	291	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
35	2015.05.07	295	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
36	2015.05.12	301	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
37	2015.05.14	322	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

38	2015.05.19	326	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
39	2015.05.21	344	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
40	2015.05.26	348	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
41	2015.05.26	352	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
42	2015.05.26	357	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
43	2015.05.28	368	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
44	2015.06.09	393	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
45	2015.06.11	394	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
46	2015.06.11	401	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
47	2015.06.12	407	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	

48	2015.06.16	420	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
49	2015.06.16	428	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
50	2015.06.19	451	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
51	2015.06.23	492	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
52	2015.06.23	499	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
53	2015.06.25	510	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
54	2015.06.30	529	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	
55	2015.06.30	537	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
56	2015.09.11	562	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
57	2015.09.17	590	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

58	2015.09.17	606	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй
59	2015.09.18	616	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
60	2015.09.18	622	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
61	2015.09.24	657	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
62	2015.09.25	672	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
63	2015.09.25	677	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
64	2015.09.29	682	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
65	2015.10.29	687	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
66	2015.01.01	698	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
67	2015.10.01	700	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	

68	2015.10.01	715	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
69	2015.10.05	717	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
70	2015.10.06	743	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
71	2015.10.06	748	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
72	2015.10.06	750	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
73	2015.10.13	765	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
74	2015.10.13	767	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн		
75	2015.10.13	770	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
76	2015.10.13	772	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		
77	2015.10.20	805	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй		

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

78	2015.10.20	807	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
79	2015.10.20	812	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
80	2015.10.22	825	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
81	2015.10.23	841	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
82	2015.10.27	850	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй
83	2015.10.27	852	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
84	2015.10.27	853	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
85	2015.10.27	856	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
86	2015.10.29	864	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
87	2015.10.29	872	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн

88	2015.10.29	873	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
89	2015.11.17	938	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
90	2015.11.17	939	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
91	2015.11.24	970	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
92	2015. 11.24	979	Эрх зүйн харилцааг зөв тодорхойлж чадаагүй	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй
93	2015.11.24	981	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
94	2015.11.26	998	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
95	2015.12.01	1006	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	
96	2015.12.01	1008	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
97	2015.12.01	1010	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

98	2015.12.03	1040	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
99	2015.12.04	1042	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
100	2015.12.04	1044	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
101	2015.12.08	1064	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
102	2015.12.10	1083	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	
103	2015.12.15	1100	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
104	2015.12.17	1108	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
105	2015.12.17	1113	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
106	2015.12.22	1137	Хэргийн үйл баримт бүрэн тогтоогдоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
107	2015.12.23	1152	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж, Дээд шүүхийн зөвлөмж

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
2. “Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлоход анхаарах зарим асуудал” Дээд шүүхийн зөвлөмж, 2016 он
3. “Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа” Дээд шүүхийн зөвлөмж, 2016 он
4. “Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах ажиллагааны эрх зүйн үндэслэл” Дээд шүүхийн зөвлөмж, 2018 он
5. Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 1996 он, 民事訴訟法
6. Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журам, 1996 он, 民事訴訟規則

Ном, гарын авлага

1. Д.Хуяг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудал”, 2013 он
2. Улсын дээд шүүх “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, Нэмэлт өөрчлөлттэй 2 дахь хэвлэл, 2008 он
3. И.Кают “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, 2015 он
4. Хамтын бүтээл “Процессын эрх зүйн онол, туршлага”, 2014 он
5. ШЕЗ, “Монгол Улсын Шүүхийн тайлан”, 2014-2019 он
6. 伊藤 眞・山本和彦[編]『民事訴訟の争点』(有斐閣、2009年)
7. 小島武司[編]『よくわかる民事訴訟法』(ミネルヴァ書房、2013年)
8. 東京弁護士会 民事訴訟問題等特別委員会『民事訴訟代理人の実務II 争点整理』(青木書院、2011年)
9. 和田吉弘『基礎からわかる民事訴訟法』(商事法務、2012年)

Өгүүлэл, нийтлэл, судалгааны материал

1. “Давж заалдах болон хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл, төрөл” ШЕЗ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Судалгааны тайлангийн эмхэтгэл”, 2014 он, 60-85 дахь тал
2. 濱崎 録「法的観点指摘義務と釈明義務の関係について」(熊本法学 130号、2014年)
3. 柳田幸三「新民事訴訟について」(ジュリスト、No.1098、1996.10.1)
4. 安井「裁判官の心証開示の必要性—証明負担軽減に際しての心証開示—」

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС
ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА
Шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн
дүн шинжилгээ

Н.Норовсамбуу (LL.M)

Багийн ахлагч, МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш

Р.Пүрэвбаатар (LL.M)

МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш

АГУУЛГА

1. УДИРТГАЛ	88
2. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	90
3. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	92
3.1. Автомашин барьцаалагчид холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №1, №2, №3)	92
3.2. Ажилтны учруулсан гэм хорд холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №4, №6)	98
3.3. 499.3-т холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №5)	100
3.4. 497-р зүйл болон 499-р зүйлийн хэрэглээнд холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №7, №8)	101
3.5. Бусад шийдвэр (Хэрэг №4 №9, №10)	102
4. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	105
4.1. ЯПОН	105
4.1.1. Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хууль болон Иргэний хуулийн харилцан хамаарал ...	105
4.1.2. “Тээврийн хэрэгслийг ашиглагч”-ийг тодорхойлох нь	107
4.1.3. Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлийн урьдчилсан нөхцөл	114
4.2. ХБНГУ	116
4.2.1. Тээврийн хэрэгслийн хамаарах этгээдийн хариуцлага ба харьцуулалт	116
4.2.2. Хуулийн тайлбар	119

5. ДҮГНЭЛТ	125
ХАВСРАЛТ	128
Хэрэг №1. 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00048 УДШ-ийн тогтоол	128
Хэрэг №2. 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр, Дугаар: 001/ХТ2017/00817 УДШ-ийн тогтоол	130
Хэрэг №3. 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдөр, Дугаар: 001/ХТ2016/00827 УДШ-ийн тогтоол	133
Хэрэг №4. 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр, Дугаар: 001/ХТ2017/00402 УДШ-ийн тогтоол	136
Хэрэг №5. 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00076 УДШ-ийн тогтоол	139
Хэрэг №6. 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/00783 УДШ-ийн тогтоол	143
Хэрэг №7. 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр, Дугаар: 001/ХТ2017/01131 УДШ-ийн тогтоол	145
Хэрэг №8. 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00341 УДШ-ийн тогтоол	148
Хэрэг №9. 2018 оны 6 дугаар сарын 17-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/00995 УДШ-ийн тогтоол	151
Хэрэг №10. 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/01042 УДШ-ийн тогтоол	153

1. УДИРТГАЛ

Монгол Улсад зам тээврийн ослын улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрах магадлал өндөр байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор Иргэний эрх зүй дэх Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалт буюу Иргэний хуулийн 499-р зүйлийн дагуу шүүхээр хохирол нөхөн төлөхийг шаардах нэхэмжлэл цөөнгүй гарсан байна¹. Энэхүү зөрчил Улаанбаатар хотын хэмжээнд түгээмэл гарч байгаа бөгөөд иргэдэд учрах хохирол жил ирэх тутам нэмэгдсээр байгааг дараах тоон мэдээллүүдээс харах боломжтой.

2017 оны байдлаар техникийн хяналтын үзлэгт орсон нийт 536,399 автомашин байгаа бөгөөд эдгээрээс 280,000 гаруй нь Улаанбаатар хотод ашиглагдаж байна². Мөн 2017 оны байдлаар нийт 36,591 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 32,662 буюу 89.3 хувь нь Улаанбаатар хотын замд тохиолджээ³. 2018 оны зөвхөн эхний улиралд гэхэд нийт 7,568 зам тээврийн осол бүртгэгдсэн бөгөөд зам тээврийн ослын улмаас учирсан хохирол өмнөх оныхоос даруй 84.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна⁴. 2019 оны байдлаар нийт 25,302 зам тээврийн осол гарсан нь өмнөх оныхоос 26.5 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт ослын 97.9 хувь нь жолоочийн гэм буруутай үйлдлээс болсон гэж үзжээ⁵.

Манай улсад зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн хувьд урьдчилсан нөхцөл болон ерөнхий ба тусгай зохицуулалт хоорондын харилцан хамаарал бүрэн шийдвэрлэгдээгүй⁶ төдийгүй, тус эрх зүйн нөхцөл бүрийг тайлбарлах нь нэлээд хүндрэл, бэрхшээлтэй байдаг.

Иргэний хуулийн 499-р зүйлийн хариуцлага хүлээлгэх урьдчилсан нөхцөлийн талаар харьцуулсан эрх зүйн төдийгүй, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийсэн судалгаа харьцангуй цөөн байгаа

¹ 2015 оны 6 дугаар сарын 30-аас хойших иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг л аваад үзэхэд нийт 100 гаруй шүүхийн шийдвэрийн илэрц байна. <http://new.shuukh.mn/irgenanhan>

² 2017 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машины тоо, (насжилтаар, бүс, аймаг, сум, жилээр), Статистик мэдээллийн нэгдсэн сан, <http://www.1212.mn>

³ Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоон үзүүлэлт танилцуулга <http://traffic.police.gov.mn>

⁴ http://transportation.police.gov.mn/resource/traffic/media/Statistic/DUN_SHINJILGEE_TANILTSUULGA_-2018-1_uliral.pdf

⁵ <http://transportation.police.gov.mn/a/4068>

⁶ Р.Пүрэвбаатар “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг нотлох үүргийн онолын үүднээс тайлбарлах нь” Шүүх эрх мэдэл сэтгүүл 2018 оны №3-ыг үзнэ үү.

бөгөөд 499-р зүйлтэй холбоотойгоор “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэж хэнийг ойлгох, түүний хүрээ хязгаарыг хэрхэн тодорхойлох, “тээврийн хэрэгслийг ашиглах явцад” гэдгийг хэрхэн ойлгох, онолын ямар хувилбарууд байж болох эсэх, жолоочийн хариуцлагыг хэрхэн шийдвэрлэх эсэх гээд олон асуулт үүсэж болдог.

Гэм хорын эрх зүйн хариуцлага хүлээлгэх урьдчилсан нөхцөлийн талаарх онолыг авч үзвэл үндсэндээ (i) Гэм бурууг үндэслэн хариуцлага хүлээлгэх зарчим, (ii) Гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим (Англи-Америкийн эрх зүй дэх *strict liability* гэх ойлголтын хувьд “хатуу хариуцлагын зарчим” гэж орчуулагдан хэрэглэгдэж байна. Тус зарчмыг ч мөн адил гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмын нэг хувилбар гэж тайлбарладаг.), (iii) Холимог зарчим гэх мэт хэд хэдэн онолын хувилбар байх бөгөөд иргэний хуулийн 499-р зүйл нь гэм бурууг урьдчилсан нөхцөлийн хүрээнд тодорхойлдоггүйгээрээ гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх (гэм буруу гэх нөхцөлийг урьдчилсан нөхцөлийн бүрэлдэхүүнд хамааруулдаггүй) зарчимд тулгуурласан хэм хэмжээ болно.

Энэхүү гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимтай холбоотойгоор (i) Аюултай эд зүйлийн эзэмшигч, өмчлөгчид хүлээлгэх хариуцлага, (ii) Аюултай эд зүйлийг ашиглан ашиг орлого олж буй этгээдэд хариуцлага хүлээлгэх зэрэг онолын ойлголтууд үүсэж хөгжсөн байна.

Тухайлбал, “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэх ойлголтыг түүхэн үүднээс нь тайлбарлахад Иргэний хуулийн 501-р зүйл дэх “амтныг эзэмшигч” гэх ойлголтоос бий болсон гэх тайлбар байх бөгөөд түүнчлэн зарим тохиолдолд Иргэний хуулийн 498-р зүйлийн зарим онолыг ч ашиглах боломжтой гэж зарим улс оронд тайлбарлаж байна⁷.

Иймд тус судалгаагаар иргэний хуулийн 499-р зүйлийн талаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, үр дүнд нь тулгуурлан харьцуулсан эрх зүйн судалгаа хийхийг зорилоо.

⁷ Шиоми Ёшио, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй I Шинзанша хэвлэлийн компани 331-р тал 潮見佳男「不法行為法 I」信山社、311 頁以降。

2. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2002 онд батлагдсан Иргэний хуулийн 499-р зүйл нь дотроо 4 хэсэгтэй. Харьцуулсан эрх зүйн үүднээс дүгнэвэл, энэ зохицуулалтыг боловсруулахад ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн зохицуулалт ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үзэж болно (ХБНГУ-ын талаарх харьцуулсан судалгааг үзнэ үү). Яагаад “нөлөө үзүүлсэн” гэх үгийг хэрэглэсэн бэ гэвэл Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн зохицуулалттай харьцуулахад Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалт дөрөвхөн хэсэгтэй бөгөөд рецепц хийсэн гэж дүгнэх боломжгүй байгаатай холбоотой.

499-р зүйлийн 499.1 дэх хэсэгт “Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч нь учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж заасан бөгөөд 497-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэхэд “гэм буруу” гэх урьдчилсан нөхцөлийг заавал шаарддаг бол 499-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэхэд уг нөхцөлийг шаарддаггүйгээрээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, “гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим”-д суурилсан хэм хэмжээ гэж дүгнэх боломжтой гэсэн үг.

Судлаачдын хувьд тус зохицуулалтыг хэрхэн дүгнэсэн талаар авч үзье. Юуны түрүүнд 2016 онд Улсын Дээд Шүүхээс эрхлэн гаргасан “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV” бүтээлд “Тээврийн хэрэгслийг ашиглах явцад үүссэн гэм хорыг арилгах явдал нь гэм хороос үүсэх үүргийн нэр төрөл бөгөөд хууль тогтоогч гэм хор үүссэн объектоос нь хамаарч хуулиар тусгайлан зохицуулсан тул энэ утгаараа Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх заалтаас ялгаатай” хэмээн дүгнэсэн байна⁸. Өөрөөр хэлбэл, тус бүтээлд урьдчилсан нөхцөлийн хувьд бус харин объектын нь хувьд ялгаатай байдлаар хуульчилсан гэж дүгнэсэн байгаа болно. Энэ нь Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийг хооронд нь зүйлчлэлийн хувьд ялгадаг гэмт хэргийн

⁸ Монгол Улсын Дээд Шүүх, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (гэрээний бус үүрэг) IV” УБ., 2016 он, 61-р тал

бүрэлдэхүүний чиг хандлагатай нэлээд төстэй арга зүйг ашигласан мэт харагдаж байна.

Бусад судлаачийн бүтээлээс харьцуулан үзвэл, 2005 онд хэвлэгдсэн “Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй” хэмээх бүтээлд “Монгол Улсын Дээд Шүүхийн 1997 оны 497-р тогтоолд орчин тойрондоо аюул учруулж болох зүйл гэдэгт төрөл бүрийн авто, механикжсан тээврийн хэрэгсэл ...” гэж тайлбарласан болохыг дурдаад 502, 499, 501-р зүйлүүдийг нэг категорид хамааруулан тайлбарлажээ. 497-р зүйлээс ялгагдах гол онцлогийн хувьд “Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлсээс учирсан гэм хорыг арилгахад уг үйл ажиллагааг явуулж байгаа этгээд болон уг эд зүйлсийг эзэмшиж, өмчилж байгаа этгээд гэм буруутай эсэхээс үл харгалзан гэм хорыг бүрэн хэмжээгээр хариуцан арилгах үүргийг хүлээдгээрээ гэм хороос үүсэх үүргийн бусад төрлөөс ялгагддаг” хэмээн тайлбарласан байгаа нь “гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим”-д суурилсан зохицуулалт болохыг нь хүлээн зөвшөөрснийг илтгэж байна⁹.

“Тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэх ойлголтын хувьд эхний бүтээл буюу тайлбарт “...тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг тогтоох гол үндэслэл болно. Гэхдээ тээврийн хэрэгслийн улсын бүртгэл нь гэм хор хүлээх этгээдийг шууд тодорхойлох үндэслэл болохгүй” гээд Иргэний хуулийн 89.2-т заасан тохиолдолд тээврийн хэрэгслийн эзэмшигч гэж үзэхгүй харин 89.3-т заасан тохиолдолд шууд болон шууд бус эзэмшигчийг аль алиныг нь тээврийн хэрэгслийг эзэмшигчид гэж тооцно гэсэн тайлбарыг санал болгосон байна¹⁰.

Түүнчлэн, гэрчилгээг үндэслэж бус харин Иргэний хуулийн 111.1 дэх хэсэгт заасан хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх зохицуулалтыг шалгуур болгон тээврийн хэрэгсэл эзэмшигчийг тогтоох шаардлагатай болохыг онцлон дурджээ¹¹. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгслийн өмчлөх эрх нь гэрчилгээнд нэр нь бичигдсэн цаг мөчөөс бус харин эзэмшлийг шилжүүлсэн мөчөөс шилждэг болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

⁹ Т.Мөнхжаргал нар, “Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй” УБ., 2005 он, 54-р тал

¹⁰ Монгол Улсын Дээд Шүүх, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (гэрээний бус үүрэг) IV” УБ., 2016 он, 62-р тал

¹¹ Мөн тэнд

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Харин судлаачдын бүтээлийн хувьд тээврийн хэрэгслийг эзэмшигч гэх нөхцөлийг “орчин тойрондоо аюултай зүйлийг эзэмшигч-д уул зүйлийг хууль буюу гэрээнд заасны дагуу байнга буюу түр хугацаагаар өөрийн эзэмших эрхийн үндсэн дээр ашиглаж байгаа хуулийн этгээд, иргэнийг хамааруулна” гээд “орчин тойрондоо аюултай зүйлийг өмчлөгчийн хувьд хууль зүйн болон материаллаг гэсэн хоёр шинжийг агуулсан байна. Орчин тойрондоо аюултай зүйлийг өмчлөгч нь түүнийг ашиглах явцад иргэний эрх зүйн өмчлөх эрх, аж ахуй эрхлэн хөтлөх эрх зэрэг тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлж байдгаар хууль зүйн шинж нь илрэн гарч байдаг бол материаллаг шинж нь өмчлөгчөөс уг зүйлийг бодитойгоор өмчлөлдөө байлгахыг чухалчилдаг” гэж тайлбарлажээ¹².

Өөр нэгэн судлаачийн хувьд “тээврийн хэрэгсэл эзэмшигчийг тусгайлан тодорхойлон хуульчилсан зүйл байхгүй тул энэ зохицуулалт нь Иргэний хуулийн эзэмшилтэй холбоотой заалтын хүрээнд тайлбарлах шаардлага үүсэж байна” гээд “жолоочийг эзэмшигч гэхээсээ илүү ашиглагч гэж үзнэ” гэсэн санааг мөн дэвшүүлжээ¹³.

3. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Автомашин барьцаалагчид холбогдох шүүхийн шийдвэр

(Хэрэг №1, №2, №3)

Хэрэг №1-д иргэн Г-ийн эзэмшлийн “приус” загварын автомашиныг иргэн А нь “верна” загварын тээврийн хэрэгслийг жолоодож яваад мөргөн зам тээврийн осол гаргасан. Хариуцагч “Н” ХХК нь А-д зээл олгон, фидуцийн гэрээний дагуу түүний “верна” загварын автомашиныг өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан. А нь автомашинаа унаж ашиглаж байжээ. Шүүхийн зүгээс “Тээврийн хэрэгслийн онцлогоос хамааран энэхүү эд хөрөнгийн ашиглалтын улмаас бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч арилгах үүрэг хүлээдэг нь гэм буруугүйгээр хүлээдэг хариуцлагын төрөл юм” гэж дүгнэн “Н” ХХК-иас хохирол гаргуулан шийдвэрлэжээ. Судлаачдын зүгээс энэхүү шийдвэртэй санал нийлэхгүй байгаа ба учир нь:

¹² Т.Мөнхжаргал нар, “Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй” УБ., 2005 он, 56-р тал

¹³ Ж.Оюунтунгалаг, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” 2017 он, 12-р тал

- Иргэний хуулийн 499-р зүйлийн зохицуулалт нь тээврийн хэрэгслийн өмчлөгчид хариуцлага хүлээлгэхэд чиглээгүй бөгөөд гол зорилго нь орчин тойрондоо аюул учруулах эрсдэл өндөртэй зүйл болох тээврийн хэрэгслийг өөрийн мэдэл, хараа хяналтдаа байлгадаг, түүний эрсдэлийг удирдах боломжтой этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилготой юм. Тийм ч учраас 499-р зүйлийн 1 дэх хэсэгт “өмчлөгч” гэх нэр томъёо хэрэглэлгүйгээр “эзэмшигч” гэсэн нэр томъёо хэрэглэж буй нь тодорхой зорилготой болохоор юм. Иймээс “Н” ХХК нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор өөрийн нэр дээр А-гийн автомашины өмчлөх эрхийг түр шилжүүлснийг тээврийн хэрэгслийг өөрийн хяналтад байлгаж, эрсдэлийг удирдах боломжтой этгээд гэж үзэхгүй. “Н” ХХК нь уг тээврийн хэрэгслийн ашиглалттай ямар ч холбоогүй этгээд болно.
- Иргэний хуулийн 499-р зүйлийн гарчиг нь “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах” гэснээс тээврийн хэрэгслийг зориулалтын дагуу ашиглаж буй этгээд хариуцлага хүлээлгэх зорилготой болох нь мөн харагддаг.
- Өмнө дурдсанчлан, Иргэний хуулийн 499-р зүйл нь “гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим”-д суурилсан бөгөөд уг зарчмыг зөвтгөх үндэслэл нь тээврийн хэрэгслийн өмчлөгч гэхээсээ илүүтэй эзэмшигчид хариуцлага хүлээлгэх болсон шалтгааныг тодорхой харуулдаг. Эхний зөвтгөх үндэслэл нь эрсдэлийг хариуцах зарчим (гер.Gefährdungshaftung) юм. Уг зарчмын гол агуулга нь нийгэмд аюул, эрсдэлийг бий болгож байгаа этгээд түүний улмаас үүссэн хохирлыг гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцах ёстой гэдэг. Дараагийн зөвтгөх үндэслэл нь нөхөн төлөх зарчим (гер.Equivalenzprinzip) юм. Гол агуулга нь ашиг олох үйл ажиллагааны явцад бусдад хохирол учруулсан тохиолдолд ашиг олж буй этгээдэд хохирол нөхөн төлөх нь зүй ёсны гэж үздэг зарчим юм. Эндээс эхний зөвтгөх үндэслэл болох эрсдэлийг хариуцах зарчим нь тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх гэм хорыг арилгах тогтолцооны гол үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл, “тээврийн хэрэгсэл” өөрөө орчин тойрондоо аюулгүй боловч харин “тээврийн хэрэгслийн ашиглалт” нь хүний үйл ажиллагааг хөнгөвчлөхийн зэрэгцээ нийгэмд тэр

хэмжээгээр хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлийг дагуулж байдаг. Иймээс тээврийн хэрэгслийн ашиглалтыг хэн хариуцаж, хяналт тавьж байна гэдгийг шалгуур болгон тээврийн хэрэгслийн эзэмшигчийг тодорхойлох нь зөв юм.

Хэрэг №2-т хариуцагч И нь хариуцагч Хаан банктай 2014 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ буюу фидуцийн гэрээ байгуулан ZL 50-C маркийн тээврийн хэрэгслийг худалдан авсан. Үүний дараагаар хариуцагч И нь уг автомашинаа худалдах зар гаргасан бөгөөд хариуцагч Б худалдан авах талаар санал гаргаж автомашиныг 26 сая төгрөгөөр заржээ. Б нь мөнгийг бэлэн өгөх боломжгүй гээд 12 сая төгрөгт тооцож “приус 20” маркийн автомашин өгч, 12 сая төгрөгийг бэлнээр, үлдэгдэл 2 сая төгрөгийг автомашины нэрийг 2015 оны 3 дугаар сарын 6-ны өдөр шилжүүлж өгсөн үед төлөхөөр тохиролцоод тээврийн хэрэгслийг 2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Б хүлээн авсан. Уг автомашиныг иргэн Ч жолоодож явахдаа Замын хөдөлгөөний дүрмийн 2.3 дахь заалтыг зөрчсөний улмаас 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр осол гарган Г, Ж, О нарыг гэмтээж, эд хөрөнгөд нь хохирол учруулсан байна. Энэ үед уг тээврийн хэрэгслийн өмчлөх эрх фидуцийн гэрээний дагуу банканд байжээ. Шүүхийн зүгээс “Б 2014 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр ZL 50-C маркийн тээврийн хэрэгсэл худалдан авч, тухайн эд хөрөнгө өөрийнх нь эзэмшилд байх үед тээврийн хэрэгсэл ашиглагчийг томилж, Ч-д шилжүүлэн өгсөн, Ч нь 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр уг тээврийн хэрэгслийг жолоодож явахдаа Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2.3-ыг зөрчсөний улмаас зам тээврийн осол гарч, нэхэмжлэгч нарт хохирол учирсан үйл баримт нотлогдсон байна. Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон, өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй” гэсэн шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэртэй судлаачдын зүгээс санал нийлж байна. Учир нь:

- Осол гарах үед тээврийн хэрэгсэл хэний эзэмшил, ашиглалтад байсныг шалгуур болгон шийдвэр гаргасан нь Иргэний хуулийн 499-р зүйлийн зохицуулалтын зорилгод нийсэн шийдвэр болжээ. Харин өмнөх хэрэг №1-ийн шүүхийн шийдвэрийн адилаар Иргэний хуулийн 499-р зүйлийг тайлбарлавал фидуцийн гэрээний

дагуу тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлж авсан байсан хариуцагч ХААН банк нь хохирлыг хамтран хариуцах ёстой гэж дүгнэх боломжтой байв. Энэ нь хэрэг №1(2019-01-10), хэрэг №2(2017-06-16) адилхан Улсын дээд шүүхийн шийдвэр, тэр дундаа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ёстой шүүхийн шийдвэр боловч нэг асуудал дээр нэг хуулийн заалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэг шийдэж буйг харуулж байгаа юм. Энэ байдал нь хууль хэрэглээний тогтворгүй байдлыг үүсгэж байна.

- Ер нь тээврийн хэрэгслийн эзэмшигч гэдгийг хэрхэн тодорхойлох вэ? гэдэг нь сонирхол татсан асуудал юм. Энэ талаар Улсын Дээд шүүхийн эрхлэн гаргасан албан бус тайлбарт “тээврийн хэрэгслийн улсын бүртгэл нь гэм хор хүлээх этгээдийг шууд тодорхойлох үндэслэл болохгүй. Иргэний хуулийн 89-р зүйлийн 89.2-т өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна, 89.3-т өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна гэж тус тус заажээ. Хуулийн энэхүү зохицуулалтын агуулгаас үзвэл тээврийн хэрэгслийг байнга буюу түр хугацаагаар өөрийн эзэмшилдээ байлгаж, хөдөлгөөнд оруулж, ашиглаж байгаа этгээдийг эзэмшигч гэж ойлгох бөгөөд тээврийн хэрэгслийн төрлөөс нь хамаарч түүнийг жолооч, машинч, нисгэгч гэж нэрлэдэг байна”¹⁴ гэж шууд болон шууд бус эзэмшигчийг аль алиныг нь тээврийн хэрэгслийг эзэмшигчид тооцохоор тайлбарлажээ. Мөн судлаач Ж.Оюунтунгалаг “тээврийн хэрэгсэл эзэмшигчийг тусгайлан тодорхойлон хуульчилсан зүйл байхгүй тул энэ зохицуулалт нь Иргэний хуулийн эзэмшилтэй холбоотой заалтын хүрээнд тайлбарлах шаардлага үүсэж байна. Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгслийн эзэмшигчийг тодорхойлбол, тухайн тээврийн хэрэгслийг

¹⁴ Монгол Улсын Дээд Шүүх, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (гэрээний бус үүрэг) IV” УБ., 2016 он, 62-р тал

бодитойгоор эзэмшилдээ байлгаж байгаа шууд эзэмшигч, эзэмших боломжоо бусдад олгосон шууд бус эзэмшигчийн аль алиныг хамрахаар байна”¹⁵ гэжээ. Эдгээр дүгнэлттэй судлаачдын зүгээс санал нийлэх боломжгүй байна. Иргэний хуулийн 89-р зүйлийн 89.2, 89.3 дахь хэсгүүдийн зохицуулалтыг Иргэний хуулийн 499-р зүйлийн тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх гэм хорын асуудалтай холбон тайлбарлах шаардлагагүй юм. Харин Т.Мөнхжаргал нарын бүтээлд тээврийн хэрэгслийг эзэмшигч гэх нөхцөлийг “орчин тойрондоо аюултай зүйлийг эзэмшигчид уул зүйлийг хууль буюу гэрээнд заасны дагуу байнга буюу түр хугацаагаар өөрийн эзэмших эрхийн үндсэн дээр ашиглаж байгаа хуулийн этгээд, иргэнийг хамааруулна” гээд “орчин тойрондоо аюултай зүйлийг өмчлөгчийн хувьд хууль зүйн болон материаллаг гэсэн хоёр шинжийг агуулсан байна. Орчин тойрондоо аюултай зүйлийг өмчлөгч нь түүнийг ашиглах явцад иргэний эрх зүйн өмчлөх эрх, аж ахуйг эрхлэн хөтлөх эрх зэрэг тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлж байдгаар хууль зүйн шинж нь илрэн гарч байдаг бол материаллаг шинж нь өмчлөгчөөс уг зүйлийг бодитойгоор өмчлөлдөө байлгахыг чухалчилдаг” гэж тайлбарласан¹⁶ нь илүү бодит байдалд нийцэж буй юм.

Хэрэг №3-т хариуцагч Ж нь 2013 оны 12 дугаар сарын 9-ний өдөр “Транскапитал” ББСБ-аас 3,000,000 төгрөгийн зээл авч, охин Л-д өгчээ. Уг зээлээр Л нь “соната-6” маркийн автомашин худалдан авч “Транскапитал” ББСБ-аас авсан 3,000,000 төгрөгийн зээлийн барьцаанд энэ машинаа барьцаалсан боловч тэрээр уг автомашиныг 2014 оны 1 дүгээр сард Б-д 6,500,000 төгрөгөөр худалдахаар тохирч 4,000,000 төгрөгийг Б нь Л-д бэлнээр өгч, үлдэгдэл 2,500,000 төгрөгийг “Транскапитал” ББСБ-аас авсан зээлийг сар бүр төлж дуусгахаар харилцан тохиролцжээ. 2014 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хариуцагч Б нь “соната-6” маркийн автомашиныг жолоодож яваад нэхэмжлэгч Ч-ийн жолоодож явсан Т-ийн эзэмшлийн “Спортаж” маркийн автомашины араас мөргөж гэм хор учруулсан. Шүүхийн зүгээс “Б-ийн гэм буруутай үйлдэл, нэхэмжлэгч нарт учирсан

¹⁵ Ж.Оюунтунгалаг “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2016 он, №3, 110 дахь тал

¹⁶ Т.Мөнхжаргал нар, “Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй” УБ., 2005 он, 56-р тал

гэм хортой шалтгаант холбоотой болох нь тогтоогдсон учир Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар нэхэмжлэгч Ч, Т нар өөрт учирсан эд хөрөнгийн хохирлыг хариуцагч Б-ээс шаардах эрхтэй” гэсэн шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэртэй судлаачдын зүгээс санал нийлэхгүй байна. Учир нь:

- Шүүхийн зүгээс нэхэмжлэгч нарын шаардах эрхийн үндэслэлийг Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 гэж тодорхойлсон нь буруу юм. Иргэн Б тээврийн хэрэгсэл унаж яваад нэхэмжлэгч нарт хохирол учруулсан тул Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсэгт зааснаар Б-д хариуцлага хүлээлгэх ёстой. Үүний цаана тээврийн хэрэгсэл эзэмшигч этгээд нь өөрөө гэм хор учруулсан этгээд байгаа тохиолдолд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 болон 499-р зүйлийн 499.1 гэх зохицуулалтуудын алийг нь хэрэглэх талаар маргаан байдаг. Энэ талаар судлаач Ж.Оюунтунгалаг “Тээврийн хэрэгсэл эзэмшигч нь өөрөө гэм хор учруулсан этгээд байгаа тохиолдолд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт зааснаар гэм хорыг хариуцан арилгах боломжтой учир заавал 499.1 дэх хэсгийн заалтыг баримтлах шаардлага үүсэхгүй¹⁷” гэсэн байдаг. Гэвч тээврийн хэрэгсэл эзэмшигч нь жолооч байх тохиолдолд Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийг шаардах эрхийн үндэслэл болгох нь нэхэмжлэгчийг нотлох үүргээс чөлөөлөх, тээврийн хэрэгсэл эзэмшигчид гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх 499-р зүйлийн зорилго хэрэгжихгүй болох юм.
- Түүнчлэн, Япон Улсын Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 2-р зүйлийн 4 дэх хэсэгт “жолооч” гэж бусдын төлөө тээврийн хэрэгслийг жолоодох, эсвэл жолоодоход туслах ажлыг гүйцэтгэж буй этгээдийг хэлнэ гэснээс авч үзэхэд тээврийн хэрэгсэл эзэмшигч нь өөрөө тээврийн хэрэгслээ жолоодож буй тохиолдолд уг хуулийн жолооч гэсэн тодорхойлолтод хамаарахгүй гэх байдлаар тайлбарлах онолын хувилбар байгаа болно. Энэ мэт онолын хувилбарыг цаашид харгалзан үзэх шаардлагатай байна.

¹⁷ Ж.Оюунтунгалаг “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2016 он, №3, 110 дахь тал

3.2. Ажилтны учруулсан гэм хорд холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №4, №6)

Хэрэг №4-ийн хувьд нэхэмжлэгч Б.Б нь гол болон туслах замын уулзварт гол замаар нэвтрэх үйлдлийг хийж байх үедээ Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны ажилтны жолоодож явсан машинд мөргүүлж гэмтсэн бөгөөд хохирлоо нэхэмжилсэн тохиолдол болно.

Замын хөдөлгөөний дүрмийн 12.9-д “Гол ба туслах замын уулзварт туслах замаар яваа жолооч гол замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө” гэсэн заалтыг зөрчсөний улмаас уг осол гарсан нь дүгнэлтээр тогтоогдсон бөгөөд тухайн тээврийн хэрэгсэл нь Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны нэр дээр гэрчилгээтэй байсан болохыг нотлох баримтаар үнэлсэн байна.

Хариуцагчийн зүгээс нэхэмжлэгч Б.Б-гийн сууж явсан мотоциклын жолооч О нь “Замын хөдөлгөөний дүрэм зөрчин жолоодох эрхийн үнэмлэхгүй, тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй, хамгаалах малгайгүй, малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэж замын хөдөлгөөнд оролцож зам тээврийн осол гаргасан” гэж үзээд тухайн хохирлыг хамтран хариуцах ёстой гэсэн хариу тайлбарыг гаргажээ.

Улсын Дээд шүүхийн зүгээс Иргэний хуулийн 499.4 дэх хэсгийн дагуу шийдвэрлэнэ гэж үзсэн бөгөөд нарийвчилсан зохицуулалт байх тул 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийг хэрэглэхгүй гээд Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны нэр дээр гэрчилгээтэй тээврийн хэрэгсэл байх тул 499.4 дэх хэсэгт заасны дагуу тус байгууллага гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээнэ гэж дүгнэжээ.

Түүнчлэн 514-р зүйлийг хэрэглэх үндэслэлгүй гэж дүгнэсэн. Үүний үндэслэлийг дурдахдаа “Нэхэмжлэгч нь мотоциклын ард явахдаа зориулалтын малгай өмсөөгүй боловч үүний улмаас гэм хорын хэмжээ нэмэгдсэн гэх байдал баримтаар тогтоогдоогүй байна” гэжээ (Энэ талаар Хэрэг №9 болон Хэрэг №10-ын тайлбартай хамтатган судлах болно).

Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.4 дэх хэсэгт “Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй” хэмээн заасан байна. Тайлбарын хувьд “499.3 болон 499.4-т заасан хариуцлага ногдуулахад

гэм хор учирсан үйл явдалд гэм буруутай байх шаардлагагүй тул тухайн этгээд гэм буруугүйгээ нотлох үүрэггүй” гэж тайлбарласан байна¹⁸. Тиймээс энэ тохиолдолд 498-р зүйлийн дагуу ажил олгогч буюу Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албанаас хохирлоо шаардах шаардлагагүй гэж дүгнэсэн байна.

Шүүхийн практикт 498-р зүйлийн хувьд ажил олгогчийн өөрийн нь гэм бурууг шалган тогтоодог байдал түгээмэл болсон бөгөөд эндээс дүгнэвэл 499-р зүйлийн 499.4 дэх хэсэг болон 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн хувьд урьдчилсан нөхцөлийн ялгаа мэдээж байгаа нь тодорхой. Ийм учраас цаашид 499-р зүйлийн 499.4 дэх хэсгийн “томилсон” болон “шилжүүлсэн өгсөн” гэх ойлголтыг нарийвчлан тайлбарлах, 498-р зүйлийн “хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх” гэх ойлголт хоорондын ялгааг сайтар томъёолох шаардлагатай гэж үзэж байна. 498-р зүйлийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх явцдаа учруулсан гэм хор байх шаардлагатай байдаг бол 499.4 дэх хэсгийн хувьд тээврийн хэрэгслийг ашиглах явцад байхад л хангалттай гэж тайлбарлаж болохоор байна. Өөрөөр хэлбэл, 499.4 дэх хэсгийн урьдчилсан нөхцөл нь 498-р зүйлээс илүү өргөн хүрээг хамрах боломжтой байдлаар хуульчлагджээ.

Хэрэг №6-ын хувьд “М” ХХК-ийн ажилтан тухайн компанийн автомашиныг жолоодож, ажил үүргээ гүйцэтгэж байх үеэр “И” ХХК-ийн ажилтан мөн адил ажил үүргээ гүйцэтгэн автомашин жолоодож явахдаа “М” ХХК-ийн автомашиныг мөргөж, ажилтанд нь эрүүл мэндийн хохирол учруулсан тохиолдол болно. “М” ХХК-ийн хувьд өөрийн ажилтны эрүүл мэндийн үйлчилгээний хөлсийг төлсөн учраас тухайн хөлсөө “И” ХХК-иас нэхэмжилсэн байдаг. Улсын Дээд шүүхийн зүгээс 497-р зүйлийн 497.1, 499-р зүйлийн 499.4 дэх хэсэг болон 513-р зүйлийн 513.1, 513.2 дахь хэсгийг тус тус үндэслэн шийдвэрлэжээ.

513-р зүйлийн хувьд 443.7-той нэлээд холбоотой зохицуулалт болно. Өөрөөр хэлбэл, хохирлын нөхөн төлсөн даатгагчийн хувьд даатгуулагчийн гуравдагч этгээдийн эсрэг хэрэгжүүлэх шаардах эрх шилжих зохицуулалттай холбоотойгоор 513-р зүйл ихэвчлэн хэрэглэгддэг.

¹⁸ Монгол Улсын Дээд Шүүх, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (гэрээний бус үүрэг) IV” УБ., 2016 он, 66-р тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Энэ тохиолдолд шүүхийн зүгээс 499.4 дэх хэсгийг мөн адил хэрэглэсэн байна. Тиймээс “М” ХХК ажилтан буюу хохирогчдын зүгээс 499.4-ийн дагуу “И” ХХК-иас шаардах эрх нь үүнийг нөхөн төлсөн “М” ХХК-д шилжсэн гэж шүүх тайлбарласан байх магадлалтай байна. Ямартай ч энэ тохиолдолд ажил олгогчид шаардах эрх шилжих боломжтой болохыг шүүхийн зүгээс хүлээн зөвшөөрчээ¹⁹. Гэвч 499.4 дэх хэсгийн хувьд 498-р зүйлийн хэрэглээтэй хэрхэн ялгагдах, шаардах эрхийн хувьд хэрхэн томъёолох талаар дахин сайтар бодолцох шаардлагатай байна. Учир нь практикт эдгээр зохицуулалтууд нь ялгаатай урьдчилсан нөхцөлийн хүрээнд хэрэглэгдэж байгаа билээ.

3.3. 499.3-т холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №5)

Хэрэг №5-д хариуцагч О нь 2015 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр нэгэн компанийн автомашины зогсоолд өөрийн эзэмшлийн автомашинаа тавьдаг байсан. Өөр хүний автомашин гарах боломжийг хааж тавьдаг учраас уг компанийн манаач болох Д-д түлхүүрээ үлдээгээд зогсоолд тавьсан автомашин гарах шаардлагатай бол автомашиныг нь хөдөлгөөд гаргачхаад буцаагаад зогсоолд тавиарай гэжээ. А нь О-ийн эзэмшлийн уг автомашиныг тус зогсоолын манаач Д-тэй хамт архи уун, согтуугаар жолоодож яваад Я-гийн жолоодож явсан “Монгол такси групп” ХХК-ийн тээврийн хэрэгслийг мөргөж зам тээврийн осол гаргажээ. Шүүхийн зүгээс “Хариуцагч О нь бусдад автомашины түлхүүрээ үлдээснээс зам тээврийн осол гарах боломжийг бүрдүүлсэн, тээврийн хэрэгслийг ашиглуулах боломж олгосон учраас тээврийн хэрэгслийг өмчлөгчийн хувьд нэхэмжлэгч нарт учирсан хохирлыг О хариуцах үүрэгтэй” гэж шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэртэй судлаачдын зүгээс санал нийлж байгаагийн учир нь:

- Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.3 дахь хэсэгт зааснаар хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол өмчлөгч, эзэмшигчийг хохирол нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлдөг. Харин өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

¹⁹ ХБНГУ-ын хувьд EFGZ гэх хуулийн зохицуулалт бий.

3.4. 497-р зүйл болон 499-р зүйлийн хэрэглээнд холбогдох шүүхийн шийдвэр (Хэрэг №7, №8)

Хэрэг №7-д Д-ийн өмчлөлийн “приус-20” маркийн автомашиныг Б жолоодож явахдаа замын хажуу руу онхолдож осол гаргасан. Д нь автомашины хохирлыг Б-гээс шаарджээ. Шүүхийн зүгээс “Номин даатгал” ХХК нь автомашинд учирсан хохирлын үнэлгээг “Итгэлт эстимэйт” ХХК-иас гаргасан үнэлгээ болох 9,325,000 төгрөгөөс тооцож 7,460,000 төгрөгийг даатгалын нөхөн төлбөр олгосон байх тул зөрүү 1,865,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгох нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэх тул анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4-т заасан үүргээ зөрчөөгүй гэж үзнэ” гэж шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэртэй судлаачдын зүгээс санал нийлэхгүй байна. Учир нь:

- Уг хэргийг анхан шатны шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсгийн баримтлан шийдвэрлэсэн байна. Харин давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 499-р зүйл 499.1 дэх хэсгийг хэрэглэх ёстой байсан гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг нэмж засварлажээ. Энэ хэрэгт 499-р зүйлийн 499.1 дэх хэсгийг хэрэглэх боломжтой эсэх нь сонирхол татсан асуудал юм. Тээврийн хэрэгсэл эзэмшигч нь нэхэмжлэгч Д өөрөө бөгөөд Б түүний автомашиныг унаж яваад онхолдуулсан байна. Харин Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсэг нь “бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс” гэсэн урьдчилсан нөхцөлтэй тул нэхэмжлэгчийн Д-гийн өөрийн тээврийн хэрэгсэлд хохирол учирсан болохоор Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсгийн “бусдын” гэсэн урьдчилсан нөхцөлийг хангахгүй байна. Иймд уг хэргийг Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсгийг баримтлан шийдвэрлэх нь буруу бөгөөд Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийн дагуу шийдвэрлэх нь зөв юм.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хэрэг №8-д Б-ийн “toyoto crown” маркийн машиныг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Өлгий сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт хариуцагч М нь “toyota harrier” маркийн машиныг жолоодож явахдаа мөргөж зам тээврийн осол гаргажээ. Шүүхийн зүгээс “Анхан шатны шүүх уг хохирлыг хариуцагч М-ээс гаргуулж Б-д олгохоор шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1-д заасан зохицуулалтыг хэрэглэсэн нь хуульд нийцжээ” гэж шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэртэй судлаачид зүгээс санал нийлэхгүй байгаа бөгөөд учир нь:

- Шүүхийн шийдвэрт Иргэний хуулийн гэм хорын ерөнхий зохицуулалт болон гэм хорын тусгай зохицуулалтыг нэгэн зэрэг баримталж буй нь тус зохицуулалтуудын зорилго, агуулга, хэрэглээг шүүх бүрэн дүүрэн ойлгоогүйг харуулж байна. Иргэний хуулийн 497-р зүйл нь ерөнхий зохицуулалт болохын хувьд гэм хор учруулагч нь үйлдэлдээ санаатай эсхүл болгоомжгүй хандсан гэм буруутай байхыг шаарддаг бол, Иргэний хуулийн 499-р зүйл нь гэм хорын тусгай төрөл тэр дундаа тээврийн хэрэгсэл эзэмшигчид гэм буруутгүйгээр хариуцлага хүлээлгэдэг тул уг хоёр зохицуулалтыг нарийн ялгаж хэрэглэх ёстой. Ийнхүү хамтад нь хэрэглэж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116-р зүйлийн 116.2 дахь хэсэгт заасан шүүхийн шийдвэр хууль ёсны байх шинжийг алдагдуулж байна.

3.5. Бусад шийдвэр (Хэрэг №4 №9, №10)

Өмнө дурдсаны дагуу Хэрэг №4-т шүүхийн зүгээс 514-р зүйлийг хэрэглэх үндэслэлгүй гэж дүгнэсэн бөгөөд уг шийдвэрийнхээ үндэслэлийг “Нэхэмжлэгч нь мотоциклын ард явахдаа зориулалтын малгай өмсөөгүй боловч үүний улмаас гэм хорын хэмжээ нэмэгдсэн гэх байдал баримтаар тогтоогдоогүй байна” гэсэн. Гэтэл энд 514-р зүйлийг хэрэглэхэд нэхэмжлэгч, эсхүл хариуцагч ямар нэгэн нотолгоо явуулах шаардлагатай юу гэсэн асуултад хариулт хайх шаардлагатай.

514-р зүйлийн 514.1 дэх хэсэгт “Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно” гэж заасан. Энэ

тохиолдолд хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн болгоомжгүй эс үйлдэл нөлөөлсөн эсэхийг шүүх бодитой нотлох баримт дээр үндэслэж шийдвэрлэх үү, эсхүл энэ тохиолдолд тодорхой үнэлэмжийн үндэслэн шийдвэрлэх ёстой юу гэсэн асуултыг сайтар бодолцох шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хохирогч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн учраас тухайн зөрчил нь хохирол нэмэгдэхэд нөлөөлөх боломжтой эсэхийг энэ тохиолдолд үнэлэх шаардлагатай гэсэн үг. Зарим тохиолдолд энэхүү үнэлгээг хийхдээ адекватацийн онолыг ашиглах боломжтой байж болох юм. Тухайлбал, ихэнх тохиолдлын хувьд хамгаалалтын малгай зүүгээгүйгээс хохирлын хэмжээ нэмэгдэх боломжтой эсэхийг гол шалгуур болгон шалтгаант холбоог адекватацийн онолын үүднээс үнэлэх боломж байхыг үгүйсгэхгүй гэсэн үг юм.

Түүнчлэн хариуцагч тал энэ тохиолдолд хохирогчийн болгоомжгүй үйлдэл болон эс үйлдлийн талаар нотолгоо гаргах шаардлагатай эсэхийг мөн тодруулах нь зүйтэй. Онолын хувьд үүнийг хариуцагчид хохирогчийн шаардах эрхийг үгүйсгэх боломж олгох тодорхой эрх гэж үзэх юм бол хариуцагч нотлох үүрэг хүлээх шаардлагатай болох юм. Гэвч 514-р зүйл нь өөрөө шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэхэд чиглэсэн эрх биш гэж тайлбарлах нь зохистой тул хариуцагч нотлох үүрэг хүлээхгүй, харин шүүх өөрийн бүрэн эрхийн хүрээнд хохирлын хэмжээг тогтоохдоо хохирогчийн болгоомжгүй үйлдэл болон эс үйлдэл, хохирол нэмэгдэхтэй холбоотой шалтгаант холбоо бий эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргана гэж тайлбарлах илүү зохистой билээ²⁰.

Уг 514-р зүйлийн хэрэгжилттэй холбоотойгоор хоёр кейсийг судлан үзсэн болно. Юун түрүүнд Хэрэг №9-ийн талаар авч үзье. Хэрэг №9-ийн хувьд нэхэмжлэгч Б.Г нь “приус” маркийн автомашиныг жолоодож явахдаа зам дээр зогссон байсан Д.Б-гийн жолоодож байсан тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөж хохирол хүлээсэнтэй холбоотой хэрэг болно. Тус хэргийн хувьд Д.Б-гийн ах нь уг тээврийн хэрэгслийг хариуцагч П.Э-ээс худалдан авсан болохыг шүүх үнэлсэн бөгөөд харин нэхэмжлэгч

²⁰ Накагава Тацуяа, Иргэний хуулийн 722-р зүйлийн 722.2 дахь хэсэг дэх гэм буруу гэх нөхцөлийг тайлбарлах, нотлох үүргийн талаарх судалгаа, Рицүмэйкан хууль, улс төрийн сэтгүүл дугаар 3, 2005 он. 中川龍也「民法722条2項の過失の主張・立証責任についての実体法的視点からの再検討」立命館法政論集第3号2005年。

нь тээврийн хэрэгслийн гэрчилгээ дээр нэр нь бүртгэгдсэн П.Э болон жолоодож явсан Д.Б нарын эсрэг нэхэмжлэл гаргасан байдаг.

Хариуцагч Д.Б нь 2004 оны Замын хөдөлгөөний дүрмийн 6.2-ийн в, е болон 6.3, 7.17 дахь хэсгүүдийг тус тус зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан байдаг. Харин нэхэмжлэгч Б.Г-ийн хувьд замын хөдөлгөөний дүрмийн 9.2 дахь хэсгийг зөрчсөн гэж шинжээч дүгнэсэн байна. Улсын Дээд шүүхийн зүгээс дээрх тохиолдолд Иргэний хуулийн 514-р зүйлийн дагуу хохирлын хэмжээг 20 хувиар бууруулах шийдвэрийг гаргасан. Түүнчлэн, тээврийн хэрэгслийн хувьд хөдлөх эд хөрөнгийн хувьд өмчлөх эрх нь тээврийн хэрэгслийн гэрчилгээ хэвлэгдсэн үеэс бус харин эзэмшлийг шилжүүлсэн үеэс шилжих боломжтой гэсэн тайлбарыг баримтлан П.Э-ийн нэр дээр гэрчилгээ байх боловч бодит байдалд өмчлөх эрх нь Д.Б-ийн ах Т-д байгаа гэж дүгнэжээ. Гэвч энэ тохиолдолд Д.Б нь Т-ийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг хэрэглэж байгаа нь түүнийг тээврийн хэрэгслийн эзэмшигч гэж үзэх үндэслэл болох эсэхийг шүүх харгалзан үзээгүй, харин 497-р зүйлийн дагуу шийдвэрлэжээ.

Харин Хэрэг №10-ын хувьд нэхэмжлэгч Ч.С нь өөрийн машиныг ах Б.Г-д зээлээр худалдсан гэх бөгөөд өмчлөх эрхийг нь төлбөрийг төлж дуусгаснаар шилжүүлэхээр тохиролцжээ²¹. Улмаар Б.Г нь уг машиныг жолоодож явахдаа Э.У-ийн жолоодож явсан “тоёота спринтер” маркийн автомашинтай мөргөлдөж хохирсон байна.

Хариуцагч Э.У-ийн хувьд өөрийн найз болох Э-ийн автомашиныг жолоодож явсан бөгөөд өөрөө Э-гийн зөвшөөрөлтэйгөөр тухайн автомашиныг жолоодож явсан эсэх талаар нотлоогүй гэж шүүх дүгнэжээ. Хариуцагчийн хувьд 2004 оны Замын хөдөлгөөний дүрмийн 12.7 дахь хэсгийг зөрчсөн бол, нэхэмжлэгч Ч.С-ын ах Б.Г нь дүрмийн 9.3 дахь хэсгийг зөрчсөн гэж шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон байна.

Улсын Дээд шүүхийн зүгээс энэ тохиолдолд Иргэний хуулийн 514-р зүйлийг хэрэглэн хохирлын хэмжээг 50 хувиар бууруулсан анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Уг шийдвэрийн дагуу 497.1, 499.3 дахь хэсгүүдийг хамтатган хэрэглэжээ. Гэвч 499.3 дахь хэсгийн хувьд гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх

²¹ Япон Улсын хувьд зээлээр худалдан авсан тохиолдолд буюу төлбөрийг бүрэн төлснөөр өмчлөх эрх шилжих тохиролцоо хийгдсэн тохиолдолд тухайн худалдан авсан этгээдийг “тээврийн хэрэгслийг ашиглагч” биш гэж тайлбарласан дээд шүүхийн шийдвэр бий. 最一小判昭和46・1・26民集25巻1号126頁。

зарчимд суурилсан зохицуулалт бөгөөд 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийн зохицуулалттай хамтатган хэрэглэх боломжгүй болно.

Шүүхийн зүгээс 499.3 дахь хэсгийг хэрэглэхдээ хариуцагч тээврийн хэрэгслийн эзэмшигчээс зөвшөөрөл авсан эсэхээ нотлоогүй гэх үндэслэлийг хэрэглэсэн байна. Гэвч энэхүү 499.3 дахь хэсэг нь бие даасан шаардах эрхийн үндэслэл биш, харин 499.1 дэх хэсгийн дагуу хохирлоо тээврийн хэрэгслийн эзэмшигчийн эсрэг нэхэмжилсэн тохиолдолд тээврийн хэрэгслийн эзэмшигчийн хариуцлагыг үгүйсгэх чиг үүргийг гүйцэтгэх зохицуулалт болно. Энэ тохиолдолд хариуцагчийн хувьд 499.1 дэх хэсгийн дагуу хариуцлага хүлээнэ. Харин хариуцагч нь энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн эзэмшигчээс хамтран үүрэг гүйцэтгэгчийн хувиар өөрт учирсан хохирлоо шаардах эрх нь нээлттэй.

Тиймээс жолооч гэх ойлголтыг өөрийнхөө ашиг сонирхлын төлөө бус, бусдын төлөө автомашин жолоодож байгаа этгээд гэж тайлбарлах нь зохистой бөгөөд энэ тохиолдолд жолоочийн эсрэг нэхэмжлэгч шаардлага гаргахаар сонгосон тохиолдолд 497-р зүйлийг хэрэглэх нь тээврийн хэрэгсэл буюу өндөр хурдтай аюултай эд зүйлсийн хувьд хариуцлагыг 497-р зүйлийн гэм буруугаар хариуцлага хүлээлгэх зарчмаас илүү хатуу, хүндрүүлсэн нөхцөлөөр хүлээлгэх гэсэн цаад агуулга, ач холбогдлыг алдагдуулахгүй байх талаас нь тайлбарлах шаардлагатай байна.

4. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

4.1. Япон

4.1.1. Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хууль болон Иргэний хуулийн харилцан хамаарал

Япон Улсын хувьд 1955 онд *Act on Securing Compensation for Automobile Accidents* буюу Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль нь автозамын ослын улмаас хохирол хүлээсэн хохирогчийн хувьд гэм хор учруулагч этгээдийн санаатай болон болгоомжгүй гэм бурууг нотлох шаардлагатай байгаагаас үүдэн хохирол нөхөн төлүүлэх боломжгүй

болох, эсхүл гэм бурууг нотолж чадсан хэдий ч гэм хор учруулагч этгээдийн хувьд хохирлыг нөхөн төлөх чадваргүй байх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Уг хуулийг батлахдаа Герман Улсын тухайн үеийн Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хууль дахь *Halter* буюу Тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн хариуцлагын талаар зохицуулсан хэсгийг ашигласан гэж судлаачид дүгнэсэн байдаг²².

Япон Улсын “Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хууль”-ийн 3-р зүйлд “тээврийн хэрэгслийг ашиглагч”-ийн хариуцлагын талаар дараах байдлаар зохицуулжээ.

(自動車損害賠償責任)

第三条 自己のために自動車を運行の用に供する者は、その運行によつて他人の生命又は身体を害したときは、これによつて生じた損害を賠償する責に任ずる。ただし、自己及び運転者が自動車の運行に関し注意を怠らなかつたこと、被害者又は運転者以外の第三者に故意又は過失があつたこと並びに自動車に構造上の欠陥又は機能の障害がなかつたことを証明したときは、この限りでない。

Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх

3-р зүйл. Өөрийн төлөө тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа этгээд нь түүнийг хөдөлгөөнд ашиглах явцдаа бусдын амь нас, эсхүл бие махбодод гэм хор учруулсан бол үүний улмаас бий болсон хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Гэвч тухайн этгээд өөрөө болон жолооч нь тухайн тээврийн хэрэгслийг ашиглахдаа анхаарал болгоомж алдаагүй, хохирогч эсхүл жолоочоос бусад гуравдагч этгээдийн санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол бий болсон, тухайн тээврийн хэрэгслийн хувьд эвдрэл, гэмтэл эсхүл ямар нэгэн доголдол байгаагүй болохыг нотолсон тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

²² Ёшино Маморү, Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийг баталсан нь, Нихонхёоронша 1972 он, 4-р тал 吉野衛「自賠法の立法過程」有泉亨監修『現代損害賠償法講座3 交通事故』日本評論社1972年、4頁以下。

(民法の適用)

第四条 自己のために自動車を運行の用に供する者の損害賠償の責任については、前条の規定によるほか、民法（明治二十九年法律第八十九号）の規定による。

Иргэний хуулийг хэрэглэх

4-р зүйл. Өөрийн төлөө тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа этгээдийн хүлээх хохирол нөхөн төлөх хариуцлагын талаар өмнөх зүйлийн дагуу шийдвэрлэхээс гадна Иргэний хууль (Мэйжигийн 29 он, Хууль, Дугаар 89)-ийн зохицуулалтыг хэрэглэнэ.

Тус зохицуулалтын талаарх судлаачдын тайлбарыг авч үзэхэд, “Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлд зохицуулсан “тээврийн хэрэгсэл ашиглагчийн хариуцлага” нь жолоочид хүлээлгэх зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн хариуцлага (Иргэний хуулийн 709-р зүйлийн дагуу хүлээх хохирол нөхөн төлөх хариуцлага)-аас тусдаа үүсдэг” хэмээн тайлбарлажээ²³. Гэвч хэрвээ жолооч нь хариуцлага хүлээхээргүй тохиолдолд эсхүл жолооч нь хариуцлага хүлээх чадамжгүй бол Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлийн урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд “тээврийн хэрэгслийг ашиглагч”-д хариуцлага хүлээлгэх бүрэн боломжтой юм.

4.1.2. “Тээврийн хэрэгслийг ашиглагч”-ийг тодорхойлох нь

Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлд “Өөрийн төлөө тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа этгээд”-ийг “тээврийн хэрэгслийг ашиглагч” хэмээн зохицуулсан. Энэ ойлголтыг Японы судлаачдын хувьд хоёр үндсэн шинжээр тайлбарлах хандлага давамгайлдаг. Эхний шинж нь тээврийн хэрэгслийг захиран мэдэх, хоёрдох шинж нь тээврийн хэрэгслийн ашиглалтаас бий болсон ашгийг захиран мэдэх болно²⁴.

²³ Шиоми Ёшио Гэм хор учруулснаас үүсэн үүргийн эрх зүй II Шинзанша 306-р тал 潮見佳男「不法行為法II」信山社306頁。

²⁴ Мөн тэнд.

1955 онд Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хууль батлагдахаас өмнө тээврийн хэрэгслийн жолоочоос өөр этгээдэд хариуцлага хүлээлгэх тохиолдолд Япон Улсын Иргэний хуулийн 715-р зүйлийн дагуу буюу Ажил олгогчийн хариуцлагын талаарх зохицуулалтыг хэрэглэдэг байжээ (Чиг үүргийн хувьд Монгол Улсын Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалттай адил бөгөөд Япон Улсын хууль дахь нэр томъёоны дагуу “ажил олгогчийн хариуцлага” гэж орчууллаа). Тус 715-р зүйлийн зохицуулалтыг Монгол Улсын Иргэний хуулийн 498-р зүйлтэй харьцуулан үзвэл дараах байдалтай байна.

(使用者等の責任)

第七百十五条 ある事業のために他人を使用する者は、被用者がその事業の執行について第三者に加えた損害を賠償する責任を負う。ただし、使用者が被用者の選任及びその事業の監督について相当の注意をしたとき、又は相当の注意をしても損害が生ずべきであったときは、この限りでない。

2 使用者に代わって事業を監督する者も、前項の責任を負う。

3 前二項の規定は、使用者又は監督者から被用者に対する求償権の行使を妨げない。

Япон Улсын Иргэний хууль

715-р зүйл. Ажил олгогч зэргийн хариуцлага

1. Тодорхой аж ахуйн үйл ажиллагааны төлөө бусдыг ажиллуулж байгаа этгээдийн хувьд ажилтан нь тухайн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхдээ гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол түүний хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Гэвч ажил олгогч нь ажилтныг сонгон томилох болон аж ахуйн үйл ажиллагааг хянан удирдах талаар тодорхой анхаарал болгоомжтой байсан бол, эсхүл тодорхой анхаарал болгоомжтой байсан хэдий ч хохирол учрах байсан бол хариуцлага хүлээхгүй.

2. Ажил олгогчийн оронд аж ахуйн үйл ажиллагааг хянан удирдах этгээд ч мөн адил өмнөх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

3. Өмнөх 2 дахь хэсгийн зохицуулалт нь ажил олгогч эсхүл хянан удирдах эрхтэй этгээд нь ажилтны эсрэг өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах явдлыг хориглохгүй.

Монгол улсын Иргэний хууль

498 дугаар зүйл. Байгууллага, албан тушаалтан бусдад гэм хор учруулсны хариуцлага

498.1. Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.

498.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.

498.3. Хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсэж болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол энэ хуулийн 498.1, 498.2-т заасан байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болно.

498.4. Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана. *(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)*

498.5. Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

Япон Улсын Иргэний хуулийн 715-р зүйлийн зохицуулалтыг Монгол Улсын Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалттай харьцуулан үзвэл Япон Улсын хувьд 715-р зүйлийн 715.1 дэх хэсэг нь гэм буруут үндэслэн хариуцлага хүлээлгэх зарчмаас ялгаатай бөгөөд “ажилтныг сонгон томилох болон аж ахуйн үйл ажиллагааг хянан удирдах талаар тодорхой анхаарал болгоомжтой байсан бол” ажил олгогчийг

хариуцлагаас чөлөөлөх боломжийг олгож байгаагаараа холимог хариуцлагын зарчим (хатуу хариуцлага гэсэн нэр томъёог хэрэглэх нь бий)-ыг ашигласан гэж дүгнэж болохоор байгаа болно.

Монгол Улсын хувьд Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийг авч үзвэл, гэм буруутгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмыг баримталсан нь харагдах боловч судлаачдын хувьд 498-р зүйлийн 498.3 дахь хэсгийн зохицуулалтыг Япон Улсын Иргэний хуулийн 715-р зүйлийн 715.1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрийн зохицуулалттай адил байдлаар тайлбарласан байгааг бид төвөггүйхэн харж болно. Гэвч ийм байдлаар тайлбарлах болсон гол шалтгаан нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 831-р зүйл (Gehilfenhaftung)-ийн зохицуулалттай холбоотой гэж үзэж болно. Харин судлаач бидний үзэж буйгаар 498-р зүйлийн хувьд гэм буруутгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмыг баримталсан бөгөөд 498-р зүйлийн 498.3 дахь хэсгийн зохицуулалт нь “Хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсэж болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс” хэмээн зохицуулсан байгаа шууд утгаараа хэрэглэгдэнэ гэж үзэж байгаа болно.

Япон Улсын хувьд үндсэндээ бусдаар дамжуулан тухайн автомашиныг хөдөлгөөнд оролцуулж байгаа этгээдэд хүлээлгэх хариуцлага нь бусдыг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд хүлээлгэх хариуцлагатай бүтцийн хувьд адил гэж үзсэн учраас 715-р зүйлийн тайлбарыг төсөөтэй хэрэглэдэг байжээ. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгслийг ашиглагч гэх ойлголтыг тодорхойлохдоо жолоочийг удирдах захирах, хянаж байгаа этгээдийг ойлгоно гэх байдлаар тайлбарладаг байсан гэсэн үг. Ингээд улмаар хариуцлага хүлээлгэх зарчмын хувьд ашиг олж буй этгээдэд хариуцлага хүлээлгэх зарчим буюу тухайн автомашин ашигласны үр шимийг хүртэж буй этгээдэд хариуцлага хүлээлгэх ёстой гэсэн онолын тайлбарыг ашиглах болжээ²⁵.

Гэвч ХБНГУ-ын онолын нөлөөгөөр тээврийн хэрэгслийг эзэмшигч, ашиглагч гэх ойлголтыг амьтныг эзэмшигчийн хариуцлагатай адил байдлаар буюу гэм буруутгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмыг баримтлан тайлбарлах хандлага хүчтэй дэвшигдсэн байна. Тиймээс жолоочийг удирдах, захирах, хянах гэх шалгуур бус тухайн автомашин буюу тээврийн хэрэгслийг захирах, мэдэлдээ байлгаж байх гэсэн

²⁵ Мөн тэнд 308-р тал.

шалгуурыг голчлон баримтлах болжээ. Дээрх онолын тайлбарыг үндэслэн дараах байдлаар тээврийн хэрэгслийг эзэмшигчийг тодорхойлох боломжтой хэмээн тус улсад үзэж байна.

I. Тээврийн хэрэгслийг захирах, мэдэлдээ байлгах эрхтэй этгээд гэх шалгуурын хувьд²⁶:

1. Тухайн аюултай зүйлийг эзэмшиж буй этгээд: Тухайн тээврийн хэрэгслийг хуулийн дагуу болон гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа буюу шууд эзэмшигчийг “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэж үзнэ.
2. Тухайн аюултай зүйлийг өмчилж буй этгээд: Өмчлөгч нь тухайн тээврийн хэрэгслийг захиран зарцуулах, үр шимийг нь хүртэх эрхтэй тул мөн л “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэж үзнэ.
3. Тухайн аюулын эх үндсийг бий болгосон буюу өргөжүүлсэн этгээд: Тээврийн хэрэгслийг эзэмшигч нь тухайн тээврийн хэрэгслийг бусдад ашиглуулахаар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн этгээдийн бусдад учруулсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

II. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас ашиг олж байгаа этгээд гэх шалгуурын хувьд²⁷:

1. Зөвхөн бодит ашгаар хязгаарлагдахгүй бөгөөд биет бус ашгийг ч мөн адил тус шалгуурт хамруулан ойлгоно гэж үзэх хандлага байдаг. Мөн өөрийн тээврийн хэрэгслийг бусдад түрээслүүлсэн, хөлслүүлсэн гэх зэрэг тохиолдолд мөн адил түүний улмаас авч буй хөлсийг энэ шинжийг хангах нөхцөлд тооцдог байна.
2. Эдийн засгийн шинжтэй болон аж ахуйн шинжтэй үйл ажиллагааны хариу төлбөрийн хувиар ашиг олж аваагүй тохиолдолд, жолоочийг удирдах, захирах, хянах ёстой этгээд гэсэн шалгуурыг хангах эсэхээр нь “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэх ойлголтыг тодорхойлон авч үзнэ.

²⁶ Нишижима Үмэжи, Жолооны үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага, Ханрэйхёорон дугаар 97, 30-р тал 西島梅治「ドライブクラブの賠償責任」判例評論97号30頁（1966年）Дам ишлэв.

²⁷ Миязаки Томия, Зам тээврийн ослын үеийн ажил олгогчийн хариуцлага болон тээврийн хэрэгслийг ашиглагчийн хариуцлага хоорондын хамаарал Ханрэй Таймс, дугаар 211, 1967 он, 125-р тал 宮崎富哉「交通事故における使用者責任と運行供用者責任との関係」判タ211号125頁（1967年）。

III. Тээврийн хэрэгслийг эзэмшигч гэж үзэх эсэх нь эргэлзээтэй тохиолдлууд:

1. Бусдын төлөө тээврийн хэрэгслийг жолоодож байгаа эсхүл жолоодох үйл явцад тусалж байгаа этгээд нь “тээврийн хэрэгслийг эзэмшигч”-д хамаарахгүй. Тиймээс энэ шалгуурыг хангаж байгаа тохиолдолд жолооч нь тээврийн хэрэгсэл эзэмшигчид тооцогдохгүй. Гэвч бодит байдалд тээврийн хэрэгсэл жолоодож байгаа бүх этгээд дээрх шалгуурын дагуу тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хариуцлагыг хүлээх этгээдийн хүрэнээс гадуур орших уу гэвэл үгүй. Өөрийн төлөө тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа этгээд нь өөрөө тээврийн хэрэгслээ жолоодож байсан ч “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэж тооцогдоно²⁸.
2. Харин тээврийн хэрэгслээ хулгайд алдсан гэх мэт тохиолдолд өөр бусад ямар нэгэн тусгай нөхцөл байдал байгаагаас бусад тохиолдолд, тээврийн хэрэгслийг эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь жолоочийг удирдах, захирах, хянах, мөн тээврийн хэрэгслийн ашиглалтаас ашиг олох гэсэн шинжийг хангахгүй болох тул “тээврийн хэрэгсэл эзэмшигч”-д тооцогдохгүй. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хулгайлсан этгээд нь өөрөө “тээврийн хэрэгсэл эзэмшигч” гэж тооцогдоно²⁹. Харин тээврийн хэрэгслийг эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь ийм боломжийг хулгайчид олгосон бол тээврийн хэрэгслийг хулгайлсан этгээдтэй хамтран “тээврийн хэрэгсэл эзэмшигч”-д тооцогдоно.
3. Харин тухайн тээврийн хэрэгсэлд зорчиж явсан этгээдийн хувьд (i) тээврийн хэрэгслийг захирах, мэдэлдээ байлгах эрхтэй, (ii) тээврийн хэрэгслийн ашиглалтаас ашиг олж байгаа этгээд гэх шалгуурыг хангаж байгаа тохиолдолд “тээврийн хэрэгслийн эзэмшигч”-ийн хувиар хариуцлага хүлээх боловч нөгөөтээгүүр, хулгайлсан болохыг мэдсээр байж зорчиж явсан этгээдийн хувьд “тээврийн хэрэгслийн эзэмшигч”-д тооцогдоно хэмээн шүүхийн хувьд шийдвэрлэсэн байдаг³⁰.

²⁸ Шиоми Ёшио, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй II Шинзанша 323-р тал 潮見佳男「不法行為法II」信山社323頁以下。

²⁹ Дээд шүүхийн шийдвэр, Шёовагийн 48 он 12 сар 20 өдөр Миншү 27-р боть, дугаар 11, 1611-р тал 最判昭和48年12月20日民集27卷11号1611頁。

³⁰ Шиоми Ёшио, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй II Шинзанша 323-р тал 潮見佳男「不法行為法II」信山社323頁以下。

4. Тээврийн хэрэгсэл эзэмшигчээс түр зуур тухайн тээврийн хэрэгслийг гэрээний дагуу эзэмшиж буй этгээд нь тухайн үед (i) тээврийн хэрэгслийг захирах, мэдэлдээ байлгах эрхтэй, (ii) тээврийн хэрэгслийн ашиглалтаас ашиг олж байгаа этгээд гэх шалгуурыг хангаж байх тул “тээврийн хэрэгслийг эзэмшигч” болно³¹.
5. Тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийн хувьд мөн адил “тээврийн хэрэгслийг эзэмшигч”-д хамаарна.
6. Харин дуудлагын жолоочийн үйлчилгээ эрхэлдэг компанийн хувьд тухайн жолооч нь өмчлөгч болон эзэмшигчийг өөрийн нь машинаар тодорхой газар хүргэж өгөх явцдаа осол гаргасан бол хэрхэн шийдвэрлэх вэ? гэсэн асуулт үүсдэг. Энэ тохиолдолд хамтран хариуцлага хүлээх боломжтой тохиолдол байхыг үгүйсгэдэггүй³².
7. Авто засварын газарт тээврийн хэрэгслээ хүлээлгэн өгсөн тохиолдолд тухайн авто засварын газар нь “тээврийн хэрэгслийг эзэмшигч”-д хамаарна.

³¹ Мөн тэнд.

³² Мөн тэнд.

4.1.3. Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлийн урьдчилсан нөхцөл

(自動車損害賠償責任)

第三条 自己のために自動車を運行の用に供する者は、その運行によつて他人の生命又は身体を害したときは、これによつて生じた損害を賠償する責に任ずる。ただし、自己及び運転者が自動車の運行に関し注意を怠らなかつたこと、被害者又は運転者以外の第三者に故意又は過失があつたこと並びに自動車に構造上の欠陥又は機能の障害がなかつたことを証明したときは、この限りでない。

Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх
3-р зүйл. Өөрийн төлөө тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа этгээд нь түүнийг хөдөлгөөнд ашиглах явцдаа бусдын амь нас, эсхүл бие махбодод гэм хор учруулсан бол үүний улмаас бий болсон хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Гэвч тухайн этгээд өөрөө болон жолооч нь тухайн тээврийн хэрэгслийг ашиглахдаа анхаарал болгоомж алдаагүй, хохирогч эсхүл жолоочоос бусад гуравдагч этгээдийн санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол бий болсон, тухайн тээврийн хэрэгслийн хувьд эвдрэл, гэмтэл эсхүл ямар нэгэн доголдол байгаагүй болохыг нотолсон тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

Тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх асуудлыг хангах тухай хуулийн 3-р зүйлийн урьдчилсан нөхцөлийг дор авч үзье.

1. Хохирогч нь тус хуулийн 3-р зүйлд заасан “бусдын” гэх нөхцөлийг хангасан байх;
2. Хохирогчийн амь нас эсхүл бие махбодод гэм хор учруулсан байх;
3. Хохирогчийн амь нас, эсхүл бие махбодод учирсан гэм хор нь тухайн тээврийн хэрэгслийн “хөдөлгөөн”-ий улмаас бий болсон байх;
4. Хохирогчид хохирол учирсан байх;
5. Хохирогчийн амь нас, бие махбодод учирсан гэм хор болон Хохирогчид учирсан хохирол хоорондын шалтгаант холбоо;
6. Тухайн ослын хувьд гэм хор учруулсан этгээд нь тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигч байх.

Дээрх 3-р зүйлийн урьдчилсан нөхцөлийн тайлбарыг дор товч танилцуулъя.

Нэгдүгээрт “бусдын” гэх нөхцөлийн тайлбарыг авч үзвэл, шүүхийн жишигт хохирогч гэдэгт тээврийн хэрэгслийн эзэмшигч болон жолоочоос бусад этгээдийг ойлгоно гэх байдлаар тайлбарлан хэрэглэж байна. Гэхдээ тээврийн хэрэгслийн эзэмшигч нь олон этгээд байх тохиолдолд, зарим нь нөгөө эзэмшигчийнхээ хувьд “бусдын” гэх нөхцөлийг хангах тохиолдол байж болно. Мөн жолоочийн хувьд ч гэсэн хоёр этгээд жолоогоо сольж, ээлжилж барьж байсан тохиолдолд нэг нь жолоодож байхад гэмтсэн этгээдийн хувьд мөн адил “бусдын” гэх нөхцөлийг хангадаг гэж үздэг. Жолоочтой хамт сууж явсан гэр бүлийн гишүүд нь тээврийн хэрэгсэл эзэмшигчид хамаарахгүй бол хохирогчид тооцогдох боломжтой байдаг байна.

“Хохирогчийн амь нас, эсхүл бие махбодод гэм хор учруулсан байх” гэх хоёрдох урьдчилсан нөхцөлийг аваад үзвэл зөвхөн амь нас, эсхүл бие махбодод учирсан хохирлоор л тус 3-р зүйлийн хамгаалалтын хүрээ, хязгаар тодорхойлогдоно гэсэн утгыг илэрхийлдэг гэж үздэг. Харин эд зүйл гэмтсэн бол ерөнхий зохицуулалтын дагуу буюу Иргэний хуулийн 709-р зүйлийн дагуу шийдвэрлэнэ гэж тайлбарлагддаг байна.

“Хохирогчийн амь нас, эсхүл бие махбодод учирсан гэм хор нь тухайн тээврийн хэрэгслийн “хөдөлгөөн”-ий улмаас бий болсон байх” гэх гуравдах урьдчилсан нөхцөлийн тайлбарыг авч үзвэл, энэ үндсэндээ хууль зүйн тайлбарын хувьд дөрвөн өөр, хоорондоо ялгаатай онолын тайлбарыг үүсгэдэг. Үүнд:

1. Замын хөдөлгөөнд оролцож байгаа тохиолдол хамаарна. Энэ нь хөдөлгүүрийг асаасан үеэс эхэлсэнд тооцогдоно. Хөдөлгүүр унтарч, дугуй зогссон үеэс дуусгавар болсонд тооцогдоно гэх хандлага.
2. Мөн экскаватор, ачааны машин, бульдозер, кран гэх мэт хэрэгслийн хувьд тухайн хэрэгсэлд суурилуулсан төхөөрөмж ажиллаж байх тохиолдлыг хамарна гэж үздэг буюу тусгай эд ангийн хувьд авч үзэх хандлага.
3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг явах төдийгүй, зогсох үйлдлийг хамруулан тодорхойлно гэх хандлага.
4. Хоёрдох тайлбарыг үгүйсгэдэг хандлага буюу зөвхөн явах эд ангийн хувьд л ажиллаж байхад хөдөлгөөн гэж үзнэ гэх хандлага.

Бусад урьдчилсан нөхцөлийн хувьд өмнө тайлбарласан бөгөөд зарим урьдчилсан нөхцөлийн хувьд Монгол Улсын хувьд мөн адил нийтлэг байдлаар авч үзэгддэг тул энд дахин нурших нь илүүц биз ээ.

4.2. ХБНГУ

4.2.1. Тээврийн хэрэгслийн хамаарах этгээдийн хариуцлага ба харьцуулалт

ХБНГУ-ын хувьд 1909 оноос хойш тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд хариуцлага хүлээлгэсээр ирсэн бөгөөд 1909 онд батлагдсан *Gesetz über den Verkehr mit Kraftfahrzeugen* буюу Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тухай хуулиар зохицуулагддаг байжээ. Улмаар 1953 оноос тус хуулийг шинэчилж *Straßenverkehrsgesetz (StVG)* буюу Замын хөдөлгөөний тухай хууль гэж нэрлэх болжээ.

Өдгөө тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн хариуцлагыг *Straßenverkehrsgesetz (StVG)* буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн дагуу шийдвэрлэж байна.

§7 Liability of the Keeper of a Vehicle

(1) If in the course of the operation of a motor vehicle or a trailer, designed to be taken along with a vehicle, a person is killed, the body or the health of a person is injured or an object is damaged, the keeper of the motor vehicle is obliged to compensate the injured party for the damage resulting therefrom.

(2) The duty to compensate is excluded if the accident is caused by force majeure.

(3) If somebody uses the vehicle without the knowledge and consent of the keeper of the vehicle that person is liable to pay compensation for the damage in the place of the keeper; in addition the keeper himself remains liable to pay compensation if the use of the motor vehicle was facilitated by his negligence. The first sentence of this paragraph does not apply if the person using the vehicle was employed by the keeper for the purpose of operating the vehicle or if he was entrusted with the vehicle by the keeper. Sentences 1 and 2 are to be applied accordingly to the use of a trailer.

7-р зүйл. Тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн хариуцлага

7.1. Тээврийн хэрэгсэл эсхүл тээврийн хэрэгслийн чиргүүлийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас хохирсон, бие махбод, эрүүл мэндэд гэм хор учирсан, эд зүйл гэмтсэн бол тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь үүний улмаас хохирсон этгээдэд хохирол нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

7.2. Осол нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болсон тохиолдолд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээхгүй.

7.3. Хэн нэг этгээд тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд мэдэгдэлгүй, түүний зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласан бол тухайн этгээд нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн оронд хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээх бөгөөд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрийн гэм буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломжийг бусдад олгосон бол хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа этгээдийг тухайн тээврийн хэрэгслийг ашиглуулах зорилгоор тээврийн хэрэгслийг хамаарах этгээд ажиллуулсан эсхүл тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрөө тухайн этгээдэд тээврийн хэрэгслийг ашиглах эрх олгосон бол энэ хэсгийн нэгдэх өгүүлбэрийн зохицуулалтыг хэрэглэхгүй. Тус хэсгийн өгүүлбэр 1 болон 2-т заасан зохицуулалтыг тээврийн хэрэгслийн чиргүүлийг хэрэглэх тохиолдолд нэгэн адил хэрэглэнэ.

ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалттай дор харьцуулж үзүүлэв.

ХБНГУ-ын Замын хөдөлгөөний тухай хуулийн 7-р зүйл	Монгол Улсын Иргэний хуулийн 499-р зүйл
<p>7.1. Тээврийн хэрэгсэл эсхүл тээврийн хэрэгслийн чиргүүлийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас хохирсон, бие махбод, эрүүл мэндэд гэм хор учирсан, эд зүйл гэмтсэн бол тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь үүний улмаас хохирсон этгээдэд хохирол нөхөн төлөх үүрэг хүлээнэ.</p>	<p>499.1. Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй.</p>
<p>7.2. Осол нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болсон тохиолдолд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээхгүй.</p>	<p>499.2. Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол энэ хуулийн 499.1-д заасан үүрэг үүсэхгүй.</p>
<p>7.3. Хэн нэг этгээд тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд мэдэгдэлгүй, түүний зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласан бол тухайн этгээд нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн оронд хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээх бөгөөд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрийн гэм буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломжийг бусдад олгосон бол хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа этгээдийг тухайн тээврийн хэрэгслийг ашиглуулах зорилгоор тээврийн хэрэгслийг хамаарах этгээд ажиллуулсан эсхүл тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрөө тухайн этгээдэд тээврийн хэрэгслийг ашиглах эрх олгосон бол энэ хэсгийн нэгдэх өгүүлбэрийн зохицуулалтыг хэрэглэхгүй. Тус хэсгийн өгүүлбэр 1 болон 2-т заасан зохицуулалтыг тээврийн хэрэгслийн чиргүүлийг хэрэглэх тохиолдолд нэгэн адил хэрэглэнэ.</p>	<p>499.3. Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.</p> <p>499.4. Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.</p>

Дээрх товч харьцуулалтаас дүгнэхэд, Монгол Улсын Иргэний хуулийн 499-р зүйл нь ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн зохицуулалттай адил агуулгатай гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Монгол Улсын Иргэний хуулийн зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалтад хуучнаар ЗХУ төдийгүй ОХУ, ХБНГУ-ын Иргэний хуулиуд болон бусад нарийвчилсан зохицуулалттай хууль тогтоомж зохих нөлөөг үзүүлсэн гэдгийг нэгэнт Иргэний эрх зүй судлаачид хүлээн зөвшөөрч, өөрсдийн судалгаагаар ч батлан харуулж байгаа билээ.

ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсэгтэй адил зарчим буюу гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд суурилсан байгааг харж болохоор байна. Мөн Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн 7-р зүйлийн 7.2 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.2 дахь хэсэг, харин 7.3 дахь хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.3 болон 499.4-тэй адил агуулгатай байна. Тиймээс ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн хэм хэмжээ нь МУ-ын Иргэний хуулийн 499-р зүйлд хүчтэй нөлөө үзүүлсэн гэж таамаглах бүрэн боломжтой.

4.2.2. Хуулийн тайлбар

ХБНГУ-ын Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсгийн товч тайлбарыг дор авч үзье.

7.1. Тээврийн хэрэгсэл эсхүл тээврийн хэрэгслийн чиргүүлийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас хохирсон, бие махбод, эрүүл мэндэд гэм хор учирсан, эд зүйл гэмтсэн бол тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь үүний улмаас хохирсон этгээдэд хохирол нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

Уг 7-р зүйлийн 7.1 дэх хэсгийн хувьд “Тээврийн хэрэгслийг хамаарах этгээд” гэдгийг тээврийн хэрэгслийг өөрийн ашиг сонирхлын төлөө

ашиглаж, тээврийн хэрэгслийг өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээд хэмээн тайлбарлах хандлага түгээмэл байдаг байна³³. Гэхдээ тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь ердийн тохиолдолд өмчлөгч байх бөгөөд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь заавал өмчлөгч байх албагүй гэж тайлбарладаг. Мөн тээврийн хэрэгслийг богино хугацаагаар бусдад шилжүүлэх нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээд гэх статусыг өөрчлөхгүй гэх шалгуур нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгджээ. Тиймээс санхүүгийн түрээсийн гэрээ зэрэг урт хугацаагаар бусдад түрээслэх тохиолдолд тухайн гэрээний хүчинтэй хугацаанд түрээслэгч нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд тооцогдохоор байна³⁴.

Харин тус хэсэг дэх “хөдөлгөөний улмаас” гэх нөхцөлийг “хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслээс гадна, зогсож байгаа тээврийн хэрэгслийг нэгэн адил хамруулан тогтооно гэж тайлбарладаг байна. Гэхдээ машин нь угаалгын газрын төхөөрөмжийн тусламжтай хөдөлж байгаа, эсхүл барилгын ажил явагдаж байгаа хашаан дотор явж байгаа тээврийн хэрэгслийн хувьд “хөдөлгөөний улмаас” гэх нөхцөлийг хангахгүй гэх байдлаар тайлбарласан шүүхийн тайлбар мөн гарсаар байдаг³⁵. Өмнө дурдсанчлан Япон Улсын хувьд “хөдөлгөөний улмаас” гэх нөхцөлийг тайлбарлах дөрвөн ялгаатай хандлага байсан. Харин ХБНГУ-ын хувьд Япон Улс дахь тусгай эд ангийн хувьд авч үзэх хандлагыг үгүйсгэдэг төдийгүй, зогсож байгаа тээврийн хэрэгслийг мөн адил хөдөлгөөнд хамааруулан тооцдоггоороо Япон Улс дахь 3 дахь хандлагатай ижил байр суурийг илэрхийлдэг гэж дүгнэж болохоор байна.

³³ Рейхийн Иргэний хэргийн шүүхийн шийдвэр: RGZ 127, 175: Холбооны анхан шатны шүүхийн шийдвэрийн эмхэтгэл: BGHZ 13, 354.

³⁴ Шүүхийн шийдвэр: BGH VersR 1983, 656.

³⁵ Шүүхийн шийдвэр: KG VersR 1977, 626, Öster. OGH JBI 1972, 539.

7.3. Хэн нэг этгээд тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд мэдэгдэлгүй, түүний зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласан бол тухайн этгээд нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээдийн оронд хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээх бөгөөд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрийн гэм буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломжийг бусдад олгосон бол хохирол нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа этгээдийг тухайн тээврийн хэрэгслийг ашиглуулах зорилгоор тээврийн хэрэгслийг хамаарах этгээд ажиллуулсан эсхүл тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрөө тухайн этгээдэд тээврийн хэрэгслийг ашиглах эрх олгосон бол энэ хэсгийн нэгдэх өгүүлбэрийн зохицуулалтыг хэрэглэхгүй. Тус хэсгийн өгүүлбэр 1 болон 2-т заасан зохицуулалтыг тээврийн хэрэгслийн чиргүүлийг хэрэглэх тохиолдолд нэгэн адил хэрэглэнэ.

Харин 7-р зүйлийн 7.3 дахь хэсгийн хувьд дараах ойлголтын тайлбар нь нэлээд чухалд тооцогдоно. Тус зохицуулалтын хувьд нэгдүгээрт тээврийн хэрэгслийг хамаарах этгээдэд “мэдэгдэлгүй”, түүний “зөвшөөрөлгүй” гэх хоёр нөхцөлийг нэлээд сайтар тайлбарлах шаардлагатай гэж дүгнэсэн байдаг.

“ohne Wissen und Willen” гэх ойлголтыг 499-р зүйлийн 499.3 дахь хэсгийн хувьд “зөвшөөрөлгүйгээр” гэж хязгаарласан байна. Энэхүү ойлголтыг ХБНГУ-ын зүгээс тус зохицуулалтын хувьд хүсэл зориг гэх нөхцөл ихээхэн ач холбогдолтой гээд хэрвээ тээврийн хэрэгслийг хамаарах этгээд өөрийнх нь хүсэл зоригийн эсрэг буюу зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа талаар санамсаргүй мэдсэн байсан ч уг зохицуулалтыг хэрэглэх явдлыг үгүйсгэхгүй гэж тайлбарладаг байна³⁶. Харин тээврийн хэрэгслийг хамаарах этгээд нь өөрөө хүсэл зоригийнхоо үндсэн дээр тээврийн хэрэгслийг ашиглуулсан тохиолдолд түүний хүсэл зоригоос эсрэг байдлаар тээврийн хэрэгслийг ашигласан байсан ч тэрээр 7-р зүйлийн 7.3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийн дагуу дангаараа хариуцлага хүлээнэ гэж үздэг ажээ³⁷.

³⁶ Reinhard Greger, Haftungsrecht der Straßenverkehrs: Handbuch und Kommentar, Verlag De Gruyter, 5 Aufl. 2014 S.103

³⁷ Мөн тэнд

Тус 7-р зүйлийн 7.3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр дэх “ажиллуулсан буюу *Anstellung*” гэх ойлголтын хувьд тээврийн хэрэгслийг хамаарах этгээд болон түүний төлөөлөгчийн зүгээс өгсөн үүрэг, даалгавар болон удирдлагын дор тээврийн хэрэгслийг жолоодох эсхүл тухайн тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг өөрөө дангаараа бие даан шийдвэрлэх боломжийг олж авсан этгээдийн хувьд үйлчилнэ гэж тайлбарладаг бөгөөд тус ажиллуулсан гэх нөхцөлийн хувьд заавал хөдөлмөрийн эрх зүй дэх нөхцөл хангагдсан байхыг шаарддаггүй байна³⁸.

Харин 7-р зүйлийн 7.3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр дэх “ашиглах эрх олгосон буюу *Überlassung*” гэх ойлголт нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээд тухайн тээврийн хэрэгслийг бодит байдалд ашиглах явдлыг өөр этгээдэд зөвшөөрсөн байхыг ойлгоно. Гэхдээ тухайн этгээд нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээд болохгүй байх тохиолдол үүнд хамаарна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг бусдад хөлслөх буюу түрээслэх, ашиглуулах, ажил олгогч нь ажилтандаа тээврийн хэрэгслийг өөрийнх нь төлөө ашиглах эрхийг олгох гэх мэт тохиолдлыг хамааруулж авч үздэг³⁹.

Мөн 7-р зүйлийн 7.3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийн талаар “хэрвээ ажилтан нь хууль бус үйлдлийн улмаас бусдад гэм хор учруулсан бол ажил олгогч нь 831-р зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ” гээд “ажилтан нь ажил олгогчид мэдэгдэлгүйгээр, эсхүл түүний зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласан бол 831-р зүйлийг хэрэглэхгүй⁴⁰. Гэхдээ ажил олгогч нь өөрийн гэм буруугаас ашиглах боломжийг олгосон бол тэрээр 7-р зүйлийн 7.3-ийн дагуу хариуцлага хүлээнэ” гэж тайлбарласан байна⁴¹.

Харин 831-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх тохиолдлын хувьд “ажил олгогч нь ажилтныг сонгох, хянахдаа алдаа гаргасан тохиолдолд хариуцлага хүлээх” бөгөөд тэрээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болохоо нотолсон тохиолдолд л хариуцлагаас чөлөөлөгдөнө. Тээврийн хэрэгслийг жолооддог ажилтнаа автомашиныг хэрхэн жолоодож байгаа болохыг байнга хянаж байх шаардлагатай. Олон жилийн туршлага, осол гаргаж байсан эсэхийг нягтлан шалгахад

³⁸ Мөн тэнд

³⁹ Мөн тэнд

⁴⁰ BGHZ 116,104,114 дам ишлэв.

⁴¹ Chi-Chou Yeh, *Der Verkehrssopferschutz und dessen Entwicklung*, Mohr Siebeck, 2007, S.42

хангалттай гэж тайлбарласан нь бий⁴².

Түүнчлэн Straßenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн 8-р зүйлийг дор дурдах шаардлагатай.

8-р зүйл. Дараах тохиолдолд 7-р зүйлийн зохицуулалтыг хэрэглэхгүй.

1. Осол нь 20 км цагаас илүү хурдтайгаар замаар явах боломжгүй тээврийн хэрэгсэл эсхүл осол болох үед тухайн тээврийн хэрэгсэлтэй холбогдсон байсан чиргүүлийн хөдөлгөөний улмаас үүссэн бол;

2. Гэмтсэн этгээд өөрөө тухайн тээврийн хэрэгслийг удирдаж байсан бол;

3. Эд зүйлийг зорчигч өөрийн хамт авч яваагүй бөгөөд осол гарах үед тээврийн хэрэгсэл болон түүний чиргүүлд тээвэрлэгдэж байсан эд зүйл байсан бол.

Strassenverkehrsgesetz (StVG) буюу Замын хөдөлгөөний тухай хуулийн хуучин зохицуулалтаар бол (8а) зөвхөн арилжааны шинжтэй буюу хариу төлбөртэй зорчигч тээврийн тохиолдолд л тус хуулийн зохицуулалтын дагуу хариуцлага тооцдог байсан бол одоогийн зохицуулалтаар хариу төлбөртэй болон төлбөргүй эсэхээс үл хамааран зорчигч тээврийн тохиолдолд тус хуулийн 7-р зүйлийн дагуу хариуцлага тооцдог болсон байна.

Тус хуулийн 8-р зүйлийн дагуу 20 км/ц-аас илүү хурдтай явах боломжгүй тээврийн хэрэгсэл болон гэмтсэн этгээд буюу хохирогч нь өөрөө тээврийн хэрэгслийг удирдаж байсан бол эд зүйлийг тээвэрлэж байсан бол 7-р зүйлд заасан гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх тогтолцоо үйлчлэхгүй байхаар хуульчилжээ.

Харин тус хуулийн 18-р зүйлийн дагуу тээврийн хэрэгслийн жолооч нь тээврийн хэрэгслийг хамаарах этгээдтэй нэгэн адил хариуцлага хүлээхээр зохицуулсан боловч жолооч нь өөрийгөө тухайн осолд гэм буруугүй болохоо нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө гэх байдлаар хуульчилжээ. Тиймээс Монгол Улсын хувьд жолооч байгаа тохиолдолд тэрээр нэгэн зэрэг тээврийн хэрэгслийн эзэмшигч байсан бол хэрхэн

⁴² BGH VersR 1961, 330; 1984, 61. Дам ишлэв.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

шийдвэрлэх вэ гэсэн асуудлыг дахин нарийвчлан судалж тогтоох шаардлагатай байна. Тээврийн хэрэгслийн эзэмшигч өөрөө жолооч байсан бол 497-р зүйлийг хэрэглэх эсэхийг дахин нарийвчлан судлах нь зүйтэй болов уу? Учир нь 499-р зүйлийн үндсэн зарчим нь тээврийн хэрэгсэл нь өөрөө өндөр хурдтай явдаг механизм буюу аюултай зүйлд хамаарах тул түүнийг эзэмшигчид гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх эсхүл 497-р зүйлээс илүү хүндрүүлсэн нөхцөлөөр хариуцлага хүлээлгэхэд оршино.

5. ДҮГНЭЛТ

Судлаачдын зүгээс Иргэний хуулийн 499-р зүйлийн дагуу гурван шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 10 хэргийг ашиглан тус 499-р зүйлийн хэрэглээний талаар дүгнэж, мөн гадаад орны хууль тогтоомж, хууль зүйн тайлбар, онолын ойлголттой харьцуулсан судалж дүн шинжилгээ хийлээ. Уг судалгааны үр дүнг үндэслэг дараах дүгнэлтийг хийж байна.

1. Шүүхийн зүгээс фидуцийн дагуу буюу үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний үндсэн дээр тээврийн хэрэгслийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээдийн хувьд 499-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэсэн болон хүлээлгэлгүй шийдвэрлэсэн буюу зөрүүтэй шийдвэр гаргасан тохиолдол байлаа. Энэ тохиолдолд “тээврийн хэрэгсэл эзэмшигч” гэх ойлголтыг тайлбарлахдаа тодорхой шалгуурыг ашиглах шаардлагатай. Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд тээврийн хэрэгсэл эзэмшигчийг тодорхойлохдоо тухайн тээврийн хэрэгслийн хурд гэх аюултай нөхцөл байдлыг өөрийн хяналтдаа байлгах боломжтой буюу эрсдэлийг удирдах боломжтой, өөрийнхөө мэдэлд байлгаж байгаа бөгөөд өөрийнхөө ашиг сонирхлын төлөө ашигладаг этгээдийг ойлгохоор байна. Гэвч фидуцийн гэрээний үндсэн дээр тээврийн хэрэгслийн өмчлөлийг олж авсан этгээд нь эрсдэлийг удирдах боломжгүй этгээд болно. Иймд үгчилсэн бус, харьцангуй тогтвортой онолын тайлбарыг хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ байна. Эс бөгөөс шүүхийн практик тогтворгүй болох эрсдэлтэй.
2. 499-р зүйлийн “бусдын” гэх нөхцөлийг сайтар тайлбарлах, агуулга, чиг үүргийг нь зөв тайлбарлах шаардлагатай байна. Хэрэг №7-г энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Хамтран амьдрагчийнхаа автомашиныг унаж байхдаа осолдож, тухайн автомашинд хохирол учруулсан тохиолдолд энд “бусдын ... эд юмс” гэх нөхцөлийг хангаагүй байгааг заавал анхаарах шаардлагатай байсан. Тиймээс цаашид “бусдын” гэх нөхцөлийг зөв тайлбарлан хэрэглэх шаардлагатай байна. Нэхэмжлэгч өөрийн тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсгийн дагуу шаардах нь “бусдын” гэсэн

- урьдчилсан нөхцөлийг хангахгүй тул 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийн дагуу шаардана гэж тайлбарлах нь зохистой байна.
3. 499-р зүйл болон 497-р зүйлийн хувьд зарчмын маш том зөрүүтэй хэм хэмжээ байтал аль алиныг үндэслэн шийдвэр гаргах явдал түгээмэл байлаа. Гэвч энэ тохиолдолд аливаа шаардах эрхийн үндэслэлийг л үндэслэх шаардлагатай билээ. Хамтатган хэрэглэх нь онолын хувьд боломжгүй болохыг энд дурдах нь зүйтэй.
 5. Түүнчлэн 499-р зүйлийн 499.4 дэх хэсгийн хэрэглээг 498-р зүйлийн хэрэглээтэй хэрхэн уялдуулах, ялгааг нь хэрхэн тайлбарлах талаар цаашид шүүхийн практикийг судлах шаардлагатай. Учир нь 498-р зүйлийг гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд суурилсан гэж тайлбарлах боломжтой ч шүүхийн практикт холимог байдлаар тайлбарлаж байгаа. Өөрөөр хэлбэл, ажил олгогч өөрийгөө гэм буруугүй болохыг нотлох боломжийг олгож байгаа.
 6. “Жолооч” гэх ойлголтыг сайтар тайлбарлах шаардлагатай байна. Жолооч гэдэг нь өөрийнхөө төлөө бус, бусдын төлөө, бусдын ашиг сонирхлын төлөө тээврийн хэрэгслийг жолоодож байгаа этгээд болно. Жолоочийн эсрэг нэхэмжлэл гаргасан тохиолдолд 497-р зүйлийг хэрэглэх нь 499-р зүйлийн ач холбогдлыг алдагдуулах боломжийг олгож байна. Тээврийн хэрэгслийг эзэмшигч өөрөө жолоодож байгаа тохиолдолд тэрээр жолооч гэх категорид хамаарахгүй. Тиймээс 499-р зүйлийн дагуу шийдвэрлэх нь зохистой.
 7. 514-р зүйл нь өөрөө шаардах эрхийн хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэхэд чиглэсэн эрх биш гэж тайлбарлах нь зохистой тул хариуцагч нотлох үүрэг хүлээхгүй, харин шүүх өөрийн бүрэн эрхийн хүрээнд хохирлын хэмжээг тогтоохдоо хохирогчийн болгоомжгүй үйлдэл болон эс үйлдэл, хохирол нэмэгдэхтэй холбоотой шалтгаант холбоо бий эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргана гэж тайлбарлах нь илүү зохистой. Шалтгаант холбооны хувьд адекватацийн онолыг ашиглах боломж байна.
 8. Шүүхийн зүгээс 514-р зүйлийг хэрэглэхдээ хурд хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжлэгчийн гэм буруугийн нөлөөллийг 50 хувь гэж үзэж хохирлыг бууруулсан тохиолдол байна. Харин жолооч

аюул саад бий болсон тохиолдолд хурдаа хасаж, зайлшгүй тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоох үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруугийн нөлөөллийг 20 хувь гэж үзэж, хохирлыг мөн хэмжээгээр хасаж тооцсон байна.

9. Монгол Улсын хувьд 499-р зүйлийн хувьд ХБНГУ-ын хууль тодорхой нөлөө үзүүлсэн байх боловч харьцуулан үзвэл, зохицуулалтын хувьд дугуу, системчлэл нь ойлгомжгүй байх тул цаашид ХБНГУ-ын нөлөөн дор онолоо боловсруулан хөгжүүлж ирсэн Япон Улстай адил, ХБНГУ-тай адилаар Иргэний хуулиас нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийг боловсруулах шаардлагатай эсэхийг судлах нь зохистой болов уу.
10. Мөн 499-р зүйлийн хувьд “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэх нэр томъёог ашигласан боловч харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд Япон Улсын хувьд “тээврийн хэрэгслийг ашиглагч” гэж, ХБНГУ-ын хувьд “тээврийн хэрэгслийг хамаарах этгээд” гэх байдлаар томъёолсон байх тул нэр томъёог цаашид нарийвчлан судалж, өөрчлөх шаардлагатай.

ХАВСРАЛТ

Хэрэг №1. 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00048 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч Г-гийн нэхэмжлэлтэй хариуцагч “Н” ХХК, А нарт холбогдох, гэм хорын хохиролд 4,18,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Г-ийн эзэмшлийн приус загварын автомашиныг А нь верна загварын тээврийн хэрэгслийг жолоодож яваад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2.7, 8.4, 9.2-т заасныг зөрчиж, зам тээврийн осол гаргасны улмаас Г-д 3,300,000 төгрөгийг хохирол учирсан. Үүнээс нэхэмжлэгч Г нь даатгалын байгууллагаас 2,935,000 төгрөгийг нь авсан ба верна загварын тээврийн хэрэгслийн эзэмшигч “Н” ХХК-иас гэм хорын хохирол болох эмчилгээний төлбөр 290,000 төгрөг, автомашины үнэлгээний төлбөр 105,000 төгрөг, архиваас материал гаргуулсны хөлс 16,000 төгрөг, нотариатын зардал 7,000 төгрөг, нийт 418,000 төгрөгийг гаргуулахаар шаарджээ.

А-нь 2016 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр верна загварын автомашиныг барьцаалан “Н” ХХК-иас 1,350,000 төгрөгийн зээл авахдаа зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх фидуцийн гэрээ байгуулсан. Зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд А-ийн өмчлөлд байгаа автомашиныг “Н” ХХК-ийн өмчлөлд шилжүүлэх гэрээ байгуулж, зээлдэгч буюу А нь автомашинаа унаж ашиглаж байжээ. Эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх фидуцийн гэрээний 5.1.4-т барьцааны тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс эвдэрч, устаж, гэмтсэн тохиолдолд байгууллагад хамааралгүй бөгөөд үүрэг гүйцэтгэгч бүрэн хариуцахаар тохиролцжээ. Гиймээс Г-д учирсан хохирлыг “Н” ХХК хариуцахгүй гэжээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 102/ШШ2018/02061 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар “Н” ХХК-иас 398,000 төгрөг

гаргуулан Г-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 20,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар А, Ө нарт холбогдох гэм хорын хохирол гаргуулах тухай хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 1806 дугаар магадлалаар Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 102/ШШ2018/02061 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Шүүх “Н” ХХК-ийг 499.4 дэх заалтын дагуу өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг эзэмшигчийг өөрөө томилсон буюу А-д шилжүүлэн өгсөн гэж дүгнэсэн боловч тус верна маркийн тээврийн хэрэгсэл нь “Н” ХХК-ийн өмч хөрөнгө биш бөгөөд зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар байгууллагын өмчлөлд түр шилжүүлсэн л үйлдэл юм. Иймд шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Нэхэмжлэгч нь хариуцагчаар А-г нэхэмжлэлдээ татсан боловч эдгээр хариуцагч нарын хаяг тодорхой бус учир хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлээ зөвхөн “Н” ХХК-д холбогдуулсан байна.

Хариуцагч “Н” ХХК нь шаардлагыг эс зөвшөөрч, авто осолд ямар нэг хамааралгүй, А-гийн эзэмшлийн верна маркийн суудлын автомашиныг зээлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор фидуцийн гэрээгээр өөрийн өмчлөлд шилжүүлэн авснаар тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гэж нэхэмжлэлийг татгалзжээ.

Хариуцагч “Н” ХХК нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.1-д заасан фидуцийн гэрээгээр А-гаас эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн авсан ба талууд автомашиныг зээлдэгч ашиглах эрхтэй болохыг тохиролцжээ. Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх фидуцийн гэрээгээр үүрэг хүлээгч нь мөнгө төлөх

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээдэг ба шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байхаар гэрээнд зааж болдог байна.

Тээврийн хэрэгслийн онцлогоос хамааран энэхүү эд хөрөнгийн ашиглалтын улмаас бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч арилгах үүрэг хүлээдэг нь гэм буруугүйгээр хүлээдэг хариуцлагын төрөл юм. Бусдад гэм хор учруулсан гэм буруутай этгээд буюу тээврийн хэрэгслийн ашиглагч нь өмчлөгчийн ийнхүү бусдын өмнө үүрэг хүлээснээс учирсан хохирлыг арилгах үүргээс чөлөөлөгдөхгүй болно. Өөрөөр хэлбэл, хариуцагч “Н” ХХК нь өөрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй юм.

Хэрэг №2. 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр, Дугаар: 001/ХТ2017/00817 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Г, Ж-ийн нэхэмжлэлтэй Хаан банк, И, Б нарт холбогдох 6,126,234 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг.

Хаан банк ХХК-ийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг иргэн И нь Хаан банктай 2014 оны 6 дугаар сарын 4-ний өдөр “Зээлийн гэрээ” болон “Фидуцийн гэрээ” байгуулан худалдан авсан. Уг автомашиныг иргэн Ч жолоодож явахдаа Замын хөдөлгөөний дүрмийн 2.3 дахь заалтыг зөрчсөний улмаас 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хашаа, гэрэлтүүлэгч шон, приус маркийн автомашин, Г-ийн гэр бүлийн амьдарч байсан монгол гэр зэргийг мөргөж, улмаар монгол гэрт байсан Г, Ж, О нарыг гэмтээжээ. Г хэвтрийн дэглэмтэй байсан 2 сарын хугацаанд приус маркийн автомашинаараа такси үйлчилгээнд явж олох байсан орлого, өдрийн орлого 50,000 төгрөгөөр тооцон нийт 3 сая төгрөг, эд хөрөнгөд учирсан хохирол 4,144,500 төгрөг, эрүүл мэндэд учирсан хохирол 1,507,513 төгрөг, түрээсийн байрны төлбөр болох 700,000 төгрөг, бусад зардал 219,300 төгрөг нийт 9,571,313 төгрөг гарсан. Эдгээрээс Бодь даатгал ХХК-иас төлөгдсөн 3,445,079 төгрөгийг хасаж 6,126,234 төгрөгийг хариуцагч нараас гаргуулахаар шаарджээ.

Хаан банкны зүгээс Фидуцийн гэрээний 2.4.5 дахь заалтад “... Хөрөнгийг эзэмших, ашиглах явцад бусдын хөрөнгөд учруулсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна...” гэж заасны дагуу аливаа бусад этгээдүүдэд учруулсан хохирлыг зээлдэгч нар өөрсдөө хариуцахаар тохиролцсон. Иймд иргэн Г, Ж нарын нэхэмжлэлтэй иргэний хэргийн хариуцагч нь Хаан банк биш гэжээ.

Хариуцагч И нь автомашинаа худалдах зар гаргасан бөгөөд Б худалдан авах талаар санал гаргаж автомашиныг 26 сая төгрөгөөр зарсан. Б нь мөнгийг бэлэн өгөх боломжгүй гээд 12 сая төгрөгт тооцож Приус 20 маркийн автомашин өгч, 12 сая төгрөгийг бэлнээр өгөөд үлдэгдэл 2 сая төгрөгийг автомашины нэрийг 2015 оны 3 дугаар сард шилжүүлж өгсөн үед төлөхөөр тохиролцсон тул тээврийн хэрэгслийг 2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Б хүлээн авсан. Иймд бид учирсан хохирлыг төлөх үндэслэлгүй гэж үзэж байна гэжээ.

Хариуцагч Б нь И-ийн шүүхэд өгсөн тайлбарыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь 2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр байгуулсан гэрээний дагуу тохирсон хугацаа болох 2015 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн дотор миний нэр дээр шилжүүлж өгнө гэсэн тохиролцоогоо зөрчсөн учраас бидний хооронд автомашин худалдах-худалдан авах гэрээ хийгдээгүй. Уг автомашин Хаан банкны нэр дээр өнөөдрийг хүртэл байгааг хэргийн материалаас харлаа. Би “автомашинаа ав биднээс авсан мөнгөө өг” хэмээн удаа дараа шаардсан боловч өнөөдрийг хүртэл өгөөгүй. И-г автомашинаа авахдаа мөнгө өгнө гэсэн үгэнд нь итгэсээр өнөөдрийг хүрсэн. Гэтэл И үнэн байдлаас зөрсөн худал тайлбар шүүхэд өгсөн байх тул миний бие автомашин худалдаж авахаар өгсөн 24 сая төгрөгөө буцаан авахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Иймд намайг хариуцагчаас чөлөөлж буруутай этгээд болох И болон Хаан банкнаас хохирлыг гаргуулж өгнө үү гэжээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 181/ШШ2016/01357 дугаартай шийдвэр гаргаж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.4, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасныг баримтлан Г, Ж нарын эд хөрөнгөд 4,144,500

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

төгрөгийн хохирол учирсан, нэхэмжлэгч нар 1,393,313 төгрөгийн эм тариа хэрэглэж, шатахуун болон нотариатын зардалд 148,500 төгрөг зарцуулан, 700,000 төгрөгөөр орон сууц хөлсөлж нийт 6.386.313 төгрөгөөр хохирсон... гэж дүгнэн, уг үнийн дүнгээс даатгалаас авсан 3,445,079 төгрөг хасаж үлдэх 2,941,234 төгрөгийг Б-ээс гаргуулж Г, Ж нарт олгож, нэхэмжлэлээс 3.185.000 төгрөгийн шаардлагыг Хаан банк ХХК, И нарт холбогдох нэхэмжлэлийн хамт хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 669 дугаартай магадлал гаргаж, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 181/ШШ2016/01357 дугаар шийдвэрийг хэвээр үлдээжээ.

4. Хариуцагч Б хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо:

И Иргэний хуулийн 243.1-т заасны дагуу эрхийн зөрчилгүй хөрөнгө, баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх гэснийг зөрчиж 2015 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн дотор тээврийн хэрэгслийн бичиг баримтыг өгч, нэрийг шилжүүлж өгнө гэсэн боловч өгөөгүй. Тухайн авто ачигчийг Б-ийн өмчлөлд шилжүүлээгүй, тээврийн хэрэгслийн бичиг баримт байхгүй байсан тул бид уг тээврийн хэрэгслийг түрээслүүлэх, ашиглуулах гэрээ хэлцэл хийж чадаагүй. Би удаа дараа шаардсан оловч бичиг баримтыг авчирч өгөөгүй. Иймд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Тухайн тээврийн хэрэгсэл Б-ийн өөрийнх нь эзэмшилд байх үед тээврийн хэрэгсэл ашиглагчийг томилж, Ч-д шилжүүлэн өгсөн, Ч 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр уг тээврийн хэрэгслийг жолоодон явахдаа Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2.3-ыг зөрчсөний улмаас зам тээврийн осол гарч, нэхэмжлэгч нарт хохирол учирсан үйл баримт нотлогдсон байна.

Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон, өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй. Иймд Г, Ж нарт учирсан гэм хорыг Б хариуцна. Тээврийн хэрэгслийг

худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаан нь Г, Ж нарын нэхэмжлэлтэй холбоогүй байх тул хяналтын шатны шүүхэд гаргасан Б-гийн гомдол үндэслэлгүй байна.

Хэрэг №3. 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдөр, Дугаар: 001/ХТ2016/00827 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Ч, Т нарын нэхэмжлэлтэй, “Транскапитал” ББСБ, Б, Л, Ж нарт холбогдох 5,373,500 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

Хариуцагч Ж нь 2013 оны 12 дугаар сарын 9-ний өдөр “Транскапитал” ББСБ-аас 3,000,000 төгрөгийн зээл авч, охин Л-д өгсөн, Л нь Соната-6 маркийн автомашин худалдан авч “Транскапитал” ББСБ-аас авсан 3,000,000 төгрөгийн зээлийн барьцаанд энэ машинаа барьцаалсан боловч тэрээр уг автомашиныг 2014 оны 1 дүгээр сард Б-д 6,500,000 төгрөгөөр худалдахаар тохирч 4,000,000 төгрөгийг Б нь Л-д бэлнээр өгч, үлдэгдэл 2,500,000 төгрөгийг “Транскапитал” ББСБ-аас авсан зээлийг сар бүр төлж дуусгахаар харилцан тохиролцжээ.

2014 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хариуцагч Б нь Соната-6 маркийн автомашиныг жолоодож яваад нэхэмжлэгч Ч-ийн жолоодож явсан Т-ийн эзэмшлийн “stortage” маркийн автомашины араас мөргөж гэм хор учруулсан. Хариуцагч Б нь Т-ийн эзэмшлийн автомашинд учруулсан хохирлоо нөхөн төлөх зорилгоор Ч-тэй “хохирол барагдуулах гэрээ”, “авто машин шилжүүлэх тухай” гэсэн баримт үйлдэж Соната-6 маркийн машиныг өр төлбөртөө өгөх, Ч нь “Транскапитал” ББСБ-д төлөх зээлийн үлдэгдэл 1,000,000 төгрөг, журмын хашааны төлбөр 172,000 төгрөгийг төлөөд машинаа авахаар тохиролцжээ.

Түүнчлэн нэхэмжлэгч Ч нь “Транскапитал” ББСБ-д Ж-ийн төлөх зээлийн үлдэгдэлд 1,001,000 төгрөг, хүүнд 309,000 төгрөг, журмын хашааны төлбөрт хариуцагч Б-ийн төлөх 172,000 төгрөгийг төлсөн нь баримтаар тогтоогджээ.

“Транскапитал” ББСБ нь Ж-ийн зээлийн үлдэгдэл хугацаандаа төлөгдөөгүй гэсэн үндэслэлээр 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нэхэмжлэгч Ч-ийн эзэмшлээс Соната-6 автомашиныг гаргуулан авч,

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

худалдан борлуулж Ж-ийн зээлийн үүргийг барагдуулсан гэх боловч хэдий хэмжээний төлбөрт тооцсон нь тодорхойгүй, хэрэгт энэ тухай баримт авагдаагүй байна.

Ингээд Нэхэмжлэгч Ч, Т нар нь “Транскапитал” ББСБ, Б, Л, Ж нараас гэм хорын хохирол 3,889,000 төгрөг, замын цагдаагийн журмын хашааны мөнгө 172,000 төгрөг, нотариатын зардал 2500 төгрөг, нийт 4,063,500 төгрөг гаргуулах, хариуцагч “Транскапитал” ББСБ Л, Ж нараас зээлд төлсөн 1,001,000 төгрөг, хүү 309,000 төгрөг нийт 1,310,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Орхон аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.4, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар Б-ээс 4,063,500 төгрөг, Иргэний хуулийн 491 дүгээр зүйлийн 491.6-д заасныг баримтлан Ж-ээс 1,310,000 төгрөг тус тус гаргуулан нэхэмжлэгч Ч, Т нарт олгож, нэхэмжлэлийн шаардлагаас “Транскапитал” ББСБ, Л нарт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 68 дугаар магадлалаар Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “...Иргэний хуулийн 491 дүгээр зүйлийн 491.6-д зааснаар Ж-ээс 1,310,000 төгрөг ...” гэснийг “Транскапитал ББСБ-аас 1,310,000 төгрөг гаргуулж гэж өөрчлөлт оруулж шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Хариуцагч Б-ийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3-т “Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй” гэж заажээ. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхүүд тээврийн

хэрэгслийн өмчлөгч болох “Транскапитал” ББСБ болон тээврийн хэрэгслийн эзэмшигч Ж, Л нарыг хариуцлагаас чөлөөлж хэргийг шийдвэрлэсэн. Ж охин Л нь “Транскапитал” ББСБ-ын өмчлөлийн, Соната-6 маркийн тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч нарынх нь зөвшөөрөлгүйгээр Б-д худалдаж, түүний эзэмшилд шилжүүлсэн болох нь хариуцагч Б, “Транскапитал ББСБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын анхан шатны шүүх хуралдаан дээр хэлсэн тайлбаруудаар тогтоогддог. Мөн 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 121312090220 дугаар “Лизингийн зээлийн болон барьцааны гэрээ”-н дээр хамтран зээлдэгчээр Л гэдэг хүн тухайн хэлцлийн нэг тал болж ийнхүү гэрээнд гарын үсэг зурсан гэдгийг ч “Транскапитал” ББСБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч анхан шатны шүүх хуралдаан дээр тайлбарладаг. Б гэм хорын төлбөр төлөх нь гарцаагүй ч Иргэний хуулийн 499.3-т зааснаар “Транскапитал” ББСБ болон Ж, Л нар ч мөн адил гэм хорын төлбөрийг хамтран нөхөн төлөх үүрэгтэй. Л нь дээрх гэрээгээр Ж-ийн адил “Транскапитал” ББСБ-ын өмнө үүрэг хүлээсэн эсэхэд анхан шатны шүүх дүгнэлт өгч, түүний эрх зүйн байдлыг зөв үнэлж, түүнийг хариуцагчаар татан оролцуулах хүсэлтийг хүлээн авалгүйгээр хэргийг хэлэлцэн шийдвэрлэсэн учраас хяналтын шатны шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй гэж үзэж шийдвэр, магадлалыг хүчингүй болгуулахаар ийнхүү гомдол гаргаж байна гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Б-ийн гэм буруутай үйлдэл, нэхэмжлэгч нарт учирсан гэм хортой шалтгаант холбоотой болох нь тогтоогдсон учир Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар нэхэмжлэгч Ч, Т нар өөрт учирсан эд хөрөнгийн хохирлыг хариуцагч Б-ээс шаардах эрхтэй.

Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд эд хөрөнгөнд гэм буруутай үйлдэл болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд хариуцагч Б-ийн гэм буруутай үйлдэл, нэхэмжлэгч нарт учирсан гэм хортой шалтгаант холбоотой болох нь тогтоогдсон, талууд гэм буруугийн тухайд маргаагүй байх тул Б-ээс гэм хорын хохиролд 4,063,500 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч нарт олгохоор шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д нийцжээ.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Харин Ж-ийн бусдад төлөх ёстой зээлийн үлдэгдэл 1,001,000 төгрөг, хүү 309,000 төгрөгийг нэхэмжлэгч Ч түүний нэрийн өмнөөс “Транскапитал” ББСБ-д төлсөн нь нотлох баримтаар тогтоогдож байх бөгөөд 1,310,000 төгрөгийг Ж-ээр төлүүлсэн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийн магадлалын үндэслэлийг буруутгах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, Ж-ийн авсан зээлийн барьцаанд барьцаалсан Соната-6 автомашиныг “Транскапитал” ББСБ Ч-ээс хураан авч худалдан борлуулж зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны хөрөнгөөр хангасан талаар хариуцагч байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараар нотлогдож байх тул нэхэмжлэгч Ч нь Ж-ийн зээлийн үлдэгдэл хүүнд 1,310,000 төгрөгийг “Транскапитал” ББСБ-д төлснийг төлбөр давхардсан гэж үзэх үндэслэлтэй тул уг мөнгийг “Транскапитал” ББСБ-аас гаргуулахаар өөрчилсөн нь үндэслэл бүхий байна.

Хэрэг №4. 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр, Дугаар: 001/ХТ2017/00402 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч Б-н нэхэмжлэлтэй, хариуцагч Өмнөговь аймгийн шүүхийн шинжилгээний албанд холбогдох, гэм хорын хохирол 79 333 400 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг.

2015 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Өмнөговь аймгийн Баруун сайханд замын уулзвар дээр Ланд крузер маркийн тээврийн хэрэгсэл Б-г иргэн Э-ийн жолоодож явсан Ява маркийн мотоциклийн ард зорчигчоор сууж явах үед нь мөргөсний улмаас Б-ийн биед хүнд зэргийн гэмтэл учирч, баруун хөлөө өвдөгний дээд хэсгээр тайруулсан байна. Зам тээврийн осол дээр тогтоосон актаар Н нь Замын хөдөлгөөний дүрмийн 12.9-т “Гол ба туслах замын уулзварт туслах замаар яваа жолооч гол замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө” гэсэн заалтыг зөрчсөний улмаас уг осол гаргасан нь дүгнэлтээр, Ланд крузер маркийн автомашин нь Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны өмчлөлд бүртгэлтэй болохыг эрүүгийн хавтаст хэрэгт тус тус тогтоосон байдаг.

Осол хэрэг гарахаас өмнө 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг “Хүннүгийн говь” ХХК-тай

Б нь барилгын ажил гүйцэтгэх, ажил гүйцэтгэсний хөлсөнд 50,021,500 төгрөг авахаар тохиролцож гэрээг байгуулсан. Гэрээ байгуулж ажил гүйцэтгэж эхэлснээс хойш Б нь уг мөнгөн дүнгээс 10,000,000 төгрөгийг авсан байсан ба осолд орсноос болж цаашид ажил үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүржээ. Хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 90 хувиар алдсан байна.

Иймд Б олох ёстой байсан орлого болох 40,021,500 төгрөг, сэтгэл санааны хувьд хүнд цохилтод орсон тул сэтгэл санааны хохирол 38,031,300 төгрөг, анхан шатны шүүх хуралдаанаас хойш эмчилгээнд зарцуулсан эмчилгээний зардал 143,900 төгрөг, эмчилгээнд болон эмнэлэгт очиход гарсан унааны зардал 186,700 төгрөг, хиймэл хөл (протез) хийлгэх зардал 950,000 төгрөг, нийт 79,333,400 төгрөгийг гаргуулан өгч хохиролгүй болгож өгөхийг шаарджээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 143/ШШ2016/00491 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэг, 499 дүгээр зүйлийн 499.4 дэх хэсэг, 505 дугаар зүйлийн 505.1 дэх хэсэгт зааснаар Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албанаас 21,291,350 төгрөгийг гаргуулан Б-д олгож, нэхэмжлэгч Б-н нэхэмжлэлийн шаардлагаас үндэслэлгүй нэхэмжилсэн 58,042,050 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 203/МА2017/00004 дүгээр магадлалаар Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 143/ШШ2016/00491 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-д зааснаар хариуцагч Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь давж заалдах гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөнийг дурдаж шийдвэрлэсэн байна.

4. Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Б-ийн “Хүннүгийн говь” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

гэрээнд гүйцэтгэх ажлын хэмжээ, үнэ байх боловч тухайн ажлыг хэдэн хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэх талаар тусгаагүй байдаг тул уг ажлыг хийж гүйцэтгэснээр авах ажлын хөлс нь дан ганц нэхэмжлэгчийн олох байсан орлого гэж үзэх боломжгүй. Тиймээс тус ажлыг хэдэн хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэх, тэдгээр нь мэргэжлийн ямар ур чадвартай, мэргэжлийн зэрэг байгаа эсэх, хүн тус бүр хэдэн төгрөгийн цалин хувааж авах түүнээс хэдэн төгрөг нь нэхэмжлэгчид оногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болох нь тогтоогдох боломжгүй байдаг.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Б.Батжаргалд учирсан гэм хор тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн, нэхэмжлэгч нь тээврийн хэрэгслийн эзэмшигчид холбогдуулан нэхэмжлэлээ гаргасан байх тул шүүх Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4, 505 дугаар зүйлийн 505.1-д заасан зохицуулалтыг хэрэглэсэн нь оновчтой болсон байна. Нэхэмжлэгчийн шаардах эрх хуулийн дээрх хэм хэмжээгээр нарийвчлан зохицуулагдсан тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг хэрэглэхгүй.

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4-т гэм хорыг гэм хор учруулаагүй этгээдээр буюу тээврийн хэрэгслийн эзэмшигчээр хариуцуулахаар заасан тул Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба гэм хорыг арилгах үүрэгтэй байна.

Шүүх нэхэмжлэлийн шаардлагаас эмчилгээний зардал 143,900 төгрөг, хиймэл хөл хийлгэх зардал 950,000 төгрөг, Улаанбаатар хотод эмнэлэгт үзүүлэх болон сэтгэцийн шинжилгээ хийлгэхэд гарсан унааны зардал 186,700 төгрөгийн нэхэмжлэлийг хангасан нь Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 505.1-д заасантай нийцсэн байна. Харин олох байсан орлогыг хуульд нийцүүлэн дүгнэж чадаагүйг зөвтгөх боломжтой гэж үзэв. Хэрэгт байгаа баримтаар нэхэмжлэгчийн зайлшгүй олох байсан орлогыг тодорхойлох боломжтой байна.

Нэхэмжлэгч нь олох байсан орлогоо осол гарахаас өмнө “Хүннүгийн говь” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд үндэслэжээ. Уг гэрээний дагуу Б.Батжаргал нь өрлөг дотор заслын ажлыг гүйцэтгэх, ажлын хөлс нь 50,021,500 төгрөг байхаар тохирсон байх ба үүнээс 10,000,000 төгрөгийг ажил гүйцэтгэж хөлсөө авсан, харин осолд орсны улмаас ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсноор олох байсан

орлогоор хохирчээ.

Иргэний хуульд зааснаар гэм хор гэх ойлголтод иргэний субъектив эрх буюу баялгийг багасгасан, устгасан бүхий л хор уршиг хамаарах ба зайлшгүй олох байсан орлого үүнд хамаарна.

Шүүх хуралдаанд “Хүннүгийн говь” ХХК-ийн гүйцэтгэх захирал В гэрчээр мэдүүлэг өгөхдөө нэхэмжлэгчийг дөрвүүлээ ажил гүйцэтгэж байсан, ажлын хөлсийг Б-д шилжүүлж, Б нь ажилчдадаа хөлсийг нь өгдөг байсан талаар мэдүүлжээ. Нэхэмжлэгч нь шүүх хуралдаан дээр 3 ажилчинд сар бүр 500,000-1,000,000 төгрөгийг хийснээр нь өгдөг байсан гэж тайлбар гаргасан ба 1 хүнд дунджаар сард 750,000 төгрөгийн хөлс, гэрээний 9 сарын хугацаанд 3 хүнд 20,250,000 төгрөгийн хөлс буюу зардал гарахаар байх тул нийт орлого 40,021,500 төгрөгөөс хасвал нэхэмжлэгч нь 19,771,500 төгрөгийн орлогыг өөртөө олох байсан байна. Иймд олох байсан орлого 19,771,500 төгрөгийн нэхэмжлэлийг хангах үндэслэлтэй гэж үзнэ.

Шүүхийн шийтгэх тогтоолд гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд нэхэмжлэгч Б-н буруутай үйлдэл нөлөөлсөн үйл баримт тогтоогдоогүй байхад шүүх хэрэглэх ёсгүй хуулийг буюу Иргэний хуулийн 514 дүгээр зүйлийн 514.1 дэх хэсгийг хэрэглэсэн нь буруу байв. Нэхэмжлэгч нь мотоциклын ард явахдаа зориулалтын малгай өмсөөгүй боловч үүний улмаас гэм хорын хэмжээ нэмэгдсэн гэх байдал баримтаар тогтоогдоогүй байна.

Иймд “нэхэмжлэгчийн олох байсан орлого нотлогдоогүй” гэсэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгуулахыг хүссэн хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулахаар шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэжээ.

Хэрэг №5. 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00076 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “Монгол такси групп” ХХК-ийн Верна маркийн автомашиныг 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Я хот доторх такси үйлчилгээнд явах автомашин түрээслүүлэх гэрээ байгуулан автомашиныг 12,000,000 төгрөгөөр үнэлж ажлын 600 хоногоор

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

байгуулан, ажлын өдрийн 20,000 төгрөгийн орлого өгөхөөр хот доторх такси үйлчилгээнд явах автомашин түрээслүүлэх гэрээ байгуулсан. 2015 оны 9 дүгээр сарын 12-ны шөнө 03 цагийн орчимд А нь О-ийн эзэмшлийн Тоёота Марино маркийн автомашиныг тус зогсоолын манаач Д-тэй архи уун, согтуугаар жолоодож Сүхбаатар дүүрэг 13 дугаар хорооны нутаг дэвсгэр, 17 дугаар сургуулийн зүүн замд Я-гийн жолоодож явсан тээврийн хэрэгслийг мөргөж зам тээврийн осол гаргаж, жолооч Я-гийн эрүүл мэндэд хохирол учруулсан. “Монгол такси групп” ХХК-д ослын улмаас автомашинд “Хөрөнгө Эстимэйт” ХХК-ийн авто машин техник эвдрэл, хохирлын үнэлгээгээр 1,928,000 төгрөг, мөн автомашины кузов худалдан авахад 3,000,000 төгрөг нийт 4,928,000 төгрөгийн хохирол гарсан тул тухайн хохирлыг хариуцагчаас гаргуулахаар шаарджээ.

Нэхэмжлэгч Я нь зам тээврийн осол болохоос өмнө гэрээний дагуу өдрийн 20,000-25,000 төгрөгөөр тооцон сард 420,000-575,000 төгрөг төлж нийтдээ 7,941,000 төгрөгийг төлсөн, тухайн үед 3,959,000 төгрөгийг төлсөн тохиолдолд машинаа хувьдаа авахаар байсан. “Монгол такси групп” ХХК-д өдөрт дунджаар 30,000-50,000 төгрөгийг төлж байжээ. Иймд олох ёстой байсан орлогоо өдрийн 25,000 төгрөгөөр тооцон тодорхойлж, хэрэг гарсан өдөр буюу 2015 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс “Топ цонх” ХХК-д жолоочоор 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр ажилд орох хүртэлх хугацаанд машины эвдрэлийг засаж чадаагүй улмаас орлого олж чадаагүйг тооцвол 680 ажлын өдрийг 25,000 төгрөгөөр бодож, нийт 17,000,000 төгрөг олохоор байсан. Хэдий хуульд заасан боломжийн хүрээнд бид нэхэмжлэлийн шаардлагаа 17,000,000 төгрөгөөр тодорхойлж болох боловч өөрт олгогдсон эрхийн хүрээнд түүнээс энэ гацаанд олох орлогоос зөвхөн 3,000,000 төгрөг, эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхэд төлсөн 160,000 төгрөг, нотариатын зардал 5000 төгрөг, нийт 3,165,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулах хүсэлтэй байна гэжээ.

Хариуцагч О нь 2015 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр автомашины зогсоолд өөрийн эзэмшлийн автомашинаа тавьсан бөгөөд өөр хүний автомашин гарах боломжийг хааж тавьсан байсан учраас уг компанийн манаач болох Д-д автомашиныхаа түлхүүрийг үлдээгээд зогсоолд тавьсан автомашин гарах шаардлагатай бол автомашиныг нь хөдөлгөөд

гаргачхаад буцаагаад зогсоолд тавиарай гэж хэлж л түлхүүрээ орхисон. Тус компанийн манаач ажилтай Д нь 2015 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр миний автомашиныг дур мэдэн, миний зөвшөөрөлгүйгээр А гэдэг хүнд зөвшөөрөл олгож, жолоодуулан явж байгаад осол гаргасан. Д-д зогсоолд тавьсан автомашин гарвал машиныг хөдөлгөөд буцаагаад зогсоолд тавиарай гэсэн болохоос биш Д-д өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг шилжүүлсэн зүйл огт байхгүй. Дээрх түрээсийн гэрээний дагуу зогсоолд тавьсан автомашиныг тус компанийн манаач Д нь ажлын хариуцлага алдаж, дур мэдэн зөвшөөрөлгүйгээр А гэдэг хүнд тээврийн хэрэгслийг ашиглуулснаас болж бусдад хохирол учруулсан. Нэхэмжлэлд дурдсан бусдад учруулсан хохирол нь миний буруугаас болоогүй учраас энэ хохирлыг хариуцахгүй, харин дур мэдэн зөвшөөрөлгүйгээр бусдад хүний эзэмшлийн автомашин жолоодох эрх олгосон Д, тухайн үед автомашин жолоодож явсан А нар бүрэн хариуцах ёстой. А гэдэг хүнийг огт танихгүй ба энэ хүнд өөрийн эзэмшлийн автомашиныхаа түлхүүрийг өгөөгүй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй тул хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 101/ШШ2018/02152 дугаар шийдвэрээр Иргэний лийн 499 дүгээр зүйлийн 499.3, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх эсэгт заасныг баримтлан хариуцагч О-аас 4,928,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч “Монгол такси групп” ХХК-д 3,165,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч Я д тус тус олгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1868 дугаар магадлалаар Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 101/ШШ2018/02152 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

4. Хариуцагч О-ийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Би тус компанийн манаач Д-д өөрийн эзэмшлийн автомашиныг зөвхөн тус компанийн гараашны хашаан дотор хөдөлгөх тодорхой,

хязгаарласан үйлдэл хийх зөвшөөрөл л олгосон.

Тэрнээс биш миний эзэмшлийн автомашиныг өөр хүнд зөвшөөрөл олгож жолоодуулан тус компанийн хашаанаас гаргаж явах зөвшөөрлийг огт өгөөгүй. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй гэж заасан.

Гэтэл шүүх хуулийн уг зохицуулалтын дагуу гэм хорыг арилгуулах асуудлыг шийдвэрлэхдээ нэхэмжлэгч талд гэм хор учруулсан хариуцагчийн хууль бус үйлдэл, гэм буруу, гэм хор болон буруутай үйлдэл, эс үйлдэхүйн хоорондох шалтгаант холбоог нарийвчлан тогтоолгүй зөвхөн автомашин эзэмшигч л хохирлыг бүрэн барагдуулах ёстой гэж үзсэнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд шүүх тухайн харилцаанаас үүссэн эрх зүйн маргааныг хууль зүйн үндэслэлтэй хянан шийдвэрлэсэн гэж үзэхгүй байна.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын татгалзлаа нотолж шүүхэд ирүүлсэн хүсэлт, баримтаар хариуцагчийн тээврийн хэрэгслийг А, Д нар ашиглах боломж бүрдээгүй байсан, ашиглахаас сэргийлэх бололцоо байгаагүй гэдгээ нотолж чадаагүй тул тэрээр өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслээ бусдад ашиглуулах боломж олгосны улмаас нэхэмжлэгч нарт учруулсан хохирлын хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй.

Хариуцагч О нь бусдад автомашины түлхүүрээ үлдээснээс зам тээврийн осол гарах боломжийг бүрдүүлсэн, тээврийн хэрэгслийг ашиглуулах боломж олгосон учраас тээврийн хэрэгслийг өмчлөгчийн хувьд нэхэмжлэгч нарт учирсан хохирлыг О хариуцах үүрэгтэй гэж дүгнэн, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт нийцжээ.

Хэрэг №6. 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/00783 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

“М” ХХК-ийн нэхэмжлэлтэй “И” ХХК-д холбогдох гэм хорын хохиролд 3,523,735 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

“М” ХХК-ийн эзэмшлийн “Хино Рэнжир” маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сийрст багийн Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн нүүрс тээврийн засмал замын 25 дахь километрт тус компанийн ажилтан жолоодож, инженер зорчигчийн суудалд сууж явах үед Нордбенз маркийн “И” ХХК-ийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл мөргөж, зам тээврийн осол гаргасан. Компанийн өмч “Хино Рэнжир” маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд 11,808,000 төгрөгийн бодит хохирол учирсан бөгөөд уг хохирлыг даатгалын байгууллагаас гаргуулж шийдвэрлэсэн.

Бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг даатгалын байгууллага хариуцахгүй гэсэн учир компани өөрийн ажилтан нарын эрүүл мэндэд учирсан хохирол төлбөр, өвчтэй байсан хугацааны цалин хөлсийг бүхэлд нь хариуцан 3,523,735 төгрөгийн зардал гаргаж хохирлыг барагдуулсан. Үүнд: Э-гийн эмчилгээ, шинжилгээнд 1,456,272 төгрөг, П-ийн эмчилгээ, шинжилгээнд 1,696,093 төгрөг, Э-ийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байх үеийн 5 хоногийн цалин 175,625 төгрөг, П-ийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байх үеийн 5 хоногийн цалин 195,745 төгрөг, нийт 3,523,735 төгрөгийн хохирлын төлбөрийг гаргуулахаар шаарджээ.

Хариуцагч “И” ХХК нь хүний биед гэмтэл учраагүй гэх үндэслэлээр Өмнөговь аймгийн сум дундын прокурорын газрын 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 5/124 тоот тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан. Гэтэл нэхэмжлэгч компанийн 2 ажилтан ослын улмаас тархи доргисон оноштойгоор эмнэлэгт хэвтэж, шинжилгээ хийлгэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна. “Монгол Хьюндай” эмнэлгээс хуурамч байж болох баримтыг шүүхэд ирүүлж, уг баримтад үндэслэн нэхэмжлэгч мөнгө нэхэмжилж байгааг зөвшөөрөхгүй. Тархи доргиход 5 хоног хэвтэж эмчлүүлэх шаардлагагүй учраас хараагүйчүүдийн төвд очиж бариулахад л хангалттай байсан. Манай компани 2 ажилтны 5 хоногийн цалин 371,100 төгрөг, мөн тархи бариулахад ямар зардал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

гардаг түүнийг нь төлөхөөс татгалзахгүй, харин үнэтэй шинжилгээ, эмчилгээнийх нь мөнгийг төлөхгүй гэжээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 181/ШШ2017/02840 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.4, 513 дугаар зүйлийн 513.1, 513.2 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан “И” ХХК-иас 3,053,735 төгрөгийг гаргуулж “М” ХХК-д олгож, нэхэмжлэлээс 470,000 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 245 дугаар магадлалаар Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 181/ШШ2017/02840 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч “М” ХХК-ийн хариуцагч “И” ХХК-с гэм хорын хохиролд 3,523,735 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

4. Нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 513.1-ийг үндэслэн хариуцагчаас төлбөр гаргуулсныг буруутгасан ба үйлдвэрлэлийн осол байсан бол зохих ёсоор нэхэмжлэх эрхтэй, Э, П нарын эрүүл мэндэд гэм хор учирсны нөхөн төлбөр төлсөн үндэслэл тодорхой бус гэж дүгнэснийг зөвшөөрөхгүй байна. Ажилтнууд осолд орж хөдөө эмнэлэгт 1 хонож Улаанбаатарт ирсэн. Яаралтай эмчилгээ шаардлагатай байсан болохоор байгууллага нь туслахаас аргагүй байсан гэдгийг шүүх анхаарч үзэхгүй байна. “И” ХХК мөнгө төлөхийг хүлээж осолд орсон өвчтөнөө ажлаа хийхийг шаардаад суух боломжгүй байсан гэдгийг анхаарч үзэхгүй байгаад гомдолтой байна.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Давж заалдах шатны шүүх “...Иргэний хуулийн 513.1 дэх хэсэгт зааснаар хохирлыг нийгмийн даатгал, нийгмийн хангамж болон эдгээр байгууллагатай адилтгаж болох хуулийн этгээд шаардах эрхтэй...” гэсэн үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Иргэний хуулийн 513 дугаар зүйлийн 513.1 дэх хэсэгт “...Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн буюу бусад хуулийн этгээд нь гэм буруутай иргэн болон хуулийн этгээдээс төлбөр, тусламжаа буцаан нэхэмжлэх эрхтэй...” гэж заасан байх бөгөөд уг хэсэгт заасан “...бусад хуулийн этгээд...” гэдэгт нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн байгууллагатай адилтгах чиг үүрэгтэй байгууллага хамаарах агуулга уг зүйлд байхгүй байна.

Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн буюу бусад хуулийн этгээд нь гэм буруутай иргэн болон хуулийн этгээдээс төлбөр, тусламжаа буцаан нэхэмжлэх эрхтэй байна. Давж заалдах шатны шүүх шийдвэрт өөрчлөлт оруулахдаа хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байх тул энэ үндэслэлээр магадлалыг хүчингүй болгов.

Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд тээврийн хэрэгслийн ашиглалтаас болж ийнхүү гэм хор учруулсан тохиолдолд жолоочийг өөрөө томилсон тээврийн хэрэгсэл өмчлөгч гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн хуулийн этгээд нь гэм буруутай иргэн болон хуулийн этгээдээс төлсөн төлбөрийг буцаан шаардах нь Иргэний хуулийн 199 болон 513 дугаар зүйлүүдийг зөрчихгүй юм.

Хэрэг №7. 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр, Дугаар: 001/ХТ2017/01131 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Д-н нэхэмжлэлтэй Б-д холбогдох гэм хорын хохиролд 9,197,100 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

Д нь Б-тэй 2012 онд танилцаж, 2013 оны 6 дугаар сараас 2014 оны 8 дугаар сар хүртэл хамт амьдарсан. Хариуцагч 2013 оны 04 дүгээр сард нэхэмжлэгчийн өмчлөлийн “Приус-20” маркийн 97-50 УНА улсын дугаартай автомашиныг жолоодож явахдаа Төв аймгийн Баянчандмань сумын 52-ын даваан дээр замын хажуу руу онхолдож осол гаргасан. Хариуцагчийн буруутай үйлдэл нь Замын цагдаагийн газраас хийсэн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

тэмдэглэл, шинжээчийн дүгнэлтээр тогтоогддог. Автомашины хохиролд үнэлгээ хийлгэхэд 11,915,000 төгрөгийн хохирол учруулсан болох нь тогтоогдсон. Даатгалаас 7,460,000 төгрөг авсан. Д нь машинаа 13,000,000 төгрөгөөр худалдаж аваад 1 жил болоогүй байжээ. Машиныг анх авсан үнэтэй бараг адил хэмжээний хохирол учирсан бөгөөд машиныг засаж, сэлбэх ямар ч боломжгүй болсон. Хариуцагчийн хамт машинд сууж явсан хүмүүс хөнгөн болон хүнд гэмтэж, Б өөрөө хүндэвтэр гэмтсэн байна. Д нь 2015 оны 8 дугаар сард 2,800,000 төгрөгөөр машинаа худалдсан.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2016 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 102/ШШ2016/02811 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, 281 дүгээр зүйлийн 281.1 дэх заалтыг баримтлан хариуцагч Б-ээс 2,745,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Д-д олгож, шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 1478 дугаар магадлалаар Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 102/ШШ2016/02811 дүгээр шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 ...” гэсний дараа “499 дүгээр зүйлийн 499.1” гэж нэмж, ” ...2,745,000 төгрөг ...” гэснийг “1,865,000 төгрөг” гэж , ” ... 19,126,150 төгрөгийг ...” гэснийг “7,332,100 төгрөгт холбогдох хэсгийг” гэж, 2 дахь заалтын ” ... 58.87 төгрөг ...” гэснийг “44,790 төгрөг” гэж тус тус өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан байсан “Мега марз” ХХК-ийн үнэлгээг үндэслэлгүй гэж, харин даатгалын компанийн санал болгосон үнэлгээг үндэслэлтэй гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нь үндэслэлгүй юм. Учир нь “Номин даатгал” ХХК-ийн барьсан үнэлгээ нь автомашины эвдрэлийн үнэлгээнд огт нийцэхгүй бөгөөд даатгал

нь аль болох бага үнэлгээг барьж даатгалын төлбөрийг гаргуулдаг болно. “Мега марз” ХХК-ийн гаргасан үнэлгээ нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан үнэлгээ бөгөөд осол гарах үед хийсэн бодит үнэлгээ болно. Гэтэл давж заалдах шатны шүүх нь хуулийг буруу тайлбарлаж, нотлох баримтыг хууль ёсны талаас нь үнэлэхгүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнд гомдолтой байна. Гэм буруутай этгээд нь өөрийн үйлдлийн улмаас бусдад учирсан хохирлыг арилгах нь хуульд нийцэх асуудал бөгөөд хариуцагч Б нь нэхэмжлэгч Д-ийн автомашинд 11,915,000 төгрөгийн хохирол учруулсан болохыг тогтоосон байдаг. Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 1478 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд хариуцагч Б нь нэхэмжлэгч Д-н эзэмшлийн “Тоёото приус” маркийн автомашиныг Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт жолоодон явахдаа зам тээврийн осол гаргасан болох нь эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол, хэргийн газарт үзлэг хийсэн тэмдэглэл зэргээр тогтоогдож байна.

Хариуцагч Б-д холбогдох эрүүгийн хэргийг шалгах явцад автомашинд учирсан хохирлын үнэлгээг “Мега Марз” ХХК нь 11,915,000 төгрөгөөр тогтоосон боловч “Номин даатгал” ХХК нь “Итгэлт эстимэйт” ХХК-ийн үнэлсэн 9,325,000 төгрөгөөс тооцож даатгалын нөхөн төлбөрт 7,460,000 төгрөгийг нэхэмжлэгч Д-д олгосон байна.

Нэхэмжлэгч Д нь хариуцагч Б-ээс мөнгөн хохирол гэх 3,850,000 төгрөгийг “зээл” гэж тодорхойлж, харин 642,000 төгрөгийг хариуцагчийн гаргасан ослын улмаас хариуцагч болон зорчигчийн эмчилгээний зардалд зарцуулсан гэсэн бол машины хохирол гэсэн 4,705,000 төгрөгийг даатгалын компаниас олгосон тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийг хасаж тооцон нийт 9,197,100 төгрөгийг нэхэмжилсэн байна.

Анхан шатны шүүх нэхэмжлэгч Д-г эмчилгээний төлбөрт 642,100 төгрөг төлсөн, 3,850,000 төгрөгийг зээлдүүлсэн шаардлагаа баримтаар нотлоогүй, тэрээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зааснаар мэтгэлцээгүй байх тул шүүх дээрх шаардлагуудыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болсон талаар давж заалдах шатны шүүхийн хийсэн дүгнэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3-т нийцсэн гэж үзнэ.

Харин хариуцагч Б нь “Мега Марз” ХХК-иас гаргасан үнэлгээг эс зөвшөөрч маргасан байхад уг үнэлгээнд талууд маргаагүй гэж анхан шатны шүүх үндэслэлгүй дүгнэлт хийж, хохирлыг энэ үнэлгээгээр тооцож, хариуцагчаас 2,745,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2-т заасантай нийцээгүй байна.

Иймээс “Номин даатгал” ХХК нь автомашинд учирсан хохирлын үнэлгээг “Итгэлт эстимэйт” ХХК-иас гаргасан үнэлгээ болох 9,325,000 төгрөгөөс тооцож даатгалын нөхөн төлбөр олгосон байх тул зөрүү 1,865,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгох нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэх тул анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4-т заасан үүргээ зөрчөөгүй гэж үзнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2-т заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул зохигчдын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Хэрэг №8. 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, Дугаар: 001/ХТ2019/00341 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Б-ийн нэхэмжлэлтэй, М-д холбогдох тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн хохирлын үнэ болох 5,175,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

Б-ийн “Toyota crown” маркийн машиныг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Өлгий сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт хариуцагч

М нь “Toyota Harrier” маркийн машиныг жолоодож явахдаа мөргөж зам тээврийн осол гарчээ. Ослыг аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн албаны а/х Б.М шалгаж М-ын буруутай үйл ажиллагаанаас болж осол гарсан гэж тогтоосон. Тус аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 95 дугаартай захирамжаар Аймгийн Цагдаагийн газраас М-д 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 000102 дугаартай шийтгэвэрээр 100,000 төгрөгөөр торгожээ. Дээрх зөрчлийн улмаас нэхэмжлэгчийн тээврийн хэрэгсэлд 4,075,000 төгрөгийн хохирол учирсан нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 130/ШШ2018/00573 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1-д заасныг тус тус баримтлан хариуцагч М-ээс баруун урьд далавч крыло буюу 115,000 төгрөг, урд салхины шил буюу 200,000 төгрөг, зүүн урд аэробак буюу 450,000 төгрөг, капот буюу 250,000 төгрөг, усны радиатор буюу 230,000 төгрөг, тосны радиатор буюу 180,000 төгрөг, баруун талын их гэрэл буюу 180,000 төгрөг, зүүн талын их гэрэл буюу 180,000 төгрөг, урд буфер буюу 250,000 төгрөг, урд нүүр буюу 230,000 төгрөг, крыло засах, бүтэн будах буюу 80,000 төгрөг, зүүн урд хамгаалагчийг засах будах буюу 80,000 төгрөг, зүүн хойд далавч засах, бүтэн будах буюу 100,000 төгрөг, рамны зүүн урд үзүүр мушгирч урагдсаныг засах буюу 50,000 төгрөг, мотор дуу чимээ орсныг засварлах буюу 1,000,000 төгрөг, баталгаат засварын газрын ажлын хөлс буюу 500,000 төгрөг бүгд 4,075,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч Б-д олгож, нэхэмжлэгчийн илүү нэхэмжилсэн 1,100,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дүгээр зүйлийн 7.1.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, 60 дугаар зүйлийн 60.1-д зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 129,030 төгрөгийг улсын орлого болгож, хариуцагч М-аас 80,150 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Б-д олгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 212/МА2018/00116

дугаар магадлалаар Баян-Өлгий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 130/ШШ2018/00573 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

4. Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Анхан болон давж заалдах шатны шүүх нэг талыг баримталж шийдвэр гаргасан. Шинжилгээний байгууллагын шинжээч нь мөргөсөн машины эд ангид дүгнэлт гаргахад зах зээлийн үнээс хэт өндөр үнээр үнэлж дүгнэлт гаргасан. Мөн Toyota crown 171 маркийн хуучин машины үнэ зах зээлийн өнөөгийн байдлаар 3-5 сая төгрөг байхад анхан шатны шүүх машины үнийн дүгнэлт гаргуулахгүйгээр шийдвэр гаргасан ба уг шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр баталсан.

Давж заалдах шатны шүүх хэрэглэх ёстой журмыг хэрэглээгүй, анхан шатны шийдвэрийг хэвээр нь шийдвэрлэсэнд гомдолтой байна. Давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэн зөв үнэлж дүгнэж шийдвэр гаргаагүй. Анхан шатны шүүхэд мөргөсөн машины эвдэрсэн эд ангид дахин шинжилгээ хийлгэхээр хүсэлт гаргахад хүсэлтийг хангаж шийдвэрлээгүй. Хүсэлтийг шүүх хуралдааны аль ч үед гаргах эрхтэй юм. Хариуцагч миний эрхийг ноцтой зөрчсөнд гомдолтой тул иргэний хэргийг тал бүрээс нь бодитой дүгнэж шийдвэр гаргах нь зүйтэй байна. Иймд давж заалдах шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн. Хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэж хяналтын журмаар гомдол гаргаж байна гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Анхан шатны шүүх уг хохирлыг хариуцагч М-ээс гаргуулж Б-д олгохоор шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1-т заасан зохицуулалтыг хэрэглэсэн нь хуульд нийцжээ.

Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулж, зохигчдын хооронд үүссэн маргаанд Иргэний хуулийн зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалтыг зөв хэрэглэсэн байх тул шийдвэрийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4-т заасан үүргээ хуульд зааснаар хэрэгжүүлсэн гэж үзнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар хариуцагч нь нэхэмжлэлийг үгүйсгэж буй үндэслэлээ өөрөө нотлох, нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй боловч энэ үүргээ хуульд заасан журмаар хэрэгжүүлээгүй байх тул нэхэмжлэгчийн тээврийн хэрэгслийн эд ангийг зах зээлийн ханшнаас хэт өндөр үнэлснийг шүүх анхаараагүй, нотлох баримтыг хуульд заасан журмаар үнэлээгүй гэсэн хариуцагчийн гомдлыг хангаагүй орхисон давж заалдах шатны шүүхийг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна.

Хэрэг №9. 2018 оны 6 дугаар сарын 17-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/00995 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

Г-ийн нэхэмжлэлтэй Э, Б нарт холбогдох гэм хорын хохирол 5,810,000 төгрөг гаргуулах үндсэн нэхэмжлэлтэй, гэм хорын хохирол 2,305,600 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэрэг

2017 оны 2 дугаар сарын 17-ны орой 21 цагийн үед Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар багийн нутагт Г-ийн жолоодож явсан Приус-20 маркийн авто машин Б-ийн эзэмшлийн зам дээр зогсож байсан Хено FR-2 маркийн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн зам тээврийн осол гарч, ослын улмаас Г-д 5,810,000 төгрөгийн, Б-д 2,305,600 төгрөгийн хохирол учирсан үйл баримт тогтоогджээ.

Шинжээчийн дүгнэлтээр нэхэмжлэгч Г нь Замын хөдөлгөөний дүрмийн 9.2-т заасан “...жолооч хөдөлгөөнд аюул саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна” гэсэн заалтыг зөрчсөн, хариуцагч Б Замын хөдөлгөөний дүрмийн 6.2-ын “в”-д заасан “харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт оврын гэрэл нь асахгүй (эсвэл байхгүй) тээврийн хэрэгслийг зогсоосон үед, “е”-д заасан “тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй бусад тохиолдолд ослын дохионы гэрлийг хэрэглэнэ” гэсэн заалтыг, мөн 6.3-т заасан “ослын зогсолтын тэмдгийг хэрэглэх” заалтыг, 7.17-д заасан “бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй газарт, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд ухрах үйлдлийг хийхийг зөвшөөрнө” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэжээ.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хариуцагч Э шүүхэд гаргасан хариу тайлбартаа: Хено FR-2 маркийн тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Э-ийн нэр дээр байгаа боловч тухайн тээврийн хэрэгсэл Б-ийн өмчлөлд байдаг. Түүний ах Т машиныг худалдан аваад Б ачаа ачиж явсан. Тиймээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэжээ.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 566 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар хариуцагч Б-ээс 4,596,800 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Г-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 1,213,200 төгрөгийг хэрэгсэхгүй болгож, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул хариуцагч Э-д холбогдуулан гаргасан нэхэмжлэл, нэхэмжлэгч Г-ээс 2,305,600 төгрөг гаргуулах тухай хариуцагч Б-ийн сөрөг нэхэмжлэлийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 03 дугаар магадлалаар хариуцагч Б-ийн давж заалдсан гомдлыг хангахгүй орхиж, Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 566 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн дугаар 03 магадлалын хяналтын хэсэгт Б нь Замын хөдөлгөөний дүрмийн 6.2-т "... ослын дохионы гэрэл хэрэглэх", 7.17 "...бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй газарт, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд ухрах үйлдэл хийхийг зөвшөөрнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн болох нь тогтоогдсон гэж үзсэн.

Б нь машины мотор эвдэрсэн учир замаа боломжит бүх байдлыг хангаж хамгийн боломжит түр зогсолтыг үйлдсэн байдаг. Тус зогсолтыг үйлдсэний дараа Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 6.2-т заасны дагуу ослын зогсолтын тэмдгийг байрлуулсан бөгөөд давхар

ослын дохионы гэрлийг асаасан боловч аккумулятор суусан бөгөөд үргэлжлүүлж асах боломжгүй болсон.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Хариуцагч Э-д холбогдох нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэгдсэн байна.

Осол гарахад нэхэмжлэгчийн буруутай үйлдэл зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагаас 20 хувийг хасаж тооцохдоо хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй байх тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд энэ үндэслэлээр хууль хэрэглээний өөрчлөлт оруулж шийдвэрлэх нь зүйтэй.

Хариуцагчийн буруутай үйлдлийн улмаас зам тээврийн осол гарсан тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй гэж дүгнэн, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт хууль зөрчөөгүй тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгохыг хүссэн хариуцагчийн өмгөөлөгчийн гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзлээ.

Хэрэг №10. 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр, Дугаар: 001/ХТ2018/01042 УДШ-ийн тогтоол

1. Хэргийн товч агуулга:

С-ийн нэхэмжлэлтэй, У-т холбогдох, 1,380,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг

Хариуцагч У нь Тоёота спринтер маркийн, Б нь С-ийн өмчлөлийн Хьюндай Верна маркийн авто машиныг тус тус жолоодон явахдаа 2017 оны 6 дугаар сарын 18-ны 00 цаг 15 минутын үед Баянзүрх дүүргийн нутаг Дарь-Эх уулзварт хоорондоо мөргөлдөж зам тээврийн осол гаргажээ.

Зохигчид энэхүү үйл баримтын талаар маргаагүй ба хариуцагч нэхэмжлэлээс татгалзахдаа “...Б хурд хэтрүүлснээс осол гаргасан буруутай” гэсэн тайлбар гаргажээ.

Хэрэгт авагдсан шинжээчийн дүгнэлтээр хариуцагч Замын хөдөлгөөний дүрмийн 12.7-т заасан “зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч нь уулзвар нэвтрэх үйлдлээ дуусгаж байгаа тээврийн хэрэгсэлд

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зам тавьж өгнө” гэсэн заалтыг зөрчсөнөөс осол гаргасан болох нь тогтоогджээ. Түүнчлэн уг дүгнэлтэд “...Верна маркийн тээврийн хэрэгслийн тоормосны мөрөөр хурдыг тодорхойлоход 82.68 км/цагийн хурдтай явж байсан нь Замын хөдөлгөөний дүрмийн 9.3 дахь заалтыг зөрчсөн байх үндэслэлтэй” талаар дурджээ.

Дээрх ослын улмаас Хьюндай Верна маркийн машинд 1,160,000 төгрөгийн хохирол учирсан ба нэхэмжлэгч оношилгооны төлбөр 31,000 төгрөг, үнэлгээний хөлс 59,000 төгрөг, уг тээврийн хэрэгслийн ачилтын зардал 130,000 төгрөг нэхэмжилсэн, хариуцагч үгүйсгэж чадаагүй байна.

2. Анхан шатны шүүхийн шийдвэр:

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 181/ШШ2018/00055 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.3, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1-д заасныг тус тус баримтлан хариуцагч У-ээс 690,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч С-д олгож, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсэг буюу 690,000 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 575 дугаар магадлалаар Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 181/ШШ2018/00055 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтаас “499 дүгээр зүйлийн 499.3”, “514 дүгээр зүйлийн 514.1-д” гэснийг хасаж, “690.000” гэснийг “1.380.000” гэж өөрчлөн, тогтоох хэсгийн 2 дахь заалтын “21.110” гэснийг “37.030” гэж тус тус өөрчлөн шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдол:

Хариуцагч У хяналтын журмаар гаргасан гомдолдоо: нэхэмжилж байгаа үнийн дүн зах зээлийн ханштай нийцэхгүй байна. Уг үнэлгээний төлбөрийг үнэн эсэхийг шалгаж тодруулж өгөхийг хүсэж байна. Миний машины жолоочийн эсрэг их гэрэл, гупер, зүүн крыло руу мөргөснөөс болж хаалга онгойхгүй болсон, хөмсөг мөн усны сав хагарч эвдэрсэн гэмтлүүд гарсны улмаас би “Вендо” ХХК-аар хохирлын үнэлгээ хийлгэхэд 760.000 төгрөгийн төлбөр гарсан. “Түмэн кредит ББСБ” нэр дээр байсан 39-77 УНА улсын дугаартай “Toyota sprinter” маркийн

машины эзэмшигчийн зөвшөөрөлтэй байсан гэжээ.

5. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1-д зааснаар тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын эд юмс эвдэрч, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй, нэхэмжлэгч зам тээврийн ослын улмаас учирсан гэм хор нэхэмжилсэн нь хуулийн дээрх зохицуулалтад нийцжээ.

Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулж, хэрэгт авагдсан нотлох баримтын хэмжээнд нэхэмжлэлийн шаардлагын талаар дүгнэлт өгч, нэхэмжлэгчийн машиныг тухайн үед жолоодож явсан Б хурд хэтрүүлсэн нь хохирлын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж, хохирлын хэмжээг багасгахдаа хэрэглэвэл зохих Иргэний хуулийн 514 дүгээр зүйлийн 514.1 дэх заалтыг зөв тайлбарлан хэрэглэжээ.

Дээрх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ
ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ
ХУВААРИЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР, МАГАДЛАЛ, ТОГТООЛЫН
ШИНЖИЛГЭЭ

(Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ)

Г.Цагаанбаяр (LL.M)
Хуульч, судлаач

Ж.Алтансүх (LL.M)
Хуульч, судлаач

АГУУЛГА

УДИРТГАЛ	159
1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ТОЙМ СУДАЛГАА	165
1.1. Анхан шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	165
1.2. Давж заалдах шатны шүүхийн магадлалд хийсэн дүн шинжилгээ.....	167
1.3. Улсын дээд шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ	168
2. ТОДОРХОЙ НЭГ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	173
2.1. Шүүхийн шийдвэрин танилцуулга	173
2.2. Үйл баримтын агуулга	173
2.3. Шийдвэрлэгдсэн байдал	174
2.4. Шийдвэрээс урган гарч буй асуудал	176
2.5. Адил төстэй маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практик	177
2.6. Эрх зүйн онол, үзэл баримтлал	178
2.7. Япон Улсын шүүхийн практиктай харьцуулсан шинжилгээ	180
2.8. Шийдвэрт өгөх үнэлгээ	184
3. ДҮГНЭЛТ	186

УДИРТГАЛ

Судалгааны хүрээнд сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн талбай, эд хөрөнгийн засвар хамгаалалт, үйлчилгээний зардлыг хуваарилахтай холбоотой маргааныг шүүхээс хэрхэн шийдвэрлэж буй практикийг тоймлон шинжиллээ. Уг судалгаагаар Улсын дээд шүүхийн шийдвэрлэсэн жишиг болохуйц нэг тогтоолыг сонгон авч, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалын дагуу шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдлыг үнэлж дүгнэн дараах асуултуудад хариулт өгөхийг зорилоо. Үүнд:

- Орон сууц өмчлөгчийг хэрхэн тодорхойлох;
- Нийтийн зориулалттай орон сууцанд аж ахуй эрхэлж, бизнесийн үйл ажиллагаа явуулж буй этгээд орон сууц өмчлөгч мөн эсэхийг тодорхойлох;
- Нийтийн зориулалттай орон сууцанд аж ахуй эрхэлж, бизнесийн үйл ажиллагаа явуулж буй этгээд Сууц өмчлөгчдийн холбооны (цаашид СӨХ гэх) гишүүн болох эсэх;
- Хэрэв СӨХ-ийн гишүүн биш бол нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар хамгаалалт, үйлчилгээний зардлыг хэрхэн хариуцах зэрэг асуудлууд багтсан болно.

Өөрөөр хэлбэл, нийтийн зориулалттай орон байрны сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун болон цэвэр, бохир ус, ариутгал, хог хаягдал, цахилгаан, харуул хамгаалалт, цэвэрлэгээ, ашиглалтын төлбөр гэх мэт засвар үйлчилгээний зардал гарахтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолуудыг судалж, энэ төрлийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практикт (жишиг) дүн шинжилгээ хийлээ.

Судалгааны ажлын хүрээг сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн талбай, үүний дотор сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун болон цэвэр, бохир ус, ариутгал, хог хаягдал, цахилгаан, харуул хамгаалалт, цэвэрлэгээ зэрэг ашиглалтын төлбөртэй холбоотой шүүхийн шийдвэрүүдээр хязгаарлав. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 142-149 дүгээр зүйл, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал,

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

нийтийн зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар (цаашид “СӨХ”-ийн тухай хууль гэх) шийдвэрлэсэн шийдвэр, магадлал, тогтоолыг сонгож судаллаа. Судалгааны хүрээг хэт өргөжүүлэхгүйн тулд нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 онд шийдвэрлэсэн маргаан, давж заалдах шатны шүүхийн магадлал, мөн хүчин төгөлдөр болсон тогтоол, холбогдох шийдвэрүүдийг сонгож дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгаагаар СӨХ-ийн эзэмшлийн газартай холбоотой асуудлыг авч үзээгүй бөгөөд энэхүү маргаан нь Захиргааны эрх зүйн маргаанд хамаарахаар байгаа тул судалгааны ажлын хүрээг Иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдээр хязгаарласан болно.

СӨХ-ийн тухай хууль 2003 онд батлагдсан бөгөөд 2005, 2011, 2015 онуудад тус тус өөрчлөлт оржээ. 2005 оны өөрчлөлтөөр хуулийн 7 дугаар зүйлд гурван заалт нэмсэн бол 2011 болон 2015 оны өөрчлөлтүүдээр хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын заалтуудад өөрчлөлт орсон байна. Үүнээс үзвэл, СӨХ-ийн тухай хууль батлагдсанаас хойш уг хуульд агуулгын болон шинэчилсэн найруулгын хэмжээний өөрчлөлт хийгдээгүй, анх батлагдсан үзэл баримтлал хэвээр үйлчилж иржээ. Хууль анх батлагдаж байсан 2003 оноос хойш өнөөдрийг хүртэл нийтийн зориулалттай орон сууцны тоо эрс нэмэгдсэний зэрэгцээ орон сууцны суурийн болон доод давхарт аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтын талбайгүй, аль эсвэл нэг давхрыг засаж өөрчлөн дээрх зориулалтын болгоогүй орон сууц бараг байхгүй болсон билээ. Иймээс энэ асуудлыг цаашдаа нарийвчлан судлах, шинэ төрлийн харилцааг зохицуулах шаардлагатай байгаа нь илэрхий билээ.

Энэхүү судалгааг хийхдээ анхан, давах, хяналтын шатны шүүхийн тогтоол, магадлал, шийдвэрүүдийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэж, мөн холбогдох мэргэжлийн байгууллага, албан хаагчтай ярилцлага хийх замаар практикт тулгарч буй тулгамдсан асуудлын талаар мэдээлэл цуглууллаа. Түүнчлэн нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 онд шийдвэрлэсэн маргаан, давж заалдах шатны шүүхийн магадлал, мөн хүчин төгөлдөр болсон тогтоол, холбогдох шийдвэрүүд, хавтаст хэрэгтэй тусгайлан танилцах байдлаар анализ хийсэн болно.

Асуудлыг тодорхойлох нь

Судалгааны багийн зүгээс судлах объект, асуудлыг илүү тодорхой болгохыг зорьж “Орон сууцны зориулалттай барилгын үйлчилгээний талбай худалдаж авсан, аль эсвэл орон сууцны талбайг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхээр засаж тохижуулсан иргэн, аж ахуйн нэгж нь орон сууц өмчлөгч (СӨХ-ийн гишүүн) мөн эсэх” гэсэн асуудлыг дэвшүүлж ажиллав.

Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Орон сууц” гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг” хэлнэ. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай (цаашид СӨХ-ны тухай хууль гэх) хуулийн 4.1.2-т “Сууц өмчлөгч” гэж нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь сууцыг захиран зарцуулах эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж тус тус тодорхойлжээ. Үүнээс үзвэл, үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулахыг зорьж үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан, аль эсвэл засаж тохижуулсан иргэн аж, ахуйн нэгж нь орон “сууц өмчлөгч”, аль эсвэл “орон сууц” худалдан авсан гэх тодорхойлолтод хамаарахааргүй байна. Энэ нь тухайн үйл ажиллагаа эрхлэгч этгээд Сууц өмчлөгчдийн холбооны гишүүн болох уу, аль эсвэл Иргэний хууль болон СӨХ-ны тухай хуульд заасан дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, арчлан хамгаалалтын зардлыг төлөх ёстой эсэх зэрэг эрх зүйн үр дагавар үүсгэж байгаа болох нь харагдаж байна.

Үйлчилгээний талбай өмчлөгч нь менежментийн (ашиглалтын) зардал төлөх үүрэгтэй болохыг дэмжсэн тайлбарыг доор харуулав. Үүнд:

1. Орон сууцны тухай хуулиар ноогдуулсан үүргийг тайлбарлах нь
Орон сууцны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар баригдсан хэсэгт болон сууцандаа бусад оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д зааснаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж болно” гэж тусгажээ. Үүний дагуу тухайн орон сууцны суурийн давхрууд нь үйлчилгээний зориулалттай талбай бол түүнээс дээших давхар нь нийтийн зориулалттай орон сууцанд хамаарахаар байна. Мөн хуулийн

16 дугаар зүйлийн 16.5-д “Нийтийн зориулалттай орон сууцны байшинд энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дундын өмчлөлийн эд хөрөнгөд засвар, үйлчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заажээ. Үүнээс дүгнэж үзвэл, үйлчилгээний зориулалттай талбайг өмчилж буй иргэн аж, ахуйн нэгжид дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ хийх, түүнд гарч буй зардал мөнгийг хариуцах, засвар үйлчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээлгэснийг харж болно. Өөрөөр хэлбэл, дээрх заалтыг баримтлан үйлчилгээний талбай өмчлөгчдөд дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн зардлыг ноогдуулж болох юм.

2. Эрүүл ахуйн тухай болон Хог хаягдлын тухай хуулиудыг тайлбарлах нь

Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3-т зааснаар “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх” үүрэгтэй. Хог хаягдлын тухай хуулийн 10.2-т хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг зааж өгсөн ба хуулийн 10.2.1-д “энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах, энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх”, мөн хуулийн 10.2.3-т “аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах”, 10.2.4-т “хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх” гэж заасны дагуу орчны эрүүл ахуйн болон хог хаягдлын менежментийн ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэж байгаа учраас үүнээс үүдэн гарч буй зардлыг үйлчилгээний талбай өмчлөгч нараас нэхэн гаргуулах үндэслэлтэй.

3. Хуулийг төсөөтэй хэрэглэх замаар тайлбарлах нь

Доод давхартаа үйлчилгээний төв бүхий барилга нь нийтдээ Орон сууцны тухай хуулийн дагуу орон сууцны байшин байх бөгөөд СӨХ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “Орон сууцны байшингийн дундын

өмчлөлийн эд хөрөнгө, дэвсгэр болон орчны газрыг тодорхойлж өгсөн”.

Үүнд, орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд “орон сууцны байшингийн гадна хана, даацын хана, багана, доод хонгил, дээвэр, дээврийн хонгил, цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууцны бус зориулалттай техникийн болон нэгдүгээр давхрын үйлчилгээний өрөө, сууц хоорондын талбай, түүний тагт, сууцны доторх дундын өмчлөлийн зүйл, тоног төхөөрөмж, орчны цонх, хаалга, довжоо, саравч, хог зайлуулах хоолой, орон сууцны байшингийн халаалт болон халуун, хүйтэн усны шугам сүлжээний удирдах зангилааны анхны хаалт, цахилгааны оролтын самбар, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, шалны +0.00 тэмдэгтээс дээших бохир усны шугам сүлжээнүүд, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг эд хөрөнгө” хамаарна гэж заажээ.

Тэрчлэн, үйлчилгээний талбай өмчлөгч иргэн аж, ахуйн нэгж байгууллагууд нь мөн л тухайн орон сууцны гадна хана, даацын хана, багана, цахилгаан болон явган шат, сууц хоорондын талбай буюу коридор, цонх, хаалга, довжоо, саравч, гэрэлтүүлэг зэргийг ашиглаж байгаа, эдгээрийг ашиглахгүйгээр тухайн үйлчилгээний талбай өмчлөгч өөрийн бизнесийн үйл ажиллагааг эрхлэх боломжгүй юм. Иймээс үйлчилгээний талбай өмчлөгч иргэн аж, ахуйн нэгж байгууллагууд нь эдгээр дундын өмчлөлийн эд хөрөнгийг ашигласнаар үүсэх зардлыг төлөхгүй байх нь үндэслэлгүйгээр өөрийн эд хөрөнгийг нэмэгдүүлэх, ашиг олж байгаа хэлбэр юм.

Иймд үйлчилгээний зориулалттай талбай өмчлөгч нь орон сууцны барилгын тодорхой хэсгийг өмчилсөн, тухайн орон сууцны барилгаас салгаж үл болох хөрөнгө өмчилж байгаа тул СӨХ-ийн тухай болон Иргэний хуулиудаар дундын өмчлөлийн эд хөрөнгийг зайлшгүй ашиглаж байгаа юм. Улмаар Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.3-т “Өмчлөгч дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйлийг ашиглаагүй буюу ашиглахаас татгалзсан нь түүнийг дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасны дагуу дундын өмчлөлийн эд зүйлийг зайлшгүй ашигласны зардлыг төлөх үүрэгтэй болохыг харуулж байна.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Гэтэл шүүхийн практикт үйлчилгээний давхруудтай орон сууцны барилгын үйлчилгээний талбайг өмчлөгч болон эзэмшигчийг Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан “Орон сууц гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг” хэлнэ гэснийг үндэслэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зориулалттай тул СӨХ-ийн гишүүн биш гэж үзэх тайлбарлах тохиолдлууд гарч байна. Үүнээс үүдэн нэгдүгээрт, орон сууцны суурийн давхрыг үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь СӨХ-ийн гишүүн мөн эсэх, хоёрдугаарт дундын өмчлөлийн талбайн засвар, үйлчилгээ, харуул хамгаалалт зэрэг ашиглалтын зардлыг хэрхэн хуваарилах эрх зүйн маргаантай асуудлууд шүүхэд хэрхэн шийдвэрлэгдэж байгааг судлах шаардлагатай байна.

1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ТОЙМ СУДАЛГАА

1.1. Анхан шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Энэхүү судалгаагаар нийслэлийн төвийн зургаан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 онд шийдвэрлэсэн маргаанаас Иргэний хуулийн 142-149 дүгээр зүйл, мөн Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний эрх зүйн хэрэг маргааныг шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авч судалсан болно. Ингэхдээ иргэний хэргийн шүүхийн шийдвэрээс СӨХ-тэй холбоотой бүхий л маргааныг орхигдуулахгүй байхаар тооцож, шүүхийн шийдвэрүүдийг нэг бүтэн жилээр түүвэрлэж судаллаа.

Судалгаанд нийслэлийн төвийн зургаан дүүргийн нийт 298 шүүхийн шийдвэрийг шүүж багтаав (Хүснэгт 1-ийг харна уу).

Хүснэгт 1. Анхан шатны шүүхийн сонгож авсан шийдвэрүүдийн тоо (дүүргээр)

№	Иргэний хэргийн анхан шатны шүүх	Шийдвэрлэгдсэн маргааны тоо	
1	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	55	
2	Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	137	
3	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	3	Иргэний хуулийн 142-149 болон СӨХ-ийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн маргаан
4	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	11	
5	Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	30	
6	Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	62	
	Нийт	298	

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Нийслэлийн төвийн зургаан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн хөрөнгийн засвар үйлчилгээ, зардалтай холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар нарийвчлан судалсан дүнг тоймлон доор харуулав.

Энэ төрлийн хэрэг маргааны нэхэмжлэлийн шаардлага нь орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын зардал болон засвар үйлчилгээний зардал хуваарилахтай холбоотой нь дийлэнх хувийг эзэлж байна. Энэ төрлийн маргаанд нэхэмжлэгч тал нь Сууц өмчлөгчдийн холбоо (цаашид СӨХ гэх) байх ба хариуцагчаар сууц өмчлөгчдийн холбооны гишүүн татагдан оролцож байна. Судалгааны явцад 2 тохиолдолд сууц өмчлөгчдийн холбооны гишүүдээс СӨХ-ийн хурлыг хүчин төгөлдөр бусд тооцох, тамга тэмдгийг хүчингүйд тооцох нэхэмжлэл, мөн 4 тохиолдолд СӨХ-ийн захирлаар ажиллаж байсан иргэн хууль бусаар ажлаас халагдсан гэх үндэслэлээр СӨХ-ийг шүүхэд өгсөн тохиолдол байв. Маргаан шийдвэрлэгдэж буй байдлыг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Анхан шатны шүүхийн СӨХ-ийн маргааныг шийдвэрлэсэн байдал (шийдвэрийн агуулгаар)

№	Хэрэг шийдвэрлэгдсэн агуулга	ИХШХШТХ-ийн зүйл, заалт	Тоо	Эзлэх хувь
1	Талууд эвлэрсэн маргааны тоо	ИХШХШТХ-ийн 74.1	73	
2	Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн	ИХШХШТХ-ийн 74.1	79	
3	Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн	ИХШХШТХ-ийн 74.1	27	77
4	Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан	ИХШХШТХ-ийн 74.1	50	
5	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан	ИХШХШТХ-ийн 115.1	37	
6	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон	ИХШХШТХ-ийн 115.1	25	23
7	Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	ИХШХШТХ-ийн 115.1	7	

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд, нийт 298 нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулснаас 229 иргэний хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, Сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээний зардал гаргуулахтай холбоотой маргааны 77 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа бол үлдсэн 23 хувь буюу 69 хэрэг маргаанд талууд мэтгэлцэх зармыг хэрэгжүүлсний үндсэн дээр шүүх шийдвэрээ гаргасан байна.

Мэтгэлцэх зарчмаар шийдвэрлэсэн 69 шийдвэрийн 37 хэрэг маргаанд буюу 54 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байх бол 25 хэрэг маргаанд буюу 36 хувьд нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин 7 хэрэг маргаанд буюу 10 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Үүнээс дүгнэж үзвэл, Иргэний хуулийн 142-149 дүгээр зүйлээр шийдэгдэж буй орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах маргааны дийлэнх буюу 90 хувьд нь маргааныг нэхэмжлэгч талд буюу Сууц өмчлөгчдийн холбооны нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг хангаж шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн маргаан шүүхийн практикт төдийлөн маргаан дагуулдаггүй, ялгаатай шийдвэр маргааны төрөлд хамаарч болох юм. Гэхдээ анхан шатын шүүхийн шийдвэр давж заалдах шат болон Улсын дээд шүүх дээр хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсны үндсэн дээр эцэслэн дүгнэх нь зүйтэй болов уу.

1.2. Давж заалдах шатны шүүхийн магадлалд хийсэн дүн шинжилгээ

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн 2017 оны магадлалаас Иргэний хуулийн 142-149 дүгээр зүйлд заасан орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилахтай холбоотой нийт 35 магадлалд судалгаа хийсэн болно. Эдгээр магадлалын статистик мэдээллийг Хүснэгт 3-т харуулав.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Хүснэгт 3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал (магадлалын агуулгаар)

№	Магадлалын агуулга	ИХШХШТХ-ийн зүйл заалт	Тоо	Эзлэх хувь (%)
1	Шүүхийн шийдвэрт зөвтгөсөн өөрчлөлт оруулсан	167.1.2, 167.1.3	12	34
2	Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцаасан	167.1.5	14	40
3	Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	167.1.4	2	6
4	Шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн	167.1.1	7	20

Дээрх хүснэгтээс харахад, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлал 7 буюу энэ төрлийн хэргийг шийдвэрлэсэн магадлалын 20 хувийг эзэлж байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм. Энэ үзүүлэлт нь 5 магадлал тутмын нэгд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байгааг харуулах бөгөөд үлдсэн 80 хувь буюу 5 магадлал тутмын 4-т нь анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгож шийдвэрлэж байгааг илтгэнэ.

Хэдийгээр СӨХ-ны дундын өмчлөлийн зүйлсийн засвар, үйлчилгээний зардал хуваарилахтай холбоотой маргааны 77 хувь нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж, үлдсэн 23 хувьд талууд мэтгэлцсэний үндсэн дээр шүүх шийдвэрээ гаргахдаа 90 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэж байна. Энэ төрлийн маргаан шүүхэд төдийлөн маргаан дагуулдаггүй юм шиг харагдаж байгаа атлаа давж заалдах шатны шүүх дээр анхан шатны шүүхийн шийдвэрийн 80 хувьд нь өөрчлөлт оруулах, хүчингүй болгож байгаа нь мөн л хууль хэрэглээний, процессын алдаа гардаг болохыг харуулж байна.

1.3. Улсын дээд шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ

2017 оны байдлаар Иргэний хуулийн 142-149 дүгээр зүйлд заасан орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилахтай

холбоотой Улсын дээд шүүхийн нийт 17 тогтоолыг сонгож судаллаа. Эдгээр тогтоолуудын статистик мэдээллийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Улсын дээд шүүхийн тогтоол (тогтоолын агуулгаар)

№	Тогтоолын агуулга	ИХШХШТХ-ийн зүйл заалт	Тоо	Эзлэх хувь (%)
1	Магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан	176.2.3	3	18
2	Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан	176.2.2	5	29
3	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буцаасан	176.2.5	1	6
4	Магадлал, шийдвэрийг хэвээр үлдээсэн	176.2.1	8	47

Дээрх нөхцөл байдлыг дүгнэж үзвэл, энэ төрлийн хэрэг маргааны 47 хувьд нь анхан болон давж заалдах шатны шүүхийн магадлал өөрчлөгдөөгүй байгаа бол хяналтын журмаар гаргасан гомдлын 53 хувьд нь ямар нэг байдлаар магадлал, шийдвэрт өөрчлөлт орох, хүчингүй болгох байдлаар шийдэгдэж байна.

Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах маргааныг шийдвэрлэх явцад дараах хэлбэрийн хууль хэрэглээний материаллаг болон процессын шинжтэй алдаа гарсны улмаас шүүхийн шийдвэр хүчингүй болж байна. Үүнд:

- Орон сууцны контор нь тусгай зөвшөөрөлгүй хэр нь иргэд, оршин суугчидтай гэрээ байгуулж, улмаар СӨХ-ны болон конторын төлбөр авсан тохиолдол гарсан байна. Анхан шатны шүүх Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасны дагуу иргэд дундын өмчлөлийн эд хөрөнгийн төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй гэж шийдвэрлэсэн боловч давж заалдах шатны шүүхээс орон сууцны контор нь бохир ус татан зайлуулах, хэрэглээний усаар хангах тусгай зөвшөөрөлгүй байж оршин суугчдаас төлбөр авсан нь тогтоогдсон. Давж заалдах шатны шүүх үүнийг “орон сууцны конторын иргэдтэй байгуулсан гэрээг хүчин төгөлдөр бусад тооцож, Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1,

56.5, 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэлээр иргэд төлсөн төлбөрөө буцаан шаардах эрхтэй болно. Гэхдээ Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан үүргээс СӨХ-ны гишүүн буюу хэрэглэгч чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм” гэж шийдвэрлэжээ.

- Нэхэмжлэлийн шаардлагыг тодруулаагүй учраас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэтгэлцэх зарчим хэрэгжээгүй гэж үзэх үндэслэл болж байна. Өөрөөр хэлбэл, талуудын нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодруулаагүй нь шүүхийн шийдвэр хуульд нийцсэн, үндэслэл бүхий байх, хэргийг нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэх зарчим мөн зөрчигдөнө гэж үзэн, энэ үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны магадлалыг хүчингүй болгож байна.
- Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.3-г “Тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил” байна гэж заасан байна. Дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ, зардал гаргуулах нэхэмжлэлтэй маргаанд цөөнгүй тохиолдолд 3 болон түүнээс дээш жилийн зардал, засвар үйлчилгээний хөлс шаардсан байх бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны заалтыг зөв хэрэглээгүй байх, аль эвэл хөөн хэлэлцэх хугацааг хэрэглээгүйн улмаас хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлал хүчингүй болж байна.
- Орон сууцны барилгад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд СӨХ-нд төлбөр төлдөг.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-г буюу нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх журам зөрчиж байна. Энэ журмыг шүүх зөрчвөл ИХШХШТХ-ийн 167 дугаар зүйлийн 167.1.5-д заасан үндэслэлээр буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэх үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгож байна. Тухайлбал СӨХ-ийн төлбөр тогтоосон баримтыг гаргуулах хүсэлт гаргасан байтал энэ хүсэлтийг хангахгүй орхисон нь ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.6-г зөрчиж буй хэлбэр болж байгаа юм.

- Хариуцагчид мэдэгдэх хуудас хүргүүлсэн гэх тэмдэглэл нь ИХШХШТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.2-ыг зөрчиж байна. Үүний үр дүнд ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд заасан талууд мэтгэлцэх зарчим зөрчигдөх, тайлбар мэдүүлэг гаргах, нотлох баримт гаргах үүрэг зөрчигдөхөд хүргэж байгаа учраас процессын энэхүү заалтаар шийдвэрийг хүчингүй болгож байна.
- Дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, ашиглалтын зардлыг нэмсэн бол нэмсэн шийдвэрийг заавал хэрэгт хавсаргах, нотлох шаардлагатай. Хэрэв ингэж хавсаргаагүй бол ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.6-г зөрчих нөхцөл байдал бүрдэнэ.
- СӨХ тусгай зөвшөөрөлгүй бол ус түгээх, ариутгах татуургын төлбөр авах эрхгүй. Гэхдээ үүнийг зөрчиж, тусгай зөвшөөрөлгүй байж иргэдээс төлбөр авсан тохиолдол байна.
- Нотлох баримт дутуу ирсэн байхад хэргийг хянан шийдвэрлэсэн нь ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.3-ыг зөрчсөн.
- Шинжээчийн дүгнэлтэд шүүгч дүгнэлт хийгээгүй, дүгнэлтийг шүүгч үнэлээгүй, шинжээчид эрх үүргийг тайлбарлаагүй нь ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9-ийг зөрчсөн.
- Шуудангаар хүргэх боломжгүй бол утсаар ярих журмыг зөрчсөн. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн үндэслэлээр шийдвэр магадлалыг хүчингүй болгох үндэслэл болох юм.
- Хэрэг танилцуулсан баримт байхгүй, энэ нь ИХШХШТХ-ийн 25.1.1-д “эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх” хэргийн оролцогчийн эрх зөрчигдөхөд хүрч байна.
- Аж ахуйн нэгжийн ашиглалтын зардлыг Удирдах зөвлөлийн тогтоолоор өндрөөр тогтоох, аль эсвэл Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан хураамжийн хэмжээг баримтлан айл өрхөөс дундын өмчлөлийн төлбөр тооцоог гаргуулж байна. Гэтэл СӨХ-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д СӨХ-ны Удирдах зөвлөлийн эрх, үүргийг зааж өгсөн байх бөгөөд үүнд удирдах зөвлөл нь СӨХ-ны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг тогтоох эрх хэмжээ олгогдоогүй. Харин СӨХ-ны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг тус хуулийн 7 дугаар зүйлийн

7.2.1¹ болон 6 дугаар зүйлийн 6.1.6²-д заасны дагуу бүх гишүүдийн хурлаар төлбөрийн хэмжээг өөрчлөх бүрэн эрх нь олгогдсон байна.

Сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, орон сууцны байшингийн харуул хамгаалалттай холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд оролцох журмыг СӨХ-ны дүрмээр, бүх гишүүдийн хурлаас тогтоохоор хуульчилсан. Хэдий тийм боловч СӨХ-ны нэхэмжлэлийн шаардлагыг судлаад үзэхэд, нэхэмжлэлийн үнийн дүнгийн задаргаа нь СӨХ-ны бүх гишүүдийн хурлаас тогтоосон үнэ, тарифаар бус СӨХ-ны удирдах зөвлөлийн өсгөж тогтоосон үнийн дүнгээр нэхэмжлэх тохиолдол цөөнгүй байна. Нөгөөтээгүүр, шүүхэд маргаан үүсгэлгүйгээр СӨХ-ны удирдах зөвлөлөөс хууль зөрчиж өндөр үнэ тогтоосон тогтоолын дагуу дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний үнийг төлж буй оршин суугчид байгаа нь эргэлзээгүй юм.

¹ 7.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. 7.2. Дараах асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. 7.2.1. холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

² 6.1. Холбооны дүрэмд дараах зүйлийг заавал тусгана: 6.1.6. сууц өмчлөгч бүрээс дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар, үйлчилгээ, орон сууцны байшингийн харуул хамгаалалттай холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд оролцох журам

2. ТОДОРХОЙ НЭГ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Шүүхийн шийдвэрийн танилцуулга

“ДГШ” СӨХ-ны нэхэмжлэлтэй, Ерөнхий боловсролын “С” сургуульд холбогдох дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээний зардал гаргуулахтай холбоотой маргааныг Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр хянан шийдвэрлэж гаргасан 001/ХТ2017/00161 тоот тогтоол, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1880 дугаар магадлал, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 102/ШШ2016/05026 дугаар шийдвэрийн хүрээнд авч үзлээ.

2.2. Үйл баримтын агуулга

БГД-ийн “...” дугаар хороо, ”...” хотхонд баригдсан 30а, 30б, 30в байрууд нь “...”-ын авто баазын албан хаагч, ажилчдыг орон сууцанд бүрэн хамруулж, тэдний нийгмийн асуудлыг сайжруулах зорилгоор баригдсан. “С” сургууль нь 30а байрны “....-....” тоотыг эзэмшиж, үйл ажиллагаа явуулдаг. Тус сургуультай албан ёсоор гэрээ байгуулж ажиллахаар СӨХ-өөс 2015 оны 11 дүгээр сард 2 удаа гэрээний хувийг өгч, санал хүсэлтээ өгөөрэй гэсэн боловч хариу ирүүлээгүй. СӨХ-ны нягтлан бодогч, байцаагч нар очиж уулзаж, албан бичиг өгсөөр байхад сууц өмчлөгчдийн холбооны төлбөрөө төлөөгүй. “ДГШ” СӨХ нь 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн бүх гишүүдийн хурлаар 1м.кв талбайн хөлсийг айл өрхөөс 160 төгрөг, албан байгууллагуудаас 600 төгрөгөөр тооцож авахаар шийдвэр гаргасан. Энэ нь Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.4.1, 16.4.2, 16.5 дахь хэсгүүдэд заасантай нийцэж байгаа. СӨХ нь “С” Сургуулийг Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж 2015 оны 9 дүгээр сараас 2016 оны 5 дугаар сарыг дуустал хугацааны дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээний зардалд 2,457,738 төгрөг гаргуулахаар шаарджээ.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

“С” сургууль нь “улсын бүртгэлийн гэрчилгээнд “...” тоот гэж бүртгэгдсэн. “Цагдаа-2” хотхоны 30а байрны 441 м.кв талбай бүхий 1 дүгээр давхрын тусдаа хаалгатай, оршин суугчдад ямар ч саад болохооргүй хэсгийг сургуулийн зориулалттай болгож бариулсан бөгөөд уг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болохоос орон сууцны өмчлөгч биш юм. Сууц өмчлөгчдийн холбооноос манайд хандаж байсан, өөрийн өмчлөлийн байрандаа 2015 оны 9 дүгээр сараас сургуулийнхаа үйл ажиллагааг эрхэлж эхлэх үед төлбөр нэхэмжилж ирсэн. Бид хэд хэдэн удаа уулзаж, төлбөрийн талаар байр сууриа илэрхийлж гэрээ хийхийг хүссэн бөгөөд ирүүлсэн гэрээ нь ойлгомжгүй, тодорхой бус байсан. Хэдий хэмжээний мөнгө, ямар үндэслэлээр нэхэмжилж байгааг ойлгохгүй байна. Сургууль 30а байрны үзүүрт байдаг учир гэрэлтүүлэг хэрэглэдэггүй, мөн камертай тул харуул, хамгаалалт шаардлагагүй. Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэгт заасны дагуу талбайн хэмжээг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй, биднээс санал аваагүй бөгөөд сууц өмчлөгчдийн холбоо нь манай сургуультай гэрээ байгуулаагүй тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй” гэжээ.

2.3. Шийдвэрлэгдсэн байдал

Анхан шатны шүүх Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1, Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасныг баримтлан хариуцагч Ерөнхий боловсролын “С” сургуулиас дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардалд 2,457,738 төгрөг гаргуулан “ДГШ” СӨХ-д олгохоор шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул Ерөнхий боловсролын “С” сургуулиас 2,457,738 төгрөг гаргуулах тухай “ДГШ” СӨХ-ны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдсэн.

Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж, хяналтын журмаар гаргасан нэхэмжлэгчийн гомдлын заримыг хангаж шийдвэрлэв.

УДШ-ийн шийдвэрийн агуулгыг авч үзвэл нэхэмжлэгч “ДГШ” СӨХ Ерөнхий боловсролын “С” бага сургуульд холбогдуулан дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээний зардалд 2,457,738 төгрөг гаргуулахаар нэхэмжилжээ. Хариуцагч Ерөнхий боловсролын “С” сургууль нь сууц өмчлөгч биш тул нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөхгүй гэж маргасан байна. Ерөнхий боловсролын “С” сургууль нь “ДГШ” СӨХ-д хамаарах Баянгол дүүргийн 3 дугаар хороо Дунд гол гудамжны 30а байрны “...” тоот хаягт байршилтай боловч сургалтын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч болох нь хэргийн 79 дүгээр талд авагдсан Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээгээр тогтоогдож байх тул Ерөнхий боловсролын “С” сургуулийг сууц өмчлөгч биш гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг зөрчөөгүй байна. Иймд Ерөнхий боловсролын С бага сургууль нь Иргэний хууль болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар зохицуулагдах сууц өмчлөгчийн үүргийг хүлээхгүй юм. Харин тус бага сургууль нь 2015 оны 9 дүгээр сараас хойш тус байранд байрлаж, үйл ажиллагаа явуулахдаа “ДГШ” СӨХ-ноос үзүүлсэн харуул хамгаалалт, хог ариутгал, гэрэлтүүлгийн үйлчилгээг ашигласан байх тул тухайн үйл ажиллагаанд зориулсан бусдын зардлаар өөрийн хөрөнгийг хэмнэх аргаар хөрөнгөжсөн гэж үзэж, нэхэмжлэлийн шаардлагаас дээрх зардлыг хариуцагчаар төлүүлэх нь зүйтэй байна. Иймд гэрэлтүүлэгт нэхэмжилсэн 15,300 төгрөг, харуул хамгаалалтын 45,000 төгрөг, хог ариутгал 13,500 төгрөг, нийт 73,800 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж, дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээний зардал гаргуулахыг хүссэн нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.

Үүнээс харахад Улсын дээд шүүхийн дээрх тогтоол нь шийдвэрт тавигдах формал шаардлагыг хангаж байгаа болно.

2.4. Шийдвэрээс урган гарч буй асуудал

Судлаачийн зүгээс орон сууцны зориулалттай барилгын үйлчилгээний талбай худалдаж авсан, аль эсвэл орон сууцны талбайг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхээр засаж тохижуулсан иргэн, аж ахуйн нэгж нь орон сууц өмчлөгч (СӨХ-ны гишүүн) мөн эсэх гэсэн асуудлыг дэвшүүлж, энэхүү шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх судалгааны ажлаа эхлүүлсэн билээ.

Улсын дээд шүүхийн энэхүү тогтоолоор орон сууцны зориулалттай барилгын үйлчилгээний талбай өмчлөгч, аль эсвэл орон сууцны талбайг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхээр засаж тохижуулсан иргэн, аж ахуйн нэгж нь тухайн орон сууцны СӨХ-нд хамаарах гишүүн биш болж байна. Үүний үр дагавар тухайн орон сууцанд аж ахуйн зориулалттай үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.1-д заасан “дундын өмчлөлийн зүйлсийг ашиглах, захиран зарцуулахад өөрт оногдох хэсгээр саналын эрхтэй оролцох, дундын өмчлөлийн зүйлд учирч болох гэм хорыг арилгах шаардлагатай арга хэмжээг бусад өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр авах, зайлшгүй гарсан зардлаа нөхөн төлүүлэхээр шаардах эрхийг эдлэхгүй болж байна. Мөн түүнчлэн дээрх зүйлийн хоёр дахь хэсэгт заасан “дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон болон бусад нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд тогтоосон хэмжээгээр оролцох зэрэг үүргээс чөлөөлөгдөж байна.

Тэгвэл нийтийн зориулалттай орон сууцны нэг давхрын талбайг засаж тохижуулан үйлчилгээний зориулалттай болгон өөрчилсөн бол Иргэний хуульд заасан СӨХ-ны гишүүн болон түүний хүлээх үүргээс чөлөөлөгдсөнөөр үүсэх хууль зүйн үр дагавар нь тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардлыг хариуцах үүргээс чөлөөлөгдөх юм. Үүний үр дүнд өөрийн хөрөнгийг хэмнэх замаар үндэслэлгүйгээр хөрөнгөжих нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.3-т “Орон сууцны дээвэр, доод хонгил, халаалт болон халуун, хүйтэн усны удирдах зангилааны анхны хаалт хүртэл, цахилгаан оролтын самбар хүртэл, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэл, шалны +00 тэмдэгтээс дээших бохир усны шугам сүлжээ, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол,

тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ, даатгал болон холбогдох бусад зайлшгүй зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлохдоо сууц эзэмшигчдийн дангаар өмчлөх талбайг, тухайн орон сууцны байшингийн дангаар өмчлөх өмчлөлд байгаа нийт талбайд харьцуулан гаргана” гэж тусгасан заалттай зөрчилдөх нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Учир нь Улсын дээд шүүхийн тогтоолоор “С” сургууль нь үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ дээрээ “Бага сургууль”-ийн үйл ажиллагаа явуулах зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, мөн аж ахуйн нэгжийн дүрэмд “сургалтын үйл ажиллагаа” явуулахаар тусгасан байгаа тул Орон сууцны тухай болон СӨХ-ны тухай хуулиар сууц өмчлөгч биш гэж үзнэ. Ингэснээр “С” сургууль нь тухайн орон сууцны дээврийн засвар үйлчилгээ, халуун хүйтэн тухайн орон сууцанд хамаарах хэсгийн засвар үйлчилгээ, цахилгааны шугамын засвар үйлчилгээний төлбөр, бусад холбогдох зайлшгүй зардлыг төлөх үүргээс чөлөөлөгдөж байна.

Үүний үр дагавар нь тухайн орон сууцны оршин суугчдад сөргөөр нөлөөлөх буюу нэг өрхөд ноогдох СӨХ-ны төлбөр нэмэгдэж, нөгөө талд аж ахуйн нэгж сууц өмчлөгч биш бол СӨХ-нд хамаарахгүй болж холбогдох үүргээс чөлөөлөгдөх хууль зүйн үндэслэлийг бий байгаа юм.

2.5. Адил төстэй маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практик

2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Улсын дээд шүүхийн 001/ХТ2017/01463 тоот тогтоолоор “ЭЗ” СӨХ-ны нэхэмжлэлтэй “А” цэцэрлэгт холбогдох хэргийг шийдвэрлэжээ. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөрт 15,000,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар нэхэмжилжээ. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрөн, анх тухайн орон сууцыг 2003 онд худалдан авч, зохих байгууллагын зөвшөөрөлтэйгөөр цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Уг байрны орцоор ордоггүй бөгөөд, хаалга, харуул хамгаалалт, цэвэрлэгээ тусдаа, хогоо өөрсдөө хариуцаж явдаг. Иргэний хуулийн 145 дугаар зүйлд заасны дагуу орон сууцыг дангаар эзэмшиж байгаа тул СӨХ-ны төлбөр төлөхгүй гэж маргажээ.

Дээд шүүхээс “Хариуцагч Ц.Т-ын хувьд орон сууцны өмчлөгч бус анхнаасаа уг байшингийн 1 давхарт цэцэрлэгийн зориулалтаар барьсан

үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч байсан, тухайн зориулалтаар нь эд хөрөнгийг эзэмшиж ашиглаж байгаа нь тогтоогдсон, хариуцагч нарыг орон сууцны зориулалттай эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч гэж үзэх үндэслэлгүй гэжээ. Өөрөөр хэлбэл, хариуцагч Ц.Т нь орон сууцны өмчлөгч биш бөгөөд нийтийн зориулалттай орон сууцны нэг хэсэгт цэцэрлэгийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч тул СӨХ-ны гишүүн байх үүрэг хуулиар үүсэхгүй, нэхэмжлэгчийн хувьд хариуцагч нараас дундын өмчлөлийн эд зүйлийн ашиглалт, засварын зардлыг сууц өмчлөгч гэж үзэж шаардах эрхгүй байна. Хариуцагч Ц.Т-ын өмчлөлийн эд хөрөнгөд “А” цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа, тус цэцэрлэг нь орон сууцны гадна талаасаа тусдаа хаалгатай боловч сууц өмчлөгч нарын дундын өмчлөлийн эд зүйл болох орон сууцны орц, орчны талбай зэрэг зарим эд хөрөнгийг ашиглах, нөлөөлөх боломж байгаа нь тогтоогджээ. Гэхдээ Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан шаардах эрх үүсэхгүй болно” гэсэн агуулгатай тогтоол гаргажээ.

Дээрх тогтоолоос харахад, мөн л орон сууцны бус зориулалттай цэцэрлэг нь СӨХ-ны гишүүн болохгүй бөгөөд Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.1-д заасан үүргээс чөлөөлөгдөнө, нөгөө талаар СӨХ-нд Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан шаардах эрх үүсэхгүй юм гэж үзсэн байна.

2.6. Эрх зүйн онол, үзэл баримтлал

Орон сууцны зориулалттай барилгын үйлчилгээний талбай худалдаж авсан, аль эсвэл орон сууцны талбайг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхээр засаж тохижуулсан иргэн, аж ахуйн нэгж нь орон сууц өмчлөгч (СӨХ-ны гишүүн) мөн эсэх гэсэн асуудалд Улсын дээд шүүхээс СӨХ-ны гишүүн болохгүй гэх нэгдсэн байр сууринаас хэргийг шийдвэрлэж байна. Улсын дээд шүүх энэ төрлийн хэрэг маргаанд нэг ижил байдлаар хэргийг шийдвэрлэж байгаа сайн талтай боловч, орон сууцыг үйлчилгээний зориулалттай болгосон, аль эсвэл орон сууцны суурын давхар нь үйлчилгээний зориулалттай байр эзэмших иргэн, аж ахуйн нэгжийг тухайн орон сууцанд өмчилж буй дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээнд хэрхэн оролцох ёстой талаарх тодорхой дүгнэлт гаргаж шийдэх шаардлагатай.

Түүнчлэн орон сууцны ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагууд буюу нийтийн аж ахуйн салбарын онцлог нь нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс ашгийн бус байх шаардлагатай онцгой объект төдийгүй ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчид байх хуулийн зохицуулалттай. Гэтэл нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинээр баригдаж буй барилга, байгууламжийн ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламж, төвлөрсөн болон салбар шугам сүлжээ хувийн хэвшлийн болон дундын өмчлөлийн байх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. Орон сууцны халуун, хүйтэн ус, бохир ус татан зайлуулах шугам сүлжээ нь дундын өмчлөлийн эд хөрөнгийн зүйл болсон байтал, тухайн орон сууцанд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэн нь СӨХ-ны гишүүний үүргээс чөлөөлөгдөж, энэхүү харилцаа хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй нь хүндрэл учруулж байна.

2015 онд гүйцэтгэсэн “Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны дүнгээс харахад Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтэд саад болж буй хүчин зүйлсийн талаар салбарын 124 мэргэжилтнээс авсан судалгаагаар инженерийн барилга, байгууламжийн өмчлөл тодорхойгүй байдал нь тус хууль хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болдог гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, нийтийн орон сууцны зориулалттай байрны ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн өмчийн эрх нь тодорхойгүй, аль эсвэл дундын өмчлөлийн эд зүйлс болжээ. Ингэснээр ус хангамж, ариутгах татуургын тухай хууль хэрэгжихгүй байгаа буюу хэрэгжилт нь сул байна гэж дүгнэж болохоор байна. Дээрх нөхцөл байдал, судалгаануудаас дүгнэлт хийж үзэхэд, нийтийн орон сууцны зориулалттай барилгын үйлчилгээний талбай өмчлөгч, аль эсвэл орон сууцыг аж ахуйн үйлчилгээ эрхлэх зорилгоор засаж тохижуулсан бол тухайн иргэн, аж ахуйн нэгжид Иргэний хуулийн 147, 148 дугаар зүйлд заасан тодорхой үүрэг хүлээдэг байхаар хуулийн нарийвчилсан зохицуулалтыг Иргэний хууль болон СӨХ-ны тухай хуульд оруулж өгөх, аль эсвэл шүүхийн практик хэрэглээг зөв тогтоох хэрэгцээ шаардлага байна.

2.7. Япон Улсын шүүхийн практиктай харьцуулсан шинжилгээ

Энэ төрлийн маргааныг Япон Улсад хэрхэн шийдвэрлэж байгааг судалж үзэхэд, Иргэний хуульд нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн зохицуулалт байхгүй байх бөгөөд *Барилгыг хэсгээр өмчлөгчид хамаарах тухай*³ бие даасан хуулиар зохицуулдаг аж. Уг хуулийн зохицуулалтаар дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг тухайн барилгын (орон сууц) өмчлөгчид өмчлөлийн талбайдаа хувь тэнцүүлэх байдлаар хариуцдаг байна⁴. Өөрөөр хэлбэл, том талбайтай өмчлөгчийн хариуцах төлбөр өндөр байх бол бага талбай бүхий өмчлөгчийн дундын өмчлөлийн хөрөнгийн засвар үйлчилгээнд хариуцах төлбөр нь бага байдаг. Гэхдээ нийтийн зориулалттай орон сууцны нэг давхарт дэлгүүр болон аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг өмчлөгч нарын оршин суугчдаас өндөр төлбөр төлдөг⁵.

Тэрчлэн, тус хуулийн 3 дугаар зүйлд барилгын “Өмчлөгчдийн холбоо”-ны талаар зохицуулсан байх бөгөөд тухайн барилгад хэсгээр өмчлөх эрхтэй бүх гишүүн хамаарах ба тухайн барилга, барилгын оршин байгаа газар болон барилгын дагалдах дэд бүтцийн (усны шугам хоолой, цахилгааны шугам зэрэг) арчилгаа, хамгаалалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх үүднээс холбоо байгуулах, тус холбооноос хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гаргасан шийдвэрээр зохицуулах эрхтэй байхаар хуульчилжээ. Үүнээс үзвэл, аж ахуйн зориулалттай үйл ажиллагаа явуулдаг этгээд мөн тус холбооны гишүүн болдгоороо манай улсын эрх зүйн зохицуулалтаас ялгаатай байна. Учир нь энэ хуулийн зохицуулалт нь зөвхөн амьдрах зориулалттай сууц өмчлөгчид хамаарах бус тухайн барилгад хэсгээр өмчилж байгаа бүх өмчлөгчид хамаарах юм.

Тус хуулийн 16 дугаар зүйлд “Дундаа хэсгээр өмчлөх (ашиглах) хөрөнгөд (дундаа хэсгээр өмчлөх, ашиглах хөрөнгө гэдэг нь зөвхөн тухайн өмчлөгчид л дундаа ашиглах хэсэг, тэр хэсгийн дундын талбай, эд хөрөнгө. Тухайлбал, орон сууцны 10 дугаар давхрын талбайн хэсгийг 10 дугаар давхрын өмчлөгчид л дундаа хэсгээр ашиглах юм),

³ 建物区分所有法、Барилгыг хэсгээр өмчлөгчид хамаарах тухай хууль. 1962 онд батлагдсан.

⁴ 建物区分所有法、14条1項、Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

⁵ 建物区分所有法、

бүх өмчлөгчийн эрх ашгийг хөндөхөөр мөн барилгын “Өмчлөгчдийн холбоо”-ны дүрэмд заасан бол бүх гишүүн хэсгээр дундаа ашиглах хөрөнгийн зардлыг хариуцна” гэж хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, барилгын нэгдүгээр давхарт аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгч нь тухайн барилгын (орон сууцны) нийтийн зориулалттай талбайг ашиглаагүй байсан ч засвар үйлчилгээний төлбөрийг хариуцахаар хуульчилжээ.

Шүүхийн шийдвэрээр хуулийн зохицуулалтаа хэрхэн тайлбарладаг талаар товч авч үзье. Япон Улсын хувьд хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хуулийг тайлбарладаг тул шүүхийн жишгийг мөрдлөг болгодог улс юм. Шүүхийн жишгээс үзвэл, орон сууцны барилгын 1 дүгээр давхрыг өмчилж, дэлгүүрийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй эрхлэгч Y нь тухайн барилгын нэгдүгээр давхрын цахилгаан шатыг ашигладаггүй байсан учраас бусад өмчлөгчтэй харьцуулбал бага ашиглалтын зардал төлдөг байсан. Үүний эсрэг оршин суугчид сууц өмчлөгчдийн холбооны олонхын шийдвэрээр ашиглалтын зардлыг нь нэмсэн тохиолдол гарчээ. Улмаар Y нь үүнийг эсэргүүцэж 1 дүгээр давхрын цахилгаан шатыг зөвхөн 1 дүгээр давхраас дээш оршин суудаг суугчид (X оршин суугчид) л ашигладаг учраас тэдний л дундаа хэсгээр ашиглах хөрөнгөд хамаардаг, цахилгаан шатны ашиглалтын зардлыг төлөх шаардлагагүй гэж маргасан⁶. Анхан шатны шүүхээс X оршин суугчдын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, ингэхдээ 1 дүгээр давхрын дундын өмчлөлийн талбай болон тэр хэсэгт байрлах хөрөнгө нь зөвхөн X оршин суугчид ашиглах, дундаа хэсгээр ашиглах хөрөнгө гэж үзсэн байна.

Харин дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ⁷. Шийдвэрийнхээ үндэслэлд “Дээрх маргааны хувьд Y-ийн дэлгүүрийн байрлал, дангаар өмчлөх хөрөнгө

⁶ Дээрх тохиолдолд тухайн орон сууцны 1 давхарт Y-ийн дангаар өмчилдөг дэлгүүр болон дундын өмчлөлийн зүйл болох орц, орцны коридор, цахилгаан шатны өрөө, 2 дугаар давхар руу гарах шат, шатны хэсэг зэрэг дундын өмчлөлийн талбайн зүйлүүд байсан. Түүнчлэн Y-ийн дэлгүүр рүү орох орц гарц нь барилгын орцноос тусдаа байсан бөгөөд Y-ийн дэлгүүрээс орц руу орох хаалга байхгүй, зохион байгуулалт бүтцийн хувьд нэлээд тусгаарлагдмал байсан байна. Гэхдээ Y-ийн дэлгүүрийн сурталчилгааны самбар болон Y-ийн дэлгүүр ашигладаг усан хангамжийн дэд бүтэц болон агааржуулалтын төхөөрөмж нь тухайн барилгын 3 дугаар давхарт байрлаж байсан учраас эдгээрийн засвар үйлчилгээг хийхийн тулд дундын өмчлөлийн талбайг ашиглах тохиолдол гардаг байжээ.

⁷ Токио хотын давж заалдах шатны шүүхийн 1984 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 1139 дугаар 44.

болон дундын өмчлөлийн зүйлийн харилцан хамаарал, хөрөнгийн оршин байгаа зориулалт, ашиглалтын байдал зэрэг олон талын нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байгаа боловч Ү болон Х оршин суугчдын эрх үүргийг энэ тохиолдолд нарийн зааглах боломжгүй. Тэрчлэн, анхан шатны шүүхийн шийдвэр зүй зохистой үндэслэл бүхий байж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, барилгыг бүхэлд нь арчлан хамгаалах, бүх оршин суугчдын эрх ашгийг хөндөхгүй байх, эрх зүйн зохицуулалтын төвөгтэй байдлаас сэргийлэх үүднээс (тухайн хөрөнгө нь илэрхий тодорхой дундаа хэсгээр ашиглах хөрөнгөд хамаарахаас бусад тохиолдолд) бүх өмчлөгчийн дундаа ашиглах, өмчлөх хөрөнгө гэж үзэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Улмаар шийдвэрээ дараах гурван үндэслэлээр тайлбарлажээ. Үүнд: (i) энэ хэргийн тухайд дундын ашиглалтын талбайд барилгын орц, шатны хэсэг, цахилгаан шатны өрөө, цахилгаан шат, аваарын гарц, жижүүрийн өрөө зэрэг нь Ү-ийн дангаар өмчлөх хөрөнгөөс бүтцийн хувьд тусдаа байгаа ч, (ii) Ү-ийн дундын өмчлөлийн талбай бага бус, түүнчлэн Ү-ийн дэлгүүр нь орон сууцнаас бүрэн тусгаарлагдаагүй, (iii) Ү өөрийн дангаар өмчлөх хөрөнгөө ашиглахад зайлшгүй дундын өмчлөл, ашиглалтад байгаа хөрөнгийг ашиглах нөхцөл байдалд байгаа ба Х оршин суугчид л зөвхөн дундын өмчлөл, ашиглалтад байгаа талбайг ашиглаж байна гэж шийдэх боломжгүй тул “Ү” нь энэ тохиолдолд бусад оршин суугчид адил хэмжээгээр орон сууцны дундын өмчлөлийн талбайн ашиглалтын зардлыг хариуцах ёстой гэж шийдвэрлэжээ.

Мөн дээрхтэй адил хэргийг Токио хотын шүүх 1994 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1461 дугаартай шийдвэрээрээ шийдвэрлэсэн байна. Хэргийн тухайд орон сууцны барилгын I давхарт шүдний эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн зүгээс нэхэмжлэл гаргасан байх бөгөөд нэхэмжлэлдээ эмнэлгийн орц гарц нь шууд нийтийн эзэмшлийн гудамж руу гардаг, барилгын зохион байгуулалтын хувьд цахилгаан шат ашиглахааргүй, I болон II давхраас дээших усан хангамжийн шугам хоолой нь тусдаа байрладаг учраас цахилгаан шат болон усан хангамжийн дэд бүтэц нь II давхраас дээш оршин суугчид л зөвхөн ашигладаг, тэдний дундаа хэсгээр ашигладаг хөрөнгө тул эмнэлгийн зүгээс дээрхтэй холбоотой ашиглалтын зардлыг төлөх шаардлагагүй гэж маргажээ.

Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ (i) цахилгаан шат болон усан хангамжийн дэд бүтцийн шугам сүлжээ нь Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд зааснаар дундын ашиглалтын эд хөрөнгө гэж заасан, (ii) барилгын бүтэц болон байгууламжийн шинж чанар талаас нь авч үзэхэд бүхэлд нь дундаа хэсгээр ашиглах хөрөнгө гэж үзэхээр, (iii) цахилгаан шатыг I давхрын өмчлөгч нар дээврийн зориулалтаар ашиглаж байгааг үгүйсгэх аргагүй, (iv) ус зайлуулах шугам хоолой нь I болон II давхрыг бүхэлд нь хамарсан цогц байдлаар хийсэн байгууламж байна, (v) I болон II давхрын шугам хоолойн засвар үйлчилгээг хийхэд барилгын бүх шугам хоолойд нөлөөлөх тул нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй гэж үзсэн байна.

Япон Улсын хуульч, судлаачид энэ төрлийн маргаан буюу орон сууцны I давхарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй эрхлэгчийн дундын өмчлөлийн хөрөнгийн зардлыг хариуцах эсэхийг шийдвэрлэхдээ тухайн тохиолдол, хэргийн агуулгыг сайтар судалсны үндсэн дээр шийдвэрээ гаргахад дөхөм болох шалгууруудыг гаргаж ирсэн байна⁸. Үүнд: (i) хэлбэрийн шаардлагуудаар шалгах, (ii) үндсэн гол шалгуураар шалгасны үндсэн дээр барилгыг бүхэлд нь арчлан хамгаалах, нийт өмчлөгчдийн ашиг сонирхол болон хэсгээр өмчлөгчийн ашиг сонирхлыг (тухайлбал, I давхарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгч) хооронд нь харьцуулах, (iii) дундын өмчлөлийн талбайг бүх өмчлөгч дундаа өмчлөн ашиглалтын зардлыг төлснөөс тухайн талбайг дангаар өмчлөгчид хариуцуулсан нь бусад өмчлөгчийн эрх ашигт нийцэхээр нөхцөл байдал байна уу гэдгийг шалгасны үндсэн дээр шийдвэр гаргах хэрэгтэй⁹ гэж үзжээ.

Хэлбэрийн шаардлагаар шалгах гэдэгт:

- Барилгын зохион байгуулалтын бүтцийн хувьд тухайн дундын өмчлөлийн зүйл нь харьцангуй бусад дундын өмчлөлийн зүйлээс тусгаарлагдсан эсэх. Өөрөөр хэлбэл, тухайн дундын өмчлөлийн зүйл (жишээ нь I давхарт үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн өмчилж буй хэсэг дэх дундын өмчлөлийн зүйл. Үүнд: барилгын хана, цахилгааны шугам, халуун хүйтэн ус, бохирын шугам зэрэг) нь барилгын бусад дундын өмчлөлийн зүйлд нөлөөлж байгаа эсэх,

⁸ 野口 大作、マンション区分所有建物における 管理費等の負担割合 Дайсаку Ногучи, Орон сууц дангаар өмчлөгчдийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн зардлыг хуваарилах асуудал, Илтгэл,

⁹ Мөн тэндээс

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

бүтцийн хувьд цогц байдлаар хийгдсэн эсэхийг шалгах.

- Тоног төхөөрөмжийн хувьд түүний шинж чанар, зориулалт нь бусад дундын өмчлөлийн тоног төхөөрөмжтэй холбоотой эсэх шалгах.

Үндсэн гол шалгуур гэдэгт:

- Тухайн дундын өмчлөлийн зүйл бусад өмчлөгчийн хувьд зайлшгүй шаардлагатай зүйл эсэх.
- Тухайн дундын өмчлөлийн зүйлийг зөвхөн тэр хэсгийг хамаарах дангаар өмчлөгч л зөвхөн онцгой эрхтэйгээр ашигладаг эсэх, бусад өмчлөгчийн хувьд тухайн дундын өмчлөлийн зүйлийг ашиглах боломж нь хязгаарлагдмал эсэх.
- Өмчлөгчийн тухайн дундын өмчлөлийн зүйлийг ашиглах давтамж, ашиглаж буй нөхцөл байдал зэргийг харгалзан үзэх.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзвэл, Япон Улсын *Барилгыг хэсгээр өмчлөгчид хамаарах тухай* хуульд орон сууц өмчлөгч, сууц өмчлөгч гэсэн тодорхойлолт байхгүй бөгөөд хэсгээр өмчлөгч буюу дангаар өмчлөгч гэсэн нэр томъёог хуульдаа тусгаж өгсөн. Үүний үр дүнд тухайн нэг барилгын хэсгүүдийг орон сууц, оффис, дэлгүүр, агуулахын зэрэг зориулалтаар ашиглаж байсан ч тухайн талбайг дангаар өмчлөгчийн хувьд нь хуулийн зохицуулалтаар хийж өгчээ. Өөрөөр хэлбэл, тухайн барилгын тодорхой хэсгийг дангаар өмчлөгч гэдэг утгаар нь өмчлөх эрхэд нь суурилсан хуулийн зохицуулалттай байна. Үүний улмаас орон сууцны барилгын I давхарт аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй этгээд ч тухайн орон сууцны “Өмчлөгчдийн холбоо”-ны гишүүн болох тул дундын өмчлөлийн зүйлийн зардлыг хариуцдаг байна.

2.8. Шийдвэрт өгөх үнэлгээ

Улсын дээд шүүхээс энэ төрлийн хэрэг маргааныг нэгдсэн байр сууринаас шийдвэрлэж байгаа нь хэргийг нэг мөр шийдвэрлэж, өөр өөрөөр шийдвэрлэхгүй буюу хуулийг нэг мөр тайлбарлаж хэрэглэж байгаа нь сайн талтай байна. Гэхдээ Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1, 147.2, 147.3-г заасан дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээг хэрхэн хуваах тал дээр илүү үндэслэл бүхий дүгнэлт гаргаж, хуулийг илүү өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх замаар сууц

өмчлөгчдийн холбооны гишүүн бус, орон сууцны барилгад аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй өмчлөгч хэрхэн дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг хариуцах, зардлыг хэрхэн хуваарилах шүүхийн шинэ жишиг тогтоох шаардлагатай байна. Мөн нөгөө талаас, дундын өмчлөлийн эд хөрөнгө, талбайн арчлалт, хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг илүү нарийвчлах, тодорхой болгох шаардлагатай.

Шүүхийн зүгээс Орон сууц хувьчлах тухай, Орон сууцны тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиудаар орон сууцны барилгад сууц өмчлөгчийг зөвхөн СӨХ-ны гишүүн гэж үзэх, улмаар Иргэний хуулийн 147.1-3 дахь хэсэгт заасан зардал, СӨХ-ны тухай хуулийн 13 болон 16 дугаар зүйлүүдэд заасан үүргийг тухайн барилга дотор үйл ажиллагаа явуулж буй аж ахуй эрхлэгчид хамаарахгүй байхаар үүргээс чөлөөлж байгаа нь тухайн орон сууцанд оршин сууж буй нийт оршин суугчийн эрх ашгийг хөндөж байгаа юм.

Орон сууцны барилга дотор үйл ажиллагаа явуулж буй аж ахуй эрхлэгчийн дангаар өмчлөлийн хэсэг нь тухайн орон сууцны бүрдэл хэсэг болох ба салгаж үл болох, нэг цогц зүйл юм. Тухайлбал, тухайн барилга руу орж буй цэвэр бохир усны шугам, бохир ус татан зайлуулах хоолой, цахилгааны шугам зэрэг нь тухайн барилгын бүх өмчлөгчид хамаарах дундын өмчлөлийн зүйл болно. Суурийн давхарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй эрхлэгчийн хувьд мөн л тухайн барилгын шугам хоолой дэд бүтцийг ашиглах бөгөөд оршин суугчдаас үл хамаарах байдалтайгаар ус цахилгааны асуудлыг шийдвэрлэх бараг боломжгүй. Тэрчлэн, дээврийн засвар үйлчилгээ, барилгын гадна болон дотор хананы засвар үйлчилгээний зардлаас чөлөөлөгдөх учиргүй юм. Өөрөөр хэлбэл, нэг давхрын хэсэгт дээвэр байхгүй учир дээврийн зардал төлөхгүй гэх логикийн хувьд алдаатай бөгөөд хэрэв тэгвэл хамгийн дээд давхрын айл л зөвхөн дээврийн засвар үйлчилгээний зардлыг хариуцах нь. Энэ мэтчилэн өмчийн харилцан хамаарал, бүрдэл хэсэг гэдэг утгаар нь аваад үзвэл, орон сууцны суурийн буюу нэгдүгээр давхрыг өмчилж үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж ч гэсэн СӨХ-ны гишүүн болж, Иргэний хуулийн 147.1-3-т заасан зардал, СӨХ-ны тухай хуулийн 13 болон 16 дугаар зүйлүүдэд заасан үүргийг зайлшгүй хүлээлгэх шаардлагатай юм.

3. ДҮГНЭЛТ

2018 оны эцсээр нийслэлийн хэмжээнд орон сууцны I давхарт үйл ажиллагаа явуулж буй ресторан, цайны газар, кафе зэрэг нийт 679 аж ахуйн нэгж нийтийн хоолны үйлчилгээ үзүүлж байна¹⁰.

2017 оны байдлаар улсын хэмжээнд нийт 627 сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр СӨХ-ны хариуцан, үйл ажиллагаагаа явуулж байгаа орон сууцны нэг давхрын болон бусад давхарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үйлчилгээний газар олон байгаа билээ. Тэдгээр нь Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар зохицуулагдахгүй болохыг улсын дээд шүүхээр тогтоож өгсөн байна. Энэ нь нийтийн зориулалттай орон сууцны барилгад үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, иргэдийн эрх ашигт шууд хамааралтай байх бөгөөд цаашлаад орон сууцанд амьдарч буй СӨХ-ны гишүүдийн эрх ашигт ч нөлөөлөх шүүхийн шийдвэр юм.

Энэхүү судалгаагаар нийтийн зориулалттай орон сууцанд аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж сууц өмчлөгчдийн холбооны гишүүн биш болохыг энэхүү тогтоолоор болон бусад тогтоолоор дээд шүүх шийдвэрлэсэн байна.

Дээд шүүх орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардал хуваарилах маргааныг нэг талдаа шийдэж байгаа боловч Иргэний хууль болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар орон сууцанд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэд СӨХ-ны гишүүн биш тул эдгээр иргэд, аж ахуйн нэгжээс хэрхэн яаж дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардлыг гаргуулах талаар Иргэний хуульд, аль эсвэл Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль болон Орон сууцны тухай хуульд нарийвчлан тусгах шаардлагатай.

Социализмын үед хувийн өмчийг бүрэн хүлээн зөвшөөрдөггүй, хувиараа аж ахуй бизнес эрхлэхийг хориглодог байсан тул тухайн үед нийтийн зориулалттай орон сууцны нэг давхрын зориулалтыг өөрчлөн

¹⁰ <https://ikon.mn/n/1q9e> сүүлд үзсэн 2019 оны 11 сар.


бизнес эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан. Улмаар 1992 оны шинэ Үндсэн хуулиар хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, иргэн хүн чөлөөтэй бизнес эрхлэх, хувиараа аж ахуй эрхлэх боломж бүрдсэн. Үүний дараа 1996 онд “Орон сууц хувьчлах тухай хууль” батлагдаж, иргэн хүн хувийн орон сууцтай болох нөхцөл нь бүрдсэн. Нэгэнт орон сууц хувийн өмч болсон тул орон сууцны дундын өмчлөлийн харилцааг зохицуулсан шинэ хууль батлах шаардлага тулгарсан.

Тухайн цаг үеийн нөхцөл байдлын үүднээс авч үзвэл, нийтийн зориулалттай орон сууц нь зөвхөн оршин суух зориулалттай л байсан бөгөөд энэ ч үүднээс “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль”-ийг зөвхөн орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай харилцааг зохицуулах гэсэн үзэл санааны үүднээс хууль тогтоогчид тус хуулийг баталсан байх талтай. Тус хууль нь 2003 онд батлагдсан юм.

Түүнээс хойш эдийн засаг хэдэн арав дахин тэлж, бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэж, үүнийгээ дагаад бизнес эрхлэгч, хувиараа аж ахуй эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулах ажлын байр, оффисын хэрэгцээ шаардлага өсөх нь зүй ёсны үзэгдэл. Иймд хамгийн хялбар аргаар, зардал багатайгаар энэ асуудлыг шийдвэрлэх арга зам нь нийтийн зориулалттай орон сууцны нэг давхрын зориулалтыг өөрчлөн үйл ажиллагаа явуулах хэлбэр байжээ.

Одоо ч гэсэн хотын төвийн хуучны барилгын нэг давхар бүхэлдээ үйлчилгээний газар, бизнесийн зориулалттайгаар ашиглагдаж байна. Шинээр баригдаж буй орон сууцны нэг давхар тэр чигтээ үйлчилгээний оффис, түрээсийн талбай болсон. Товчоор дүгнэхэд, нийтийн зориулалттай орон сууцны барилгад иргэд, бизнес эрхлэгч хоёр зэрэгцэн оршиж байна.

Гэтэл орон сууцны барилгад зөвхөн оршин суугчид суух, амьдрахаар бодож, энэ үүднээс хийсэн хууль маань одоогийн шинэ төрлийн харилцааг зохицуулахад хуучирсан, нийгэм эдийн засаг, өмчийн харилцаагаа даган өөрчлөгдөж чадалгүй хоцорчээ. Иймд “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах, цаг үе, нийгмийн харилцаанд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага тулгамдсан асуудал болж байна.



ISBN 978-9919-9645-4-2



9 789919 964542